

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА

Сургалтын гарын авлага

1



Хувийн аж ахуй
эрхлэх эрхтэй



Сайн дураараа
эвлэлдэн нэгдэх эрхтэй



Шашин шүтэх, эс шүтэх
эрхтэй



Тайван жагсаал
цуглаан хийх эрх
чөлөөтэй



Эд, мөнгөний тусламж
авах эрхтэй



Гадаадад явах, оршин
суух, эх орондоо буцаж
ирэх эрхтэй



Эрүүл, аюулгүй орчинд
амьдрах эрхтэй



Соёл, урлаг, шинжлэх
ухааны үйл ажиллагаа
явуулах, бүтээл туурвих,
үр шимийг нь хүртэх
эрхтэй



Сонгох, сонгогдох
эрхтэй



Шударга шүүхээр
шүүгэх эрхтэй



Улс төр, эдийн засаг, нийгэм
соёлын амьдрал, гэр
бүлийн харилцаанд
тэгш эрхтэй



Улсынхаа нутаг дэвсгэрт
чөлөөтэй зорчих
эрхтэй



Сурч боловсрох
эрхтэй



Амьд явах эрхтэй



Мэдээлэл хайх,
хүлээн авах эрхтэй



Өмчлөх эрхтэй



Өмгөөлөх, өмгөөлүүлэх
эрхтэй



Хууль зүйн тусалцаа
авах эрхтэй



Итгэл үнэмшилтэй байх,
үзэл бодлоо чөлөөтэй
илэрхийлэх эрхтэй



Төрийг удирдах хэрэгт
оролцох эрхтэй



Ажил мэргэжлээ чөлөөтэй
сонгох, хөдөлмөрийн аятай
нөхцөлөөр хангуулах
эрхтэй



Халдашгүй чөлөөтэй
байх эрхтэй



Эрүүл мэндээ хамгаалуулах,
эмнэлгийн тусламж авах
эрхтэй



Өв залгамжлуулах
эрхтэй



Түр буюу байнга оршин
суух газраа сонгох
эрхтэй



Эрүү шүүлтээс ангид
байх эрхтэй



Төрийн байгууллага, албан
тушаалтанд өргөдөл,
гомдлоо гаргаж
шийдвэрлүүлэх
эрхтэй

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

HUMAN RIGHTS BASED APPROACHES
A TRAINING MANUAL

ЦУВРАЛ

1

Хүний эрх, эрх чөлөөг
орон даяар, цаг ямагт, хүн бүрт

ДАА 340
ННА 67
Х-828

Сургалтын гарын авлагыг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажилтнууд боловсруулж, Комиссын гишүүн, Хууль зүйн ухааны доктор, профессор П.Оюунчимэг хянан тохиолдуулав.

Энэхүү сургалтын гарын авлагыг Швейцарийн Хөгжлийн Агентлагийн "Тогтвортой бичил уурхай" төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.

Цаасны хэмжээ: А4
Хэвлэлийн хуудас: 13 хх
Хэвлэгдсэн тоо: 500 ш

"ЭКИМТО" ХХК-д хэвлэв.

ISBN 978-99973-43-88-8

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГЫН АЧ ХОЛБОГДОЛ

Аливаа улсын төр хүний эрхийн асуудлаар үүрэг хүлээдэг бөгөөд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын ажилтан, алба хаагчид хүний эрхийн ойлголттой, хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйгээр үйл ажиллагаагаа явуулах хэрэгцээ шаардлага бий болж байна.

Хүний эрх ба хөгжил хоёр нь харилцан хамаарал бүхий үнэт зүйлс болохын хувьд учир шалтгаант холбоогоор холбогддог. Хүний эрх болон хөгжлийн хоорондын хамаарал нь Хүний хөгжлийн хандлага, НҮБ-ын Хөгжих эрхийн тунхаглал, Мянганы хөгжлийн зорилтууд, Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан байдаг. Эдгээр баримт бичгүүд нь хүний эрх ба хөгжлийн хоорондын харилцан хамаарлыг чухалчлан үзэхийн хамт олон улсын болон үндэсний хөгжлийн бодлогод тусгахыг эрмэлздэг. Мөн иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засгийн болон соёлын ямар нэгэн эрхийг эдлэх боломжгүй байх нь хөгжилд тулгарч буй бэрхшээл саад мөн болохыг онцлон үзсэн байдаг. Эцэст нь хэлэхэд, хүний эрх болон хөгжлийн хоорондын нэгдмэл чанарт үндэслэсэн эрхэд суурилан хөгжих хандлага, түүний үнэт зүйлсийг чухалчлан үзэх байдал нэмэгдэж байна.

Энэхүү сургалтын гарын авлагад хүний эрх болон хөгжлийн хоорондын хамаарал, уялдаа холбооны талаарх хэлэлцүүлгийг хөндөж байна. Дээр дурдсанчлан, хөгжил нь хүний эрхийн үзэл санаа, эрх чөлөөт байдал дээр үндэслэх ба эргээд түүнийг түгээн дэлгэрүүлэх, хангах, хамгаалах баталгаа, суурь нь болж өгдөг. Хөгжлийн мөн чанар нь хүмүүс эрүүл, зөв мөн бүтээлчээр амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх явдал юм. Тийм учраас хүний хөгжил гэдэг нь аливаа үндэстний орлогын хэмжээ өсөх, буурахаас илүү өргөн дэлгэр, гүн гүнзгий агуулгатай юм.

Эрхэд суурилан хөгжих хандлага нь хүний эрхийг хангах, хамгаалах зорилго бүхий олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн хөгжлийн тухай үзэл баримтлал юм. Эрхэд суурилан хөгжих хандлагын хамгийн чухал ач холбогдол нь хөгжлийн төвд хүнийг тавьж үзэхийн хамт хөгжлийн хамтын ажиллагааны зорилго хийгээд үр дүнгийн шалгуур нь хүний эрхийг хангах явдал хэмээн үздэгт оршино. Тиймээс хүний оршин амьдарч буй улс нийгэм, дэлхий нийтийг энх амгалан байлгаж, амьдралын чанарыг сайжруулах зорилгод хүрэх нь эрхэд суурилсан хөгжлийн хандлагын гол үнэт зүйл юм.

Эцэст нь хэлэхэд НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар асан Мэри Робинсоны хэлсэнчлэн “хүний эрх болон хөгжил хоёрыг тусад нь ярих бус харин энэ хоёрын нэгдмэл чанарыг хангах нь” дэлхий нийтийн хамгийн чухал үнэт зүйл байх бөгөөд энэ нь сургалтын гарын авлагын үзэл санаа байх болно.

Сургалтын гарын авлагын дагуу суралцагч бүр хүний эрхийн асуудлыг өөрийн хэрэгжүүлж буй чиг үүрэгтэй холбон авч үзэх мэдлэг, чадвараа хөгжүүлэх, үйл ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг ашиглан явуулах дадлыг төлөвшүүлэх, аливаа үйл хэрэгт хүний эрхийн үнэт зүйлс, зарчмуудыг нэвтрүүлэх замаар нийгмийн эерэг өөрчлөлтөд өөрсдийн зохих хувь нэмрээ оруулах явдал юм.

СЭДЭВ 1: ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ: ЗАРЧИМ, АНГИЛАЛ.....	5
СЭДЭВ 2: ХҮНИЙ ЭРХИЙН ТҮҮХЭН ТОВЧООН.....	19
СЭДЭВ 3: ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ТӨРИЙН ҮҮРЭГ.....	26
СЭДЭВ 4: ХҮНИЙ ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ.....	36
СЭДЭВ 5: ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ.....	46
СЭДЭВ 6: ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН МЕХАНИЗМ.....	53
СЭДЭВ 7: ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ.....	64
СЭДЭВ 8. ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛАН ХӨГЖИХ ХАНДЛАГА.....	80
СЭДЭВ 9. ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛАН ХӨГЖИХ ХАНДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ.....	91

Дасгал

1. Дасгал. Шинэ гариг 14
2. Дасгал. Динамика (эрх мэдлийн алхалт) 34
3. Дасгал. Нийгмийг өөрчлөхдөө хүний эрхийн асуудлыг анхаарах нь
4. Дасгал. Хүний эрхийн зөрчил сэдвээр Оюуны зураглал хийх нь
5. Дасгал. НҮБ-ын хүний эрхийн тогтолцооны тойм
6. Дасгал. Хүний эрхийн олон улсын гэрээнүүд болон механизмын үндсэн шинж 65
7. Дасгал. Орон сууцтай байх эрх ба албадан нүүлгэлт
8. Дасгал. Эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эрх
9. Дасгал. Нэгэн хотын түүх
10. Дасгал. Тогтолцоог нэгтгэх нь

СЭДЭВ 1:

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ: ЗАРЧИМ, АНГИЛАЛ

Зорилго

Энэ бүлгийн хүрээнд суралцагчид хүний эрхийн үндсэн ойлголт, мөн чанар, хүний эрхийн үзэл санаа үүсэж хөгжсөн түүхтэй товч танилцах болно.

Хүн төрөлхтөний ам бүлийн гишүүн хэн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнийг иш үндэс болгон...

"Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой".

(Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын Оршил, 1 дүгээр зүйл)

Хүний эрх нь хүнд төрөхөөс заяагдсан эрхүүд юм. Хүний эрх нь хүний эрхэм чанар, хүний үндсэн эрх, эрх чөлөөнд харшлах үйлдлээс хувь хүн болон аливаа бүлгийг үндэсний, олон улсын хуульчилсан хэм хэмжээгээр хамгаалах байдал юм. Өөрөөр хэлбэл хүний эрх бол таныг хүний зэрэгтэй, нэр төртэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа гэж хэлж болно.

Хүний эрхийг нэг мөр шууд тодорхойлоход ихээхэн бэрхшээлтэй байдаг. Хүний эрхийн олон улсын гэрээ, тунхаглал зэрэгт ч “хүний эрх”-ийн тухай санал нэгдсэн тодорхойлолт байхгүй бөгөөд хүний эрхийн онолын ном, сурах бичгүүдэд мөн л “хүний эрх”-ийг нарийвчлан тодорхойлоогүй байдаг. Мөн хүний эрхийн үүслийн талаар асуувал олон янзын хариулт гарна. Гэхдээ хүний эрхийн тухай авч үзэхэд дараах үндсэн хоёр асуултад хариулах шаардлагатай.

- Хүний зэрэгтэй хүн байна гэж юуг ойлгох вэ?
- Хүний үнэ цэнэтэй амьдралаар амьдарна гэдэгт юуг ойлгох вэ?

Хүн төрөлхтөн дээрх асуултын хариуг олохоор олон төрлийн шинжлэх ухаан, философи зэрэг мэдлэгийн тогтолцооноос эрэлхийлсээр байна. Ингэхдээ хүний зэрэгтэй хүн байх, үнэ цэнэтэй амьдралаар амьдрах гэдэг нь хүн бүрийн салшгүй мөн чанар буюу “хүн байх”, “хүний эрхэм зэрэг” “эрхэмсэг оршихуй”-гаас үүдэлтэй гэж тайлбарладаг. Эдгээр нь хүний зөвхөн зарим нэг шинжийг бүхлээр нь бус харин хүнийг бүхэлд нь буюу хүний өөрийнх нь оршихуй, хувь хүний мөн чанарыг хөнддөг цогц тайлбарыг шаарддаг байна.¹

Хүний эрхийн үзэл санаа нь хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн үр дүнд буй болсон билээ. Өнгөрсөн цаг үед хүний эрх гэсэн ойлголтыг бүрэн утгаар нь ярьдаггүй байлаа. Зарим сургаал номлол, шашин, соёл, гүн ухааны үзэл санаануудад хүний эрхийн тухай үзэл санаа олон хэлбэрээр тусаж ирсэн ч энэ нь бүх дэлхий дахинаа түгэн дэлгэрч, хүлээн зөвшөөрөгдөх, сахин биелүүлэхэд учир дутагдалтай байсаар ирсэн. Үүний дараа хүмүүс тодорхой эрх чөлөөг эдлэх ёстой гэсэн үзэл санаагаа нэгтгэх болжээ. Дэлхийн II дайны үеэр амссан зовлон, гамшигт тулгуурлан дайны аюул занал, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхийн тулд Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) гэх баримт бичгийг бололвсруулан, бүх хүн эдлэх ёстой суурь эрх, эрх чөлөөг даян дэлхийд тунхаглан баталгаажуулсан байна.

¹ Сургагч багшийн гарын авлага, Ази Номхон далайн бүс нутгийн чуулган, Манила, Филиппин, 2012 он

Өнөө цагт хүний эрх нь бүх улс үндэстэн, ард түмний хувьд нийтлэг үнэт зүйлс, зайлшгүй даган мөрдөх хэм хэмжээ болон хүлээн зөвшөөрөгдсөн тул улс үндэстнүүд хүний эрхийн мөн чанар, үндсэн агуулгыг хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ, үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж байна. Өнөөгийн даян дэлхийн хөгжлийн гол оролцогчдын нэг болох Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ) нь дөрвөн үнэт зүйлсийг эрхэмлэдэг. Эдгээр нь аюулгүй байдал, хөгжил, хүний эрх мөн хүрээлэн буй орчин юм. Ялангуяа дэлхийн I, II дайны улмаас тухайн үеийн дэлхий дахины хамгийн чухал зорилго нь энх тайванч байх, хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх, дайнд сүйрч, доройтсон улс орнуудыг сэргээн босгох явдал байсан тул НҮБ-ын Дүрэмд тусгалаа олсон гэж үздэг.

Хүний эрх хэнд хамаарах вэ?

Хүн бүрт хамааралтай. Өөрөөр хэлбэл, хүн бүр ямар ч ялгаваргүйгээр эрх, эрх чөлөөгөө эдлэх ёстой. Хүний эрх түгээмэл учраас дэлхийн хаана ч ижил дээдлэгдэх учиртай.



Хүний эрхийн зарчмууд

Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхийн тулд мөрдлөг болгох зарчмуудыг томъёолж ирсэн. Энэхүү зарчмыг амьдралд мөрдлөг болгох, бодит утгаар нь хэрэгжүүлэх нь хүн бүр эрх эрх чөлөөгөө сэтгэл хангалуун эдэлж, эрхэмсэг оршихуйн баталгаа болох ёстой.

1993 онд Австрийн Вена хотод зохион байгуулагдсан Хүний эрхийн Дэлхийн хоёрдугаар бага хурлаар хүний эрхийн тулгуур шинжүүд буюу зарчмуудыг “Венийн тунхаглал буюу үйл ажиллагааны хөтөлбөр”-өөр улс орнууд санал нэгтгэйгээр баталжээ. Үүнд дараах зарчмуудыг батлан тунхагласан билээ.

ХҮНИЙ ЭРХИЙН СУУРЬ ЗАРЧМУУД

Тэгш байх

Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.

Ялгаварлан гадуурхахгүй байх

Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал болон бусад статусаас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй.

Түгээмэл, салшгүй байх

Хүн оршин байгаа цагт эрхийг хүнээс тусгаарлах, салгах боломжгүй бөгөөд хүнээс салшгүй ойлголт юм.

Энэ дэлхийн аль ч өнцөгт байгаа аливаа эмэгтэй, эрэгтэй хүн, хүүхэд нь хүний төрлийг олж төрсний хувьд хүний эрхийг эдлэгч болдог. Тиймээс хүний эрх нь ертөнцийн өнцөг, булан бүрт амьдарч байгаа хүн бүрт хамаатай. Иймд бүх хүн аливаа ялгаваргүйгээр тэгш хүртэх түгээмэл шинж чанартай.

Хүн үнэ цэнэ, нэр төртэй байх

Хүний үнэ цэнэ, нэр төр нь бүх хүмүүс хүн болж төрснийхөө хувьд ижил үнэлэгдэж, адил хүндлэл хүлээнэ гэдгийг баталгаажуулдаг. Бүх хүн нас, соёл, угсаа гарал, арьс өнгө, хүйс, бэлгийн чиг баримжаа, хэл, боломж чадвар, нийгэмд эзлэх байр суурь, иргэний харьяалал болон улс төрийн үзэл бодлоос үл хамааран ижил хүндлэлийг хүлээнэ.

Хуваагдашгүй байх

Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл, хуваагдашгүй байдаг.

Харилцан хамааралтай байх

Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрт, амьдралын бүхий л хүрээг хамардаг. Өөрөөр хэлбэл аль нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө, нөгөө талаар нэг төрлийн эрхийг хангах явдал сайжрахад өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг.

Хариуцлага тооцох

Төртэй хариуцлага тооцох

Хүний эрхийг төр өөрийн үзэмжээр өгдөггүй. Төр нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангахаас татгалзах, эсхүл хэсэг хүмүүсийн эрхийг хүндэтгэж, хамгаалж, хангаад бусад хүмүүсийн эрхээс татгалзах ёсгүй.

Хувь хүнтэй хариуцлага тооцох

Хүн бүр хүний эрхийг хүндэтгэх болон хүний эрхийг зөрчдөг байгууллага, хүмүүстэй тэмцэх үүрэгтэй.

Бусад этгээдтэй хариуцлага тооцох

Корпорацууд, Төрийн бус байгууллагууд, сангууд, боловсролын байгууллага зэрэг нийгмийн бусад бүх хэсгүүд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үүргийг хүлээнэ.

Хүний эрхийн зарчмуудыг мөрдлөг болгох нь

Эдгээр зарчмуудыг нэг мөр ойлгож, түүнийгээ хэлбэрэлтгүй баримтлах нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах үйлсэд зайлшгүй чухал билээ. Дээр дурдсан тэгш байх хэмээх зарчмын гол мөн чанар бол хууль ёсны тэгш байдлыг бодит тэгш байдал болгоход чиглэдэг. “Хүн бүр тэгш эрхтэй” хэмээх томъёоллыг бид олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичгүүд, төсөл хөтөлбөрөөс хаанаас л бол хаанаас олж харах боломжтой. Харин амьдрал дээр тэгш байх зарчим бодитой хэрэгжиж байгаа эсэхийг тэр бүр анхаарч үздэггүй. Тэгш байх зарчмын амин сүнс бол тэгш боломж юм. Учир нь хүмүүс боловсрол, хүйс, хөрөнгө чинээ, нийгэмд эзлэж байгаа байр суурь гэх мэт олон зүйлээрээ өөр хоорондоо ялгаатай. Нөгөө талаас социализмын үед мөрөөдөж байсан шиг бүх хүмүүсийг адил түвшинд байлгах боломжгүй. Тиймээс хүний эрхэд суурилсан хандлагын үүднээс бол (тэгш боломжийг) ялгаварлагдсан, гадуурхагдсан, нийгмийн цөөнх болсон, улс төр, эдийн засгийн эрх мэдэл багатай хүмүүс байгаа хэсэгт л анхаарлаа хандуулах учиртай. Тухайлбал, ядуу өрхийн хүүхэд их дээд сургуулийн элсэлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд, төрөөс суралцах боломжоор хангахыг хэлнэ. Дээд боловсролын тухай хуульд “...Өнчин, хөгжлийн бэрхшээлтэй болон амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн болон бусад шаардлагатай суралцагчид тэтгэлэг, буцалтгүй тусламж, сургалтын төлбөрт зориулан хөнгөлөлттэй зээл олгоно...”² хэмээх хуулийн зохицуулалт байдаг. Энэ нь эдгээр бүлгийн хүмүүсийн тэгш эрхийг хуулийн хүрээнд баталгаажуулсан заалт юм. Тэгвэл хуулийн энэ заалт хэрхэн хэрэгжиж байгаагаар тэгш байх зарчмыг хэмжих боломжтой.

² Дээд боловсролын тухай хууль, 19.2-р зүйл, 2002 он, www.legalinfo.mn (2011.01.15)

Хүний эрхийн ангилал

Хүний эрхийг ангилах олон шалгуур байдагтай уялдаж ангилал тус бүр өөрийн онцлогтой байдаг. Хүний эрхийг шинжлэх ухааны судлагдахууны хувьд олон шалгуураар ангилан авч үзэх нь ач холбогдолтой юм. Олон янзын ангиллаас хамгийн түгээмэл ангиллаас дурьдвал:

Нэгдүгээрт, мөн чанар (уг гарвал) талаас нь

1. Хүний жам ёсны эрх,
2. Хүний зүй ёсны эрх гэж хувааж байна.

Хүний жам ёсны эрх гэдэг нь байгалиас заяасан хүний амьдрах, үр удамтай байх эрх зэрэг хүнийг байгалийн бүтээгдэхүүн учраас түүний төрөлхийн заяамал хэрэгцээнээс эх үндэстэй, бичигдээгүй хуулиар зөвшөөрөгдсөн зан үйлийн боломж юм. Жам ёсны эрх гэдэг нь төрөөс тогтоож болохгүй эрхүүд болно. Хүний жам ёсны эрхэд хүний амьд явах, амьдрах, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, халдашгүй чөлөөтэй байх, гэр бүл, үр хүүхэдтэй байх зэрэг эрх хамаарна.

Хүний зүй ёсны эрх гэдэг нь нийгмийн хэрэгцээнээс үүдэлтэй бөгөөд зайлшгүй хуульчлан зохицуулах шаардлагатай эрх юм. Өөрөөр хэлбэл түүний хүрээ, хязгаарыг төрөөс тогтоож, баталсан байдаг. Ийм эрхэд сурч боловсрох эрх, сонгох сонгогдох эрх, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах, эвлэлдэн нэгдэх, бүтээл туурвих, эд мөнгөний тусламж авах зэрэг эрх хамаарна.

Хоёрдугаарт, түүхэн хөгжил талаас нь ангилж болно. Түүхэн хөгжил талаас нь эртний сэтгэгчдээс эхэлж болох боловч нөгөөтэйгүүр хүний эрхийн хөгжлийг Үндсэн хуульт ёсны түүхтэй холбоотой авч үзэх утгаар нь түүхийн 3 үед хуваан авч үздэг.

Үүнд:

1. Нэгдүгээр үе: XVIII зууны сүүл үеэс XX зууны 50-иад он хүртэл

Энэ үед ардчилал, тэгш эрх, хүний эрх, эрх чөлөөний үндэслэл, Үндсэн хуулиудад тусгагдаж эхэлсэн байна. Сонгох, сонгогдох, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаан хийх, боолчлолоос ангид байх зэрэг улс төрийн эрх чөлөөний суурь тавигдсан бөгөөд хувьдаа байр орон сууцтай байх, өв залгамжлах, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, цалин хөлс авах зэрэг эрхийн тодорхой хүрээ бий болжээ.

2. Хоёрдугаар үе: XX зууны 50-иад оноос XX зууны 90-ээд он.

Сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, бүтээл туурвих, шашин шүтэх, эс шүтэх, тэтгэвэр тэтгэмж авах гэх мэт эрх хангагдах баталгаа бүрэлдэн төлөвшсөн байна. Тухайн үеэс хүний эрх, эрх чөлөөний агуулга, хүрээг олон улсын хэмжээнд анх удаа хуульчлан томъёолж, эрх зүйн зохицуулалтыг бий болгосон.

3. Гуравдугаар үе: XX зууны 90-ээд оны эхэн үеэс эдүгээг хүртэл.

Энэ үед эрүүл аюулгүй орчинд амьдрах, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх, мэдээлэл хайх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах зэрэг эрх биеллээ олж, ихэнх оронд хэрэгжиж эхэлсэн байдаг. Түүнчлэн дэлхий дахинд улс төр, үзэл суртлын системийн ялгаа алга болж, нийтлэг жишиг тогтон, хүний эрхийн хүрээнд бүхэлдээ нааштай өөрчлөлт бодит зүйл болж төлөвшиж байна.

Гуравдугаарт, түүхэн хөгжлийг бүхэлд нь авч үзсэн ангилал.

1. Нэгдүгээр үеийн эрх,
2. Хоёрдугаар үеийн эрх,
3. Гуравдугаар үеийн эрх

Нэгдүгээр үеийн эрхэд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан эрхүүд багтах юм. Харин манай улсын 1992 оны Үндсэн хуульд заасан эрхүүдээс авч үзвэл амьд явах эрх, чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох, гадаадад зорчих, цагаачлах, эх орондоо эргэж ирэх, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нам, олон нийт бусад байгууллага байгуулах зэрэг эрхийг дурьдаж болно.

Хоёрдугаар үеийн эрх нь гол төлөв нийгэм эдийн засгийн шинжтэй эрх байх бөгөөд Үндсэн хуулиас авч үзвэл ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрх, өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрх, сурч боловсрох эрх, соёл урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрх зэргийг дурьдаж болно.

Гуравдугаар үеийн эрх буюу даяарчлал, олон улсын хамтын ажиллагаа, дэлхий нийтийн өмнө тавигдаж байгаа зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудлуудтай уялдаатай орчин үед гарч ирсэн эрхүүд юм. Тухайлбал, хамтын эрх, бүлгийн эрх, байгаль орчноо хамгаалах эрхүүд хамаардаг байна.

Яагаад заавал эрхийг эдгээр ангиллаар ангилах болсон бэ? гэсэн асуулт урган гарч ирж болох юм. Нийгэмд нийтлэг ашиг сонирхол, нийтлэг бэрхшээлтэй олон бүлэг байж болно. Тухайлбал, эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, үндэсний цөөнх, бэлгийн цөөнх гэх мэт. Харин эдгээр бүлэг хүмүүс нь нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, арьс үндэс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон бусад үндэслэлээс үл хамааран бусдын нэг адил эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх ёстой. Гэтэл амьдрал дээр эдгээр бүлгүүдийн олонх нь эрх, эрх чөлөөгөө бодитой эдлэхэд саад бэрхшээл тулгарч байдаг. Тиймээс эдгээр бүлгүүдэд бусдын нэг адил эрхээ эдлэх тэгш бололцоог олгох үүднээс тэдэнд онцгой анхаарал хандуулах шаардлага тулгардаг. Тухайлбал, хүн амын 50 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа ч шийдвэр гаргах түвшинд тэдний дуу хоолой туйлын бага байгаагийн улмаас жендэрийн мэдрэмжгүй бодлого шийдвэр гарч эцэст нь эмэгтэйчүүд өөрсдөө хохироход хүрч байна. Энэ тохиолдолд эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийн асуудлыг зайлшгүй ярих болдог. Энэ мэтчилэн тодорхой бүлгийн эрхийн асуудлыг тодотгон авч үзэж, тэдний эрх ашгийг хамгаалах нь ардчилсан төрийн зайлшгүй хийх ажил юм. Учир нь тодорхой бүлэгт хамаардагийн хувьд ялгаварлан гадуурхагдаж, улмаар хүний эрх, эрх чөлөөгөө бусдын адил эдэлж чадахгүй байх тохиолдол түгээмэл гардаг.

Хамтын эрхийн асуудал

Нийгэм, нийт хүн төрөлхтөний амьдрал, сайн сайхан байдалтай холбоотой энх тайван, байгаль орчин зэрэг түгээмэл асуудлуудын хүрээнд хамтын эрхийг авч үздэг. Түүнчлэн хамтын эрхийн хүрээнд ард түмний өөртөө засан тогтнох эрх, байгалийн нөөц баялгийн зарцуулалтыг хянах, хөгжих эрх, зарим тохиолдолд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудлыг хамруулдаг. Эдгээр бүлэг эрхийг 3 дахь үеийн эрх буюу хөгжих эрх ч гэж томъёолдог.

Хамтын эрхийн асуудал нь олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгалаа олсон байдаг. Тухайлбал, уламжлалт газар нутаг дээрх уугуул ард түмний эрхийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 169 дүгээр конвенц, өөртөө засан тохинох эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 1 дүгээр зүйл, хөгжих эрхийн асуудлыг Хөгжих эрхийн тунхаглал зэрэг баримт бичигт тус тус заасан. Хамтын эрх, хувийн эрхийн харилцан хамаарлыг хүний эрхийн бүс нутгийн зарим тогтолцоонд тод томруун тусгасан байдаг. Тодруулбал, Хүний болон ард түмнүүдийн эрхийн Африкийн Хартид “...өөрийн улс төр, нийгэм, эдийн засгийн чиг хандлагыг тодорхойлох ард түмний бүрэн эрх зөрчигдөөгүй тохиолдолд тухайн улсын иргэд улс төр, иргэн, нийгэм, соёл, эдийн засгийн эрх, эрх чөлөөгөө эдлэх нөхцөл бүрдэнэ...” хэмээн заасан байна. Хамтын эрхийг хүндэтгэн, хангаж, хамгаалах нь хувийн эрхийн эдлэх нөхцлийг бүрдүүлнэ гэсэн санаа юм. Тухайлбал, хөгжих эрхийн хүрээнд “хүн хөгжлийн төвд байх ёстой бөгөөд хөгжлийн үйл явцад идэвхтэй оролцож, түүний үр шимийг хүртэгч байх ёстой” гэж үздэг. Тиймээс хөгжих эрхийг баталгаажуулснаар тодорхой бүлгийн эрхүүд хамгаалагдаад зогсохгүй, хүн бүр эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх нэг чухал нөхцөл болно.

Бүлгийн эрхийн асуудал

Бүлгийн эрхийн хүрээнд хүүхэд, ахмад настан, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ХДХВ, ДОХ-той амьдарч буй хүмүүс, цагаач иргэд, дүрвэгсэд, үндэстний цөөнх, дотоодын шилжин суурьшигсад, бэлгийн цөөнх гэх мэт тодорхой нийтлэг шинжээр холбогдсон бүлэг хүмүүсийн асуудлыг авч үздэг. Тухайн бүлгүүдэд тулгамдаж байгаа нийтлэг асуудлаас хамааран хүний эрх, эрх чөлөөгөө эдлэхэд хүндрэл учирч байдаг. Гэвч бүлгийн эрхийн хүрээнд хүний эрхийн цоо шинэ асуудлыг авч үздэг үү гэвэл үгүй юм. Харин түгээмлээр хамгаалагдсан эрхүүд нь тэдгээр бүлгүүдийн хувьд бусад бүлгүүдтэй харьцуулахад нийтлэг зөрчигдөх байдал гарсны улмаас үүнийг засч залруулахын тулд тухайн бүлгийн хүний эрхийн асуудалд анхаарал хандуулах шаардлага тулгардаг.

Хүний эрхийн хэрэгжилтийг хангаж, хамгаалахын тулд тодорхой бүлгүүдийн эрхийн хэрэгжилтэд илүү анхаарал хандуулах ёстой. Учир нь тухайн бүлгүүдийн эмзэг байдал нь бусадтай адил эрхээ бүрэн дүүрэн эдлэхэд нь саад учруулдаг. Тухайлбал, өнөөдөр манай улсад дэд бүтцийн салбар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй биш байна. Олон улсын түвшинд тухайн улсын хүн амын 10 хувиас доошгүй нь хөгжлийн бэрхшээлтэй байдаг хэмээн үздэг бөгөөд манай улсын ажиллах хүчний арав орчим хувийг эзэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс баялаг бүтээгээд, өөрсдийнхөө амьдралыг цогцлоож явахын оронд хэн нэгний гар харан суухад хүрч байна.

Олон иргэд, төрийн албан хаагчид эдгээр бүлэг хүмүүсийг тэтгэвэр, тэтгэмж аваад л гэртээ сууж байх ёстой гэж үздэг, их сайндаа өгдөг жаахан мөнгийг нь нэмээд өгвөл сайнсан гэж бодохоос хэтрэхгүй. Гэтэл яагаад энэ хүмүүс бидэнтэй адил хөдөлмөрлөөд, нийгэмдээ хувь нэмрээ оруулаад явж болохгүй гэж. Өөрөө өөрийнхөө төлөө өөрсдөө санаа тавья гээд байхад нь яагаад бид заавал үгүй ээ, заавал чамайг үүрээд явна гээд байгаа билээ. Нөгөө талаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрх нь зөрчигдөж, нийгмээс гадуурхагдсан бүлэг тул тэдний эрхийг бодитойгоор эдлүүлэхийн төлөө төр тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ үүргээ төр ямар нэг байдлаар хэрэгжүүлж байгаа ч хэрэгжилт нь хэр үр дүнтэй байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс үр шимийг нь жинхэнэ утгаараа хүртэж чадаж байна уу гэдэгт л анхаарал хандуулах нь зөв юм.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхүүдийг улс төр, эрх зүйн шалгуураар ангилж болно. Үүнд:

1. Нийгэм эдийн засгийн эрх
2. Улс төрийн эрх, эрх чөлөө
3. Хувийн эрх, эрх чөлөө

НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ

1. Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрх

Хүн хэрэгцээгээ хангахын тулд:

- Амьдрал үйл ажиллагаандаа шаардлагатай зүйлс, байр сууц, машин техник, мөнгө, үнэт цаас гэх мэт өмчтэй байх,
- Тэдгээрийг зориулалтын дагуу хэрэглэхшиглах, өөрийн мэдэлд байлгах, захиран зарцуулах,
- Нас барах буюу хүндэтгэн үзэх шалтгаан тохиолдсон үед үр хүүхэд, хууль ёсны төлөөлөгчдөд гэрээслэлээр өвлүүлэх,
- Өмч хөрөнгөө үнэлэх, худалдах, хадгалж хамгаалах зэрэг эрхтэй болно.

2. Ажил мэргэжлээ сонгох эрх

Монгол Улсын иргэн нь:

- Сонирхол, хүсэлтээрээ ямар ч мэргэжлийг чөлөөтэй сонгох, эзэмших,
- Мэргэжлийнхээ дагуу улсынхаа аль ч нутаг дэвсгэрт, байгууллага, албан газарт хуулийн хүрээнд ажил хөдөлмөр эрхлэх,
- Мэргэжлийнхээ ажил үүргийг ямар нэгэн хязгаарлалтад автахгүйгээр сонгон гүйцэтгэх эрхтэй,

3. Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх

Хүн нэгэнт ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол

- Хэвийн бөгөөд эрүүл, аюулгүй орчинд ажиллах боломжоор хангагдах,
- Хангагдаагүй бол нөхцөлөө сайжруулах шаардлага тавих,
- Тухайн орчин нөхцөл нь ажлын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэгдсэн байх зэрэг хүсэлт гаргах эрхтэй,

4. Цалин хөлс авах эрх

Монгол Улсын иргэн хэн боловч:

- Мэргэжлээрээ болон дадлага туршлагаараа тодорхой ажил эрхэлсэн, эсхүл гэрээгээр болон хувиараа ажил үүрэг гүйцэтгэсэн бол түүнийхээ үр шимийг хүртэх,
- Хийсэн хөдөлмөрийнхөө хэмжээнд нийцсэн цалин хөлс, хангамж, шагнал, урамшууллыг тогтоосон хугацаанд нь авах,
- Өгөгдөөгүй нөхцөлд нөхөн авах боломжоор хангагдах эрхтэй.

5. Амрах эрх

Ажил хөдөлмөр эрхэлж байгаа ямар ч хүн

- Хөдөлмөрийн чадвар бүтээмжийн чадавхиа ямагт дээшлүүлж байх,
- Энэхүү шаардлагыг хангахын тулд 7 хоног, сар, жил тутамд тодорхой хугацаагаар амарч байх,
- Өдөрт ажиллах цагийн дээд хэмжээ, жилдээ амрах өдрийн тоогоор хангагдах,
- Малчдын хувьд ажил амралтын цаг нь тухайн хөдөлмөрийн онцлогоос хамаарч өвөрмөц охицуулалт шаарддаг ч хүний амрах эрхийн ерөнхий зарчимтай тохирч, зохицсон байх,
- Хуулиар тогтоосон баяр ёслолын өдрүүдэд амрах,

6. Хувийн аж ахуй эрхлэх эрх

Монгол Улсын иргэн хэн боловч:

- Хувиараа чөлөөтэй ажил хөдөлмөр эрхлэх,
- Түүнийхээ үр шимийг хүртэх,
- Ажиллах нөхцөл, боломжтой байх эрхтэй

Хувийн аж ахуй эрхлэх эрх нь хувийн өмчтэй байх, түүнийгээ ашиглах, эзэмших, захиран зарцуулах, төдийгүй өв залгамжлуулах, бусдад худалдах зэрэг эрхтэй салшгүй холбоотой.

7. Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй.

Монгол Улсын иргэн хэн боловч:

- Хөдөлмөрийн чадвараа түр алдах, хүүхэд төрүүлэх, эрүүл мэндээрээ хохирох үед ажилладаг байгууллагаасаа тэтгэвэр, тэтгэмж авах, эд мөнгөний болон материаллаг туслалцаа хүсэх,
- Монгол Улсын хууль тогтоомжуудад зааснаар эрэгтэй хүн 60 нас, эмэгтэй хүн 55 нас хүрээд өндөр насны тэтгэвэр авах эрхтэй.

8. Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх

Хүн ямар ч үед

- Эрүүл мэндийнхээ төлөө санаа тавьж, түүнийгээ хамгаалуулах эрхтэй,

- Эрүүл мэндээ хамгаалуулах нь эмнэлгийн тусламж авах, эмчлэн сувилуулах үйлчилгээгээр хангагдах бүрэн боломжтой байх,
- Эрүүл мэндийн даатгалтай нөхцөлд түүний шаардлагад тохирсон эм, тариа, эмнэлгийн анхан шатны үйлчилгээгээр үнэ төлбөргүй хангагдах,
- Эмнэлгийн тусламж үйлчилгээ зарим нөхцөлд төлбөртэй байх боловч тэр нь хүний эрүүл мэндээ хамгаалуулах зүй ёсны шаардлагад нийцсэн байх учиртай.

9. Сурч боловсрох эрх

Аливаа иргэний сурч боловсрох эрх нь

- Бүх шатны сургуульд суралцаж суурь болон мэргэжлийн боловсрол эзэмших,
- Сургуулиа өөрөө сонгох,
- Зохих шаардлага хангахуйц сургалтад хамрагдах,
- Мэдлэг мэргэжлийн түвшингээ дээшлүүлэхэд чиглэгдсэн дэмжлэг тусалцаа авах эрхтэй. Соёл шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл турвих, үр шимийг нь хүртэх эрх Монгол Улсын иргэн хэн боловч:
- Соёлын амьдралд чөлөөтэй оролцох,
- Шинжлэх ухааны болон урлаг, соёл, утга зохиолын бүтээл туурвих, түүнийхээ үр шимийг хүртэх,
- Зохиогчийн эрхээ хамгаалуулах,
- Соёл урлагийн үйлчилгээ, ном, сонин, сэтгүүлээр хангагдах, түүнийг олж авах өргөн боломж, нөхцөлтэй байх эрхтэй.

УЛС ТӨРИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Иргэн хүний нийгэм-улс төрийн эрх, эрх чөлөө бол тухайн хүний нийгмийн идэвх байр суурь, мөн чанарыг илтгэн харуулдаг.

1. Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийн удирдах үйл хэрэгт оролцох эрх.

Төрийн үйл хэрэгт оролцоно гэдэг нь:

- Ерөнхийлөгчийг сонгох, Улсын Их Хурлыг байгуулах, түүний гишүүнийг сонгох, сонгуульд санал өгч оролцох,
- Иргэдийн санал, асуулга, төр засгийн шийдвэрт санал өгөх,
- Хууль, хуульчилсан баримт бичгийн төслийг иргэд нийтээр хэлэлцүүлэх үед санал өгөх эрхийг хэлнэ. Ийнхүү оролцох эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлснээр ардчилал, тэгш эрхийн зарчим бодит биелэл болж, төр, ард түмний эв нэгдлийг бататган тогтоох нөхцөл бүрддэг.

2. Төрийн байгууллагад сонгох сонгогдох эрх.

Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрх, Монгол Улсын иргэд:

- Өөрсдийн улс төрийн болон, нийгмийн ашиг сонирхол, эрх ашгаа харилцан ойлголцох,
- Түүнийгээ нэгтгэн илэрхийлж, хамгаалах зорилгоор улс төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагыг хуулийн дагуу байгуулах эрхтэй.

3. Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрх.

Монгол Улсын иргэн хэн боловч:

- Хүйсээр ялгаварлахгүйгээр хууль шүүхийн өмнө адил тэнцүү эрх эдэлж, үүрэг хүлээх,
- Нийгмийн амьдралын бүхий л хүрээнд адил боломжтой оролцох,
- Өрх гэр, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэйчүүд харилцан бие биеэ хүндэтгэх,
- Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд эрэгтэй, эмэгтэйчүүд хамтдаа хариуцлага хүлээх,

4. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд эрхээ нэгэн адил эдлэх эрхтэй.

Төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрх. Монгол Улсын иргэн:

- Үндсэн эрх, эрх чөлөөг нь зөрчсөн буюу хууль бусаар хязгаарласан тохиолдолд зөрчигдсэн эрхээ сэргээлгэх,
- Үүний тулд өргөдөл, хүсэлт гаргах зэргээр төрийн эрх бүхий байгууллага, албантушаалтанд хандах эрхтэй,

- Түүнийг нь дээрх байгууллага, албан тушаалтан хүлээн авч шийдвэрлэх үүрэгтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан ямар асуудлаар, ямар өргөдлийг, ямар хугацаанд, хэрхэн гаргаж шийдвэрлэх вэ гэдгийг төрийн байгууллагын болон энэ талаар тусгайлан гаргасан хууль тогтоомжуудаар зохицуулсан байдаг.

5. Тайван замаар жагсаал цуглаан хийх эрх.

Монгол Улсын иргэн:

- лс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх хүрээнд улс төрийн жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг эрх чөлөөг эдэлнэ,
- Ингэхдээ хуульд заасан журмыг хатуу баримтлах (зөвшөөрөл, хугацаа) аль болох тайван замаар уг жагсаал цуглааныг хийх зэрэг үүрэг хүлээсэн байна.

ХУВИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ

Иргэдийн үндсэн эрх, эрх чөлөөний дотор хувийн эрх, эрх чөлөө онцгой байрыг эзэлнэ. Хувийн эрх, эрх чөлөө гэдэг нь хүний хувийн амьдрал ахуйн хүрээнд шууд хамааралтай чухал нөхцөл, боломжийг хуульчлан тогтоосныг хэлнэ. Энэ нь зарим талаар хүний жам ёсны эрхтэй салшгүй холбоотой. Энд ихэнхдээ үйл ажиллагааны шинжтэй (байцаан шийтгэх) эрх нилээд тусгагдсан байдгаараа онцлогтой.

1. Халдашгүй чөлөөтэй байх эрх.

Халдашгүй чөлөөтэй байх эрх нь:

- Хувийн амьдрал халдашгүй байх,
- Гэр бүл халдашгүй байх,
- Орон байр халдашгүй байх,
- Захидал харилцаа халдашгүй байх гэсэн 4 үндсэн хүрээг хамарна.

2. Шүүхэд гомдол гаргах эрх

Өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх. Энэхүү эрх нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүнлэг, энэрэнгүй байх зарчмын бодит илрэл болдог.

- Эцэг эх, үр хүүхэд, эхнэр нөхөр хоорондын ёс зүйн харилцааг бие биенд нь сөргүүлэн тавихгүй байх,

3. Албан ёсоор нотлогдоогүй асуудалд хүлээцтэй хандах,

- Нотлох баримтыг шалгаруулах болон мэтгэлцэх үндсэн дээр тухайн ажиллагаанд оролцох гэсэн гол агуулгыг илэрхийлдэг байна.

4. Өмгөөлүүлэх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх.

Монгол Улсын иргэн:

- Эрүү, захиргааны хэрэгт холбогдох, иргэний хэрэгт оролцоходоо өөрийн эрх ашгийг хамгаалуулах,
- Үүний тулд хууль зүйн мэргэжлийн зөвлөлгөө, туслалцаа авах,
- Өмгөөлөгчөө өөрөө сонгох,
- Хэрэгт холбогдсон үед чухам ямар үндэслэлээр шалгагдаж байгаагаа мэдэх,
- Өөрийн гэм буруугүй эсэхийг нотлох,
- Ял шийтгэл хариуцлагыг хөнгөрүүлэх, цагаатгах нөхцөл байдлыг хангуулах,
- Өөрийгөө өмгөөлөх замаар тухайн нотлох баримтыг шалгуулах зэрэг эрхтэй.

Хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шударга шүүхээр шүүлгэх эрх. Эрүүгийн болон захиргааны хэрэгт холбогдсон бөгөөд түүний гэм бурууг шүүхээр шийдвэрлэх үед:

- Шүүх хурлын ажиллагаанд биечлэн оролцох,
- Хэрэгт холбогдсон шүүгдэх гэж буй этгээд хүндэтгэх шалтгаан бий болсон үед тухайн шүүгчээс татгалзах (өөр шүүгчээр шүүлгэх),

5. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө.

Монгол улсын иргэн хэн боловч:

- Сүсэглэн бишрэх, шүтлэгтэй байх,
- Аль нэг шашны сүм хийдийн гишүүн байх,
- Шүтлэггүй байж болох, эс шүтэх,
- Ямар нэгэн шашны нөлөөнөөс ангид байх зэрэг эрхтэй.

6. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрх.

Монгол улсын иргэн нийгмийн амьдралд оролцоходоо:

- Өөрийн гэсэн үзэл бодолтой байх,

- Түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх,
- Өөртөө иргэл үнэмшилтэй байх,
- Хурал цуглаанд оролцох оролцох, үг хэлэх, санал хүсэлт гаргах зэрэг эрхтэй.

7. Мэдээлэл хайх, хүлээн авах эрх.

Монгол Улсын иргэн:

- Өөрийн танин мэдэхүйн болон бусад шаардлагатай хэрэгцээгээ хангах,
- Өөрт хэрэгтэй мэдээ, мэдээлэл хайж, түүнийг олж авах, цуглуулах, хүлээн авах,
- Түүнийгээ өөрт ашигтайгаар боловсруулж ашиглах, зүй зохистой хэрэглэх зэрэг эрхтэй. Гэхдээ энэхүү мэдээлэл нь төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарах асуудлаар хязгаарласан байдаг. Мөн түүнчлэн хувь хүн, байгууллагын нууцад хамааралгүй байх шаардлагатай.

8. Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох.

Монгол Улсын иргэн хэн боловч:

- Улсынхаа аль нэг нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин сууж буй эсэхээс үл хамааран нийт нутаг дэвсгэртээ чөлөөтэй зорчих,
- Түр буюу байнга оршин суух газар болон ажиллаж амьдрах байршлаа өөрөө чөлөөтэй сонгох эрхтэй. Харин иргэдийн шилжилт хөдөлгөөн, байршил, харьяаллын нөхцөл журмыг хуулиар тусгайлан зохицуулсан байдаг.

Чиглүүлэгч багшийн нэмэлт мэдээлэл

Та гудамжинд яваа хүмүүсээс “Хүний эрх гэж юу вэ?” Гэж асуувал олон төрлийн хариултуудыг сонсоно. Тэд танд өөрийн мэдэх эрхүүдийн тухай хэлэх боловч маш цөөн хүн л өөрийн бүх эрхийг мэдэх болно.

Хүний эрх нь хувь хүн бүрийг хүндэтгэх зарчимд тулгуурладаг. Хүний эрхэд тулгуур болох ойлголт бол “хүн бүр нэр төртэйгээр харилцах ёс суртахуунтай, оюунлаг бодьгал” юм. Эдгээр нь түгээмэл учраас хүний эрх гэж нэрлэдэг.

Үндэстэн, эсвэл тусгайлан бүлэг зөвхөн тэдэнд зориулсан тодорхой эрхүүдийг эдэлдэг бол хүний эрх нь хэн болох, хаана амьдарч байгаагаас үл шалтгаалан хүмүүс амьд байгаагийн хувьд хүн бүрийн эдлэвэл зохих эрхүүд юм. Гэсэн ч хүмүүсээс өөрийн эрхийг хэлэхийг хүсэхэд олон хүмүүс зөвхөн “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх”, “тайван замаар жагсах цуглах” гэх мэт эрхүүдийг нэрлэж болно. Эдгээр эрхүүд чухал эсэх талаар ямар нэгэн асуудалгүй ч хүний эрхийн хамрах хүрээ нь маш өргөн. Энэ нь сонголт, боломж гэсэн санааг илтгэнэ. Үүнд ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, албан тушаал ахих, өөрийн сонголтоор ханиа сонгох, хүүхдээ өсгөх зэрэг болно. Мөн чөлөөтэй зорчих, шахалт, дарамтгүйгээр хөдөлмөрлөх, дур мэдэн баривчлагдахаас ангид байх ч багтана. Үүний зэрэгцээ амрах эрхийг ч агуулдаг.

Эрхээ мэдэх нь ямар ач холбогдолтой вэ?

Хүмүүс эрхээ мэдсэнээр эрхээ бүрэн дүүрэн эдлэх боломжийг олж авна. Эрхээ зөрчигдөж байна гэдгийг мэдэж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх арга хэмжээ авна. Үүгээр ч зогсохгүй эрхээ зөрчигдөхөөс хамгаалж, түүнд нийцсэн баталгаа бүрдүүлэхийг төрөөс шаардах болно. Эрхээ бүрэн дүүрэн эдэлнэ гэдэг нийгмийн амьдралд идэвхтэй оролцоно гэсэн үг. Таны оролцоо, хяналт улс төрчдийг хариуцлагатай болгож, хууль, төрийн бодлогыг сайжруулж, ингэснээр эрүүл нийгмийг бүтээх боломжтой.

Эрүүл нийгэм биднийг энх тайван, амар амгалан амьдрал, хөгжил, дэвшилд хөтөлнө.

Дасгал (15 минут)

Оролцогчдыг нийт 3 багт хуваан тус бүр 3 эрх дээр тодорхой хугацаа өгч ажиллуулна. Баг бүрээс илтгэгчийг урин бусад багтай өөрийн багийн ажлыг танилцуулна.

Асуулт: Нэг эрх зөрчигдвөл бусад ямар эрхүүд хөндөгдөх вэ? Тухайлбал, цэвэр усаар хангагдах эрх, сурч боловсрох эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдвөл өөр ямар эрх хөндөгдөх вэ? Ямар хор хөнөөл учруулах вэ?

Дасгал (30 минут, хэлэлцүүлэг 30 минут)

“Шинэ гариг” дасгал ажил

Зорилго:

- Дасгалын явцад оролцогчид хоорондоо танилцах
- Хэн нэгэн буюу хэсэг бүлэг хүмүүсийн зүгээс бусдыг хянах эрх мэдэлтэй байгааг оролцогчдод шууд мэдрүүлэх
- Дасгалын явцад юу мэдэрснээ бусадтайгаа хуваалцах
- Дасгалд өгөгдсөн нөхцөл байдлыг амьдарч буй нийгэмтэйгээ харьцуулан хэлэлцэж дүгнэх

Бэлтгэл:

- Шинэ гаригийн эрхийн батламж болон амьдралын картуудыг олшруулж, хайчилж бэлтгэнэ.
 1. *Аюулгүй байх эрхтэй* – Энэ эрх таныг хэнээс ч хамааралгүй, халдашгүй чөлөөтэй, бие махбодын хувьд бүрэн бүтэн байж, гэмтэж, бэртэхээс хамгаалдаг.
 2. *Бусдаар хүндлүүлэх эрхтэй* – Энэ эрх нь таныг давтагдашгүй, цорын ганц гэдгийг хүлээн зөвшөөрч, тантай хүнлэг бусаар харьцах, таныг ялгаварлан гадуурхахаас хамгаалдаг.
 3. *Өөрийнхөө амьдралд хамаатай шийдвэрүүдийг гаргах эрхтэй* - Энэ эрх танд өөрийнхөө амьдралд хамаатай аливаа асуудлаар сонголт хийх, шийдвэр гаргах боломжийг өгдөг. Мөн мөнгө, өмчтэй болоход тань, эсвэл мэдээлэл авахад тань бусдын зүгээс саад хийх явдлаас хамгаалдаг.
 4. *Өөрийн бэлгийн амьдралыг хянах эрхтэй* - Бэлгийн чиг баримжаа чинь ямар байх, хэдэн насандаа хэнтэй бэлгийн харьцаанд орох, хэнтэй гэрлэх, хэдэн жилийн зайтай хэдэн хүүхэд төрүүлэх эсэхээ хэний ч шахалт, албадлагагүйгээр та өөрөө шийдэх эрхтэй. Энэ эрх таныг хүчээр гэрлүүлэх, бэлгийн харьцаа, хүчээр биеийг нь үнэлүүлэх, эсвэл өөр ямар нэгэн хүсээгүй бэлгийн халдлагад өртөхөөс хамгаалдаг.
- Дөрвөн эрх тус бүрийн батламж оролцогчдын тоогоор байна. Амьдралын карт ч ялгаагүй оролцогчдын тоогоор байх хэдий ч тал нь дугуй карт, үлдсэн тэн хагаст дөрвөлжин карт ноогдохоор бэлдэнэ.
- Картыг энгэртээ наах цаасан цавууг оролцогчдын тоогоор жижиглэн бэлдэж, самбар буюу ширээний өнцөгт урьдчилан тогтоосон байна.
- Ханан дээр самбарын хоосон цаас өлгөнө.

Чиглүүлэгчид зориулсан зөвлөмж:

- Энэ дасгал нилээн чимээн шуугиантай болж мэднэ. Тиймээс шаардлагатай үед оролцогчдын анхаарлыг татахын тулд шүгэл, хонх эсвэл метал хувин цохих зэрэг хэрэг болж болзошгүй.

Алхмууд:

1. Оролцогчдод дараах зүйлийг хэлж өг: “Та бүхэн цөм “Шинэ гариг”-ийн иргэд болчихсон байна гэж төсөөлнө үү? Энэ шинэ гараг дээр бид бие биентэйгээ мэндэлж, бие биенээ

сонирхон хөөрөлддөг. Түүнчлэн, бид гаригийнхаа хуулийг зарлахад анхааралтай сонсож, хууль бүрийг заавал мөрддөг.”

2. Мөн дараах зүйлийг тайлбарлаж өг: “Оролцогчид өрөөгөөр тарж явна, хүн бүр хэн нэгэнтэй уулзаж, нэрээ солилцоно. Ингэхдээ бөөгнөрөлдөхгүй. Нэг удаад нэг хүн нэг л хүнтэй уулзана, тэгээд үргэлжлүүлээд дараа, дараагийн хүмүүстэй нэг бүрчлэн уулзаад, нэрээ солилцоод, мэнд усаа мэдэлцээд явна. Хэн нэгэнтэй хоёрдахь эсвэл гуравдахь удаад учрах тохиолдолд өөрийнхөө тухай түүнд шинэ мэдээлэл өгнө (жишээ нь хаана амьдардаг, юу хийдэг вэ, хэдэн хүүхэдтэй, ямар хоббитой гэх мэт). Хүмүүстэй уулзаж байхдаа өөрийнхөө жинхэнэ нэрийг ашиглана, өөрийнхөө тухай бодит мэдээлэл өгнө.”
3. Оролцогчдод босоод сая танилцуулсан зааврын дагуу өрөөгөөр тарж, бие биентэйгээ мэндэлж, танилцаж эхлэ гэж хэл.
4. Тэд мэнд усаа мэдэлцэж явах зуур эрхийн батламжуудаа ширээн дээр 4 ангилаад тавь.
5. Оролцогчид уулзаж ярилцаад 2 минут өнгөрсний дараагаар “Анхаараарай!” гэж өндөр дуугаар дуудаад оролцогчдын анхаарлыг өөр дээрээ бүрэн төвлөрүүл. Оролцогчид зогсож л байх ёстой, хэн ч суухгүй.
6. Дараах зүйлийг хэлж өг: “Манай Шинэ гариг тусгай хуулиудтай. Манай гаригийн бүх хүн тэдгээр хуулийг заавал, нэг бүрчлэн дагадаг. Одоо би та бүхэнд манай гаригийн анхдугаар хуулийг уншиж өгье.”

Хууль №1

“Шинэ гаригийн эрхэмсэг иргэд ээ, тавтай морилно уу! Та нар аз жаргалтай, нөхөрсөг гаригийн хүмүүс. Та бүхэн шинэ хүмүүстэй танилцахдаа хэзээд баяртай байдаг, өөрийнхөө тухай тэдэнд ярьж өгөх ч маш дуртай байдаг. Энэ гаригийн иргэний хувьд, хүн бүр дараах 4 эрхийг баталгаатай эдэлнэ:

- “Нэгдүгээрт, Та бүхэн бие махбодын хувьд аюулгүй байх эрхтэй – Таныг хэнээс ч хамааралгүй, халдашгүй чөлөөтэй, бие махбодын хувьд бүрэн бүтэн байж, гэмтэж, бэртэхээс энэ эрх хамгаалдаг.” Хүн бүрт бие махбодын аюулгүй байдлыг илэрхийлсэн батламж өгнө. (Оролцогчдод “бие махбодын аюулгүй байдал” батламжийг үзүүл.)
- “Хоёрдугаарт, Та бүхэн бусдаар хүндлүүлэх эрхтэй – Энэ эрх нь Таныг давтагдашгүй, цорын ганц гэдгийг хүлээн зөвшөөрч, тантай хүнлэг бусаар харьцах, таныг ялгаварлан гадуурхахаас хамгаалдаг.” Хүн бүрт бусдаар хүндлүүлэх эрхийн батламжийг өгнө. (Оролцогчдод “бусдаар хүндлүүлэх” батламжийг үзүүл.)
- “Гуравдугаарт, Та бүхэн өөрийнхөө амьдралд хамаатай шийдвэрүүдийг гаргах эрхтэй - Энэ эрх Таныг өөрийнхөө амьдралд хамаатай аливаа асуудлаар сонголт хийх, шийдвэр гаргах боломжийг өгдөг. Мөн мөнгө, өмчтэй болоход тань, эсвэл мэдээлэл авахад тань бусдын зүгээс саад хийх явдлаас таныг хамгаалдаг.” Хүн бүрт өөрийнхөө амьдралд хамаатай шийдвэрийг өөрөө гаргах эрхийн батламжийг өгнө. (Оролцогчдод “сонголт хийх, шийдвэрээ өөрөө гаргах” батламжийг үзүүл.)
- “Дөрөвдүгээрт, Та бүхэн өөрийн бэлгийн амьдралыг хянах эрхтэй – Бэлгийн чиг баримжаа чинь ямар байх, хэдэн насандаа хэнтэй бэлгийн харьцаанд орох, хэнтэй гэрлэх, хэдэн жилийн зайтай хэдэн хүүхэд төрүүлэх эсэхээ хэний ч шахалт, албадлагүйгээр та өөрөө шийдэх эрхтэй. Энэ эрх таныг хүчээр гэрлүүлэх, бэлгийн харьцаа, хүчээр биеийг нь үнэлүүлэх, эсвэл өөр ямар нэгэн хүсээгүй бэлгийн халдлагад өртөхөөс хамгаалдаг. Хүн бүрт өөрийн бэлгийн амьдралыг хянах эрхийн батламжийг өгнө. (Оролцогчдод “бэлгийн амьдралаа өөрөө хянах” батламжийг үзүүл.)

Ирээд батламжуудаа авна уу, тэгээд үргэлжлүүлээд өөрийнхөө талаарх мэдээллээ солилцоно уу”

7. Оролцогчид үргэлжлүүлэн мэдээллээ харилцан солилцох зуур амьдралын картуудыг хоёр ангилан ширээн дээр өрж тавь.
8. Гурван минутын дараагаар “Анхаараарай!” Гэж өндөр дуугаар дуудаад анхаарлыг нь өөр дээрээ бүрэн төвлөрүүл.
9. “Хоёрдугаар хуулийг уншиж танилцуулах цаг боллоо” гэж хэлээд дараах зүйлийг уншиж өг:

Хууль №2

“Шинэ гаригийн эрхэмсэг иргэд ээ, манай гаригийн нийт хүн амыг хоёр хэсэгт хуваах боллоо. Та нарын тал нь “дөрвөлжин”, тал нь “дугуй” болно. Хүн бүр энэ хоёр бүлгийн аль нэгийг төлөөлсөн карт авна, энэ бол таны Амьдралын карт. Энэ Шинэ гариг дээр амьд явахын тулд та зайлшгүй Амьдралын карттай байх ёстой. Ирээд нэг, нэг карт аваад энгэртээ наана уу. Тэгээд үргэлжлүүлээд мэдээллээ солилцоод явна уу.”

10. Гурван минутын дараа оролцогчдыг зогсоогоод гуравдугаар буюу хамгийн сүүлчийн хуулийг уншиж өг.

Хууль №3

“Шинэ гаригийн эрхэмсэг иргэд ээ! Цаг үе өөрчлөгдлөө. Энэ мөчөөс эхлэн дугуйнууд дөрвөлжингүүдээс илүү эрх мэдэлтэй болсныг албан ёсоор мэдэгдэж байна.” Намайг алгаа ташихад (хонх дуугаргах, шүгэл үлээх) мэдээллээ солилцож буй дугуй, дөрвөлжин хоёрын дугуй нь дөрвөлжингийнхөө 4 эрхийн батламжийн нэгийг нь авах болно. Үргэлжлүүлэн мэдээллээ бусадтай харилцан солилцох ба намайг алгаа таших бүрт дугуй нь учирсан дөрвөлжингийнхөө нэг эрхийн батламжийг авсаар байх болно. Хэрэв дугуйн учирсан дөрвөлжин нь эрхийн батламжгүй болсон бол дугуй нь түүний Амьдралын картыг авна. Амьдралын картгүй болсон дөрвөлжин тоглоом дуустал хөшсөн мэт доошоо харж, гараа унжуулан хөдөлгөөнгүй, чимээгүй зогсоно. Ийм эрсдэлтэй гэдгийг мэдэж байгаа ч дөрвөлжингүүд дугуйнуудтай мэдээллээ харилцан солилцоод л явах ёстой. За та бүхэн үргэлжлүүлээд мэдээллээ солилцоод явна уу.”

11. Үе үе алгаа таш (хонхоо дуугарга, шүгэлээ үлээ). Оролцогчдын 3-ны 1 нь “хөшсөн” хойно тоглоомыг “Зогс!” гэж өндөр дуугаар дуудаад зогсоо. Тэгээд Шинэ гаригийнхан хийдэг ажлаа түр орхиод хэлэлцүүлэг өрнүүлнэ гэж хэл.
12. Оролцогчдыг том тойрог болгон суулга.
13. Шинэ гариг дээр амьдрахад ямар байсан тухай хэлэлцүүлгийг дараах асуултуудыг тавин өрнүүл:
 - “Дөрвөн эрхээ авахад ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?”
 - “Та нарыг дугуй болон дөрвөлжин болгон хуваахад ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?”
 - “Дөрвөлжингүүд ээ, дугуйнуудад илүү эрх мэдэл өгөхөд ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?”
 - Эрхийг тань хэзээ л бол хэзээ хурааж авах аюулд амьдрах ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ? Энэ нь таны биеэ авч явах, бусадтай харилцах байдалд хэрхэн нөлөөлсөн бэ?”
 - “Дугуйнууд аа, бусдаас илүү их эрх мэдэлтэй байх ямар санагдсан бэ? Ямар мэдрэмж төрсөн бэ?”

14. Шинэ гариг болон бидний амьдарч буй нийгмийг харьцуулан дүгнэ, ингэхдээ дараах аргыг ашигла:
- А. Оролцогчдод дараах асуултыг тавь:
1. Хүн бүр бидний эдэлж байсан шиг 4 эрхтэй байх ёстой юу?
 2. Бидний амьдарч буй нийгэмд хүмүүс өөр өөр бүлгүүдэд яг энэ дасгал шиг хуваагдсан, “ангилагдсан” байдаг уу? (Хэрэв хүмүүс “хүйсээр” буюу “эрэгтэй, эмэгтэйгээр ангилдаг, ялгадаг” гэж хэлэхгүй бол үүнийг нэмж хэлэх хэрэгтэй шүү.)
 3. Нэг бүлэг хүмүүст өөр бүлэг хүмүүсээс илүү эрх мэдэл өгөх нь ямар үр дагавартай вэ?
 4. Зарим хүмүүст нийгмийн зүгээс давуу эрх мэдэл оноох нь шударга уу?
 5. Манай нийгэмд ихэвчлэн хэнд илүү эрх мэдэл олгодог вэ?
 6. Зарим хүмүүс энэ эрх мэдлээ бусдын эрхийг үл хүндлэх, бусдыг дарамтлахад ашигладаг уу?
 7. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх мэдлийн тэнцвэргүй байдал эмэгтэйчүүдийн амьдралыг хэрхэн хязгаарладаг вэ? (жишээ нь тэдний сонголт, шийдвэр, боломжоо ашиглах байдал)
- Б. Дараах зүйлийг тайлбарлаж өг: “Эмэгтэй, эрэгтэй хоёрын хооронд эрх мэдлийн тэнцвэргүй байдал байхад бид тухайн эрэгтэй бусдыг хянах эрх мэдлээ тухайн эмэгтэйн эсрэг ашиглаж байна гэж үздэг. Нийгэм, хамт олны гишүүд эрх мэдлийн энэ тэнцвэргүй байдлыг хардаггүй, эсвэл хүлээн зөвшөөрдөг буюу энэ талаар үг дуугардаггүй тул эрх мэдлийн тэнцвэргүй байдал нь оршин тогтносоор байдаг. Энэ байдлыг өөрчлөхийн тулд бид өөрсдийнхөө хандлага, зан үйлийг өөрчлөх хэрэгтэй.”
- В. “Нэг өрөөнд сууж буй бид цөм бие биенийхээ эрхийг хүндэтгэнэ” гэдгийг тайлбарла. Тэгээд оролцогчдыг Шинэ гаригдаа эргэж очоод, мэнд усаа мэдэлцээд, хүн бүр 4 эрхийн батламжтай болтол батламжуудаа тарааж өгөхийг хүс.

СЭДЭВ 2:

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮҮХЭН ТОВЧООН

Эртний Вавилон улсаас эхлэн хүний эрхийн санаа нь маш хурдтай Энэтхэг, Грек, хожим Ром улсад дэлгэрчээ. Ром улсад хүмүүс бичигдээгүй боловч тодорхой хууль журмыг дагах хандлагатай байснаас “жам ёсны хууль” гэсэн ойлголт гарч ирсэн бөгөөд Ромын эрх зүй нь юмсын мөн чанараас үүдэлтэй оюунлаг санаанд тулгуурладаг. Улмаар Магна Карта (1215 он), Эрхийн шаардлага (1628 он), АНУ-ын Үндсэн хууль (1787 он), Францын Хүний болон иргэний эрхийн тунхаглал (1789 он), АНУ-ын Эрхийн билл (1791 он) зэрэг хувь хүмүүсийн эрхийг эдлүүлэхэд чиглэсэн баримт бичиг нь өнөөгийн хүний эрхийн олон баримт бичгүүдийн бичмэл эх сурвалж билээ.

Вавилон улсын Хаммурафи хааны хууль (МЭӨ 1750-аад он)

Хаммурафи хаан нь Вавилон улсын анхны хаан байсан бөгөөд хүн төрөлхтний түүхэнд мэдэгдсэн хамгийн анхны бичмэл хуулийг боловсруулжээ. Үүнд буруутгагч тал нь яллаж буй хүнийхээ гэм бурууг нотлох хүртэл тухайн яллагдагч гэм буруугүй гэж үзнэ гэсэн санааг агуулсан байдаг.



Хуучин гэрээ (МЭӨ1200-100 он)



Үүнийг Еврей Библи, Танак буюу Еврей нартай Бурханы хэлэлцсэн яриа хэмээн нэрлэх нь ч бий. Хуучин гэрээ нь Арван сургаалийн хамт хүний амь нас хийгээд өмчийн эрхийг хамгаалах (тухайлбал амь насыг бүрэлгэхгүй байх үүрэг), нотлогдоогүй байхад гэм буруугүйд тооцох, сүмээс өршөөл үзүүлэх гэх мэт зарчмуудыг агуулсан байдаг.

Күнзийн сургаал (МЭӨ 551-479 он)



Тус сургаалын тулгуур зарчим болох “бусдаас хүсч буй зүйлээ бусдад хандуулан үйлд, бусдаас хүсэхгүй зүйлээ бусдад хандан бүү үйлд” гэсэн зарчмыг агуулсан байдаг.

Сайрусын бортого (МЭӨ 539 он) (The Cyrus Cylinder)



Хатаасан шавар бортого дээр хүний эрхийн төлөөх Сайрусын хааны зарлигуудыг Аккадиан хэлээр буулгасан юм.

МЭӨ 539 онд Эртний Персийн анхны хаан Аугаа Сайрусын арми Вавилон хотыг эзэлжээ. Гэхдээ үүний дараа хийсэн үйлдлийг хүний төлөөх чухал ололт гэж үздэг. Тэрээр боолуудыг суллаж, бүх хүмүүс өөрийн шашнаа сонгох эрхийг зарлан тунхаглаж, арьсны өнгөнд тэгш хандах хэрэгтэйг тогтоосон байна. Эдгээр болон бусад зарлигуудыг цилиндр хэлбэртэй үсэг бүхий Аккадиан хэлээр хатаасан шавар бортогууд дээр бичжээ.

Орчин үед Сайрусын бортого гэх энэхүү эртний бичгийн дурсгалыг дэлхийн анхны хүний эрхийн баримт бичиг гэж хүлээн зөвшөөрчээ. Үүнийг НҮБ-ын албан ёсны зургаан хэлээр орчуулсан ба түүний заалтууд нь ХЭТТ-ын эхний дөрвөн зүйлтэй адил агуулгатай ажээ.



Магна Карта (1215 он) (The Magna Carta)

1215 онд Английн хааны гарын үсэг зурсан Магна Карта буюу “Аугаа дүрэм” нь хүний эрхийн талаарх эргэлт хийсэн алхам юм.

Магна Карта нь Англи хэлээр яригч ертөнцөд өнөөдрийн үндсэн хуулийн эрх зүйн засаглал бий болох түүхэн үйл явцад маш хүчтэй нөлөөлсөн байна. Англид мөрдөж байсан маш олон тооны эртний хууль тогтоомж, зан заншлыг Английн хаан Жон зөрчсөний дараа түүний бараа бологчид түүнийг Магна Картад гарын үсэг зурахыг хүчилсэн бөгөөд энэ баримт бичигт хожим хүний эрх гэж нэрлэх олон зүйлсийг жагсаасан болно. Эдгээрийн дотроос сүм нь төрийн хөндлөнгийн оролцооноос ангид байх, бүх чөлөөт иргэд өмчтэй байх, түүнийгээ өв залгамжлуулах, хэт өндөр татвараас хамгаалуулах эрхийг нэрлэж болно. Мөн өмч эзэмшиж буй бэлэвсэн эмэгтэйчүүд дахин гэрлэхгүй байх гэдгээ сонгох эрхийг зааснаас гадна шүүхийн журам, хууль шүүхийн өмнө тэгш байх зарчмуудыг заажээ. Үүний зэрэгцээ хахууль, албаны зүй бус үйлдлийг хориглосон заалт оруулжээ. Орчин үеийн ардчиллын хөгжилд хамгийн чухал баримт бичгийн нэгд тооцогддог энэ баримт бичиг нь эрх чөлөөг тогтоох тэмцэлд чухал эргэлт болсон билээ.



Эрхийн шаардлага (1628 он) (Petition of Right)

Хүний эрхийн хөгжил дэх дараагийн бичмэл эх сурвалж бол 1628 онд Парламентаас гаргасан Эрхийн шаардлага бөгөөд үүнийг иргэдийн эрх чөлөөний мэдэгдэл хэмээн хаан I Чарльз хүргүүлжээ. Парламент хааны нийтлэг бус гадаад бодлогыг санхүүжүүлэхээс татгалзсан нь хаант засгийн газар хүчээр зээл авах, эдийн засгийн арга хэмжээ гэж бараа бологчдынхоо гэрт цэргүүдийг суулгахад хүргэсэн байна. Эдгээр бодлогыг эсэргүүцсэн хүмүүсийн дур зоргоор баривчилж, хорьсон нь хаан болон Бюкингемийн гүн Ж.Вилнерт ширүүн хандахад хүргэжээ. Сэр Эдвард Кокийн санаачилсан Эрхийн шаардлага нь эртний хууль, дүрэм журамд суурилсан ба дөрвөн зарчмыг агуулсан. Үүнд:




(1) Парламентаар хэлэлцэлгүйгээр ямар ч татварыг оногдуулж болохгүй; (2) ямар ч шалтгаангүйгээр хэнийг ч хорьж болохгүй; (3) иргэний орон байранд цэргүүдийг байршуулж болохгүй; (4) энхийн цагт цэргийн хуулийг ашиглаж болохгүй.

АНУ-ын Үндсэн хууль (1787 он)

1776 онд Томас Жефферсон Америкийн Тусгаар тогтнолын тунхаг бичгийг үзэглэсэн байна.


АНУ-ын Конгресс 1776 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Тусгаар тогтнолын тунхаг бичгийг баталсан билээ. Үүний гол зохиогч Томас Жефферсон уг тунхаглалыг Америкийн хувьсгалт дайнаас хойш жил гаруйн дараа Их Британиас тусгаар тогтносноо зарлахын тулд Конгресс яагаад санал хураах болсныг тайлбарласан тайлбар болгон гаргаснаас гадна Америкийн 13 колони Британийн эзэнт гүрний нэг хэсэг биш болохыг зарласан мэдэгдэл юм. Конгресс Тусгаар тогтнолын тунхаг бичгийг хэд хэдэн хэлбэрээр гаргасан ба олон нийт унших боломжтой хүснэгт хэлбэрээр хэвлэн нийтэлсэн байна. Гүн ухааны үүднээс авч үзвэл тунхаг бичиг нь хувь хүний эрх болон хувьсгал хийх эрх гэсэн хоёр сэдвийг хөндсөн. Эдгээр санааг Америкчууд өргөнөөр дэмжсэн ба олон улсын түвшинд ч түгэж, Францын хувьсгал гарахад нөлөөлжээ.



(АНУ-ын Үндсэн хуулийн) АНУ-ын Эрхийн билл (1791 он)

АНУ-ын Үндсэн хуулийн Эрхийн Билл нь АНУ-ын иргэдийн үндсэн эрх чөлөөг хамгаалдаг.

Филадельфи мужид 1787 оны зун бичсэн АНУ-ын Үндсэн хууль бол АНУ-ын төрийн холбооны тогтолцооны тулгуур хууль бөгөөд Барууны ертөнцөд чухал баримт бичигт тооцогддог. Энэ бол хамгийн анх хэрэглэж ирсэн бичмэл үндсэн хууль бөгөөд төрийн гол байгууллагууд, тэдгээрийн харьяалал, иргэдийн үндсэн эрхийг тодорхойлсон болно. Уг хуулийн эхний арван нэмэлт өөрчлөлт болох Эрхийн билл 1791 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба АНУ-ын Холбооны засгийн газрын эрх мэдлийг хязгаарлаж, АНУ-ын нутаг дэвсгэр дэх бүх иргэд, оршин суугчид, хүрэлцэн ирсэн хүмүүсийн эрхийг хамгаалдаг болно. Эрхийн билл нь үг хэлэх эрх чөлөө, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, зэвсэг хадгалах, зэвсэг барин тэмцэх, эвлэлдэн нэгдэх, шаардлага бичих эрх чөлөөг хамгаалдаг. Мөн үндэслэлгүй нэгжих, хураах, хэрцгий болон зүй бусаар шийтгэх, хүчээр өөрөө гэмт хэрэг хүлээх зэргийг хориглодог байна. Энэхүү эрх зүйн хамгаалалт дунд Эрхийн билл нь Конгресс шашин бий болгохыг хүндэтгэсэн ямар нэгэн хууль гаргахыг хориглож, хууль бус замаар ямар нэгэн хүний амьдрал, эрх чөлөө, өмчид халдахыг холбооны засгийн газарт хориглодог. Холбооны түвшний гэмт хэргийн хувьд, цаазаар авах ял оноосон буюу онц хүнд гэмт хэрэгт их суудлын тангарагтаны шүүх хуралдах, гэмт хэрэг гарсан тойрогт шударга тангарагтаны шүүх бүхий шүүх хуралдахыг баталгаажуулан, давхардуулан аюул учруулахыг хориглодог.



Францын Хүний болон иргэний эрхийн тунхаглал (1789 он)

1789 оны Францын хувьсгалын дараа Хүний болон иргэний эрхийн тунхаглал нь дарангуйллаас тодорхой эрх чөлөө олгосон тул “нийтлэг хүсэл сонирхлын илэрхийлэл” гэдэг.

1789 онд Францын ард түмэн хэмжээгүй эрхт хаант засгийг унаган, Францын анхны Бүгд найрамдах улсыг байгуулах түвшинд хүрсэн. Бастиль цайз уруу довтолсноос хойш 6-7 хоног дараа феодализмыг халаад, 3-7 хонож байхдаа Хүний болон иргэний эрхийн тунхаглалыг Үндэсний байнгын Ассамблей баталсан нь БНФУ-ын Үндсэн хуулийг бичих анхны алхам болсон. Тунхаглалд бүх иргэд нь “эрх чөлөө, өмч, аюулгүй байдал, дарангуйллаас ангид байх” эрхийг баталгаажуулсан байхыг заажээ. Мөн “хүн бүрийн жам ёсны эрхийг эдлүүлэх явдалд нийгмийн бусад гишүүдийн бусдын адил эрхийг хэрэгжүүлэхэд баталгаажуулах шаардлагатай хил зааг байдаг” тул хууль хэрэгтэй гэж үзсэн байна. Тунхаглалд эрхүүдийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих, “гагцхүү нийгэмд хор хөнөөлтэй үйлдлүүд”-ийг хориглохын тулд хуулийн “нийтлэг хүсэл сонирхлын илэрхийлэл” гэж үзсэн байна.



Женевийн нэгдүгээр конвенц (1864 он)

Анхны 1864 оны Женевийн конвенцийн эх баримт бичигт шархадсан цэргүүдэд үзүүлэх халамжийг тусгайлан заажээ.

Женевийн хорооны санаачилгаар Швейцарийн Холбооны Зөвлөлийн санаачилгаар 1864 онд Женев хотноо Европын 16 улс, Америкийн хэдэн улс хуралд оролцсон. Энэ дипломат уулзалтын зорилго нь тулаан дахь шархадсан цэргүүдийг эмчлэхэд зориулсан конвенцийг батлах байсан ажээ. Үндсэн зарчмуудыг тухайн конвенцид тусгаж, дараагийн Женевийн конвенцуудад шархадсан, өвчтэй цэргийн бие бүрэлдэхүүнийг ялгаварлахгүй тусламж үзүүлэх, цагаан суурин дээр улаан загалмайн ялгах тэмдэг бүхий эмнэлгийн бие бүрэлдэхүүний тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг хүндэтгэх үүргийг заажээ.



Нэгдсэн Үндэстний Байгууллага (1945 он)

1945 онд Сан Франциско хотод 50 улс цуглан, энх тайвныг хамгаалах, хөхиүлэн дэмжихээр Нэгдсэн Үндэстний байгууллага (НҮБ)-ыг байгуулжээ.

Дэлхийн II дайн 1939 оноос 1945 оны хооронд улам ширүүсч, төгсөхийн алдад Европ, Ази даяарх хотууд үнсэн товрог болсон байна. Олон сая хүн үхэж, сая сая хүн орон гэргүй, эсвэл өлсгөлөнд нэрвэгдсэн байлаа. Оросын зэвсэгт хүчин Германы нийслэл бөмбөгдүүлсэн Берлин дэх Германы үлдэгдэл хүчинд дөхөж байсан болно. Номхон далайд АНУ-ын



тэнгисийн зэвсэгт хүчин Окинава зэрэг арлууд дээр Японы зэвсэгт хүчинтэй тулалдаж байлаа. 1945 оны 4 дүгээр сард 50 улсын төлөөлөгчид Сан-Франциско хотод өөдрөг сэтгэл, итгэлээр дүүрэн уулзсан юм. НҮБ-ын олон улсын байгууллагын талаарх хурлын зорилго нь энх тайвныг хөхиүлэн дэмжих, ирээдүйд гарах дайнаас урьдчилан сэргийлэхийн тулд олон улсын байгууллагын загварыг гаргахад оршиж байлаа. Тус байгууллагын загварыг түүний санал болгосон дүрэмд “НҮБ-ын ард түмэн бид хүн төрөлхтөнд хэлэхийн аргагүй уй гашууг бидний амьдралд хоёр удаа авчирсан дайны хөлөөс хойч үеийг аврах зорилгоор байгуулсан”. НҮБ-ын шинэ дүрэм 1945 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд уг өдрийг НҮБ-ын өдөр гэж жил болгон тэмдэглэдэг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948 он)

Хүний эрхийн түгээмэл тунхаглал (ХЭТТ) нь дэлхий дахинд хүний эрхийн маш олон тооны хууль тогтоомж, гэрээг, конвенц, стандартыг санаачлахад нөлөөлсөн.

1948 онд НҮБ-ын шинээр байгуулсан Хүний эрхийн комисс дэлхийн анхаарлыг татаж байлаа. Хүний эрхийн Комиссын эрч хүчтэй дарга, хүний эрхийн цогтой тэмцэгч, НҮБ-д болон Комисст АНУ-ыг төлөөлөгч Элеанора Рузвельт нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал гэх болсон баримт бичгийн төслийг боловсруулах ажлыг эхлүүлсэн байна. Тэрээр өөрт төрсөн сэтгэгдлээр “Бүх хүн төрөлхтөнд зориулсан олон улсын Магна Карта” гэж тунхаглалыг нэрлэж байсан. Уг баримт бичгийг 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр НҮБ-аас баталсан бөгөөд. Тунхаглалын оршил хэсэг болон 1 дүгээр зүйлд тунхаглал нь өргөн утгаар хүн бүрийн салшгүй эрхүүдийг заасан. Үүнд “Хүний эрхийг үл тоомсорлох, басамжлах нь зон олны ариун сэтгэлийг сэвтээн жигшээсэн балмад үйлдэлд хүргэж байсан бөгөөд хүмүүс үгээ хэлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй, түүнчлэн айх аюулгүй, гачигдах зовлонгүй дэлхий ертөнцийг бий болгох нь хүн ардын эрхэм дээд эрмэлзэл мөн хэмээн үзэж “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна” гэжээ.

Түүхэнд анх удаа НҮБ-ын гишүүн улсууд нэгэн баримт бичигт нэгтгэн буулгасан хүний эрхийн 30 зүйлийг хөхиүлэн дэмжиж, хамтдаа ажиллахыг баталгаажуулсан билээ. Үүний үр дүнд эдгээр эрхүүдийн олонх нь төрөл бүрийн хэлбэрээр өнөөдөр ардчилсан улсуудын үндсэн хуулийн хэсэг болсон байна.

Дэлхийн II дайны төгсгөлд 1945 оны 10 дугаар сарын 24-ний өдөр НҮБ олон улсын зөрчилдөөний хор хөнөөлөөс хойч үеийг хамгаалах зорилгоор Засгийн газар хоорондын байгууллага болж эхэлсэн байна.

Дэлхийн бүх хэсгээс ирсэн НҮБ-ын төлөөлөгчид 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ХЭТТ-ыг албан ёсоор баталжээ.



НҮБ-ын Дүрмээр Ерөнхий Ассамблей, Аюулгүйн Зөвлөл, Олон улсын шударга ёсны шүүх, хүний эрхтэй холбон Эдийн засаг, нийгмийн зөвлөл зэргийг багтаасан зарчмын зургаан байгууллага байгуулжээ. НҮБ-ын Дүрмээр Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь “эдийн засаг, нийгмийн салбар хариуцсан болон хүний эрхийг хөхиүлэн дэмжих комиссуудыг байгуулах...” Эрх мэдэл олгосон болно. Эдгээрийн нэг нь Элеанора



Рузвельтын удирдлаган дор ХЭТТ-ыг бүтээхэд ажилласан НҮБ-ын Хүний эрхийн комисс юм. Тунхаглалын төслийг дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн төлөөлөгчид боловсруулсан ба бүхий л эрх зүйн уламжлалыг тусгасан ажээ. НҮБ-аас 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр албан ёсоор баталсан уг тунхаглал нь ардчилсан нийгмийн суурь болсон гучин үндсэн эрхийг тодорхойлсон хамгийн түгээмэл хүний эрхийн баримт бичиг билээ.

Энэхүү түүхэн үйл явдлын дараа Ерөнхий Ассамблей бүх гишүүн улсуудаас уг тунхаглалын бичвэрийг нийтлэх, “улс орны эсвэл газар нутгийн улс төрийн нөхцөлд суурилсан ялгаваргүйгээр ялангуяа сургууль, боловсролын бусад байгууллагуудад түгээсэн, олонд харуулсан, уншуулахаар тавьсан, тайлбарласан байхыг” уриалсан байдаг. Өнөөдөр уг тунхаглал нь дэлхий дээрх төр болон ард түмний хоорондын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн амьд баримт бичиг юм. ХЭТТ нь Дэлхийн амжилтын тухай Гиннесийн номонд зааснаар дэлхий дээрх хамгийн ихээр орчуулсан баримт бичиг ажээ.

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ТӨРИЙН ҮҮРЭГ

Зорилго

Хүний эрхийн асуудлаар хэн, хэрхэн үүрэг хүлээдэг, төрийн үйлчилгээ ямар байх ёстой талаар ойлголттой болох.

Дасгал

15 мин

Оролцогчдыг 3 бүлэгт хуваан ажиллуулна. Тухайлбал, “эрүүл мэндээ хамгаалуулах эрх”, “эрүү шүүлтээс ангид байх эрх”, “хөдөлмөрлөх эрх” зэргийг бүлэг тус бүрт хуваарилан өгч эдгээр эрхийг хэрхэн хүндэтгэх, хамгаалах, хангах вэ гэсэн асуултын хариуг самбарын цаас тараан өгч ажиллуулж тус бүрээр танилцуулга хийлгэнэ.

Чиглүүлэгчийн уншсан байх мэдээлэл

“...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг)

Аливаа төрийн үүрэг нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хангах явдал юм. Төрийн үүрэг нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой. Нэгэнт хүнээс салгаж болшгүй ойлголт тул хүний эрхийг огт үгүйсгэлгүй, зөвхөн тусгайлан заасан нөхцөлд хязгаарлах боломжийг орчин үеийн төрд олгосон юм. Иймээс төр нь эн тэргүүнд өөрийн улсын нутаг дэвсгэр дээрх хүмүүсийн эрхийг:

- Хүндэтгэх
- Хангах
- Хамгаалах гэсэн үүргийг хүлээдэг.

Хүний эрхийг хүндэтгэх

Тухайн эрхийг эдлэхэд ямарваа нэгэн саад учруулахгүй, зөрчихгүй байхыг ойлгодог. Төрийн зүгээс хүмүүсийн эрхээ эдлэх гэсэн үйлдлийг хязгаарлах, хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулж болохгүй (жишээлбэл, эрүүдэн шүүх, хууль бусаар баривчлах, хүчээр нүүлгэх буюу төлбөрийн чадваргүй хүмүүст төлбөртэй эмнэлгийн үйлчилгээ санал болгох гэх мэт).

Хүний эрхийг хамгаалах

Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хохирлыг арилгах бүтэц, тогтолцоог бий болгох боловсронгуй хууль тогтоомж батлахыг ойлгодог.

Хүний эрхийг хангах

Хүний эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн баталгааг бий болгох эерэг алхмуудыг ахиц дэвшил гаргасан байдлаар авах ёстой. Ялангуяа хялбаршуулах (үйлчилгээний хүртээмжийг амар хялбар болгох), хөхиүлэн дэмжих (мэдээлэх), хэрэгжүүлэх (эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарч, тэгш

байдлыг бүрдүүлэхэд чиглэх) арга хэмжээг авна. Жишээлбэл, төрөл бүрийн үйлчилгээг нэгтгэсэн нэг цонхны үйлчилгээ, хүүхдийн тэрэг түрсэн, тэргэнцэртэй, эсвэл ахмад настай хүн, хүүхэд хүртэл явах боломжтой налуу зам, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлдэг дүүрэг, аймгийн төвүүд дэх “Эрх зүйн туслалцааны төв”-үүдийг нэрлэж болно.

Жишээлбэл, сурч боловсрох эрхийн асуудал дээр төрийн үүргийг харьцуулж үзье.

Үүнд:

Хүндэтгэх	Хамгаалах	Хангах
Сургуульд сурч байгаа хүүхдүүдийг сургуулиас завсардуулахгүй, сургуулийн орчин, үзэж байгаа хичээлийг дордуулахгүй байх	Багш хүүхдийг ялгаварлан гадуурхах, зодож шийтгэх, төрөл бүрийн мөнгө, хураамж авахыг хориглож, ийм үйлдэл гаргасан бол хуулийн дагуу хариуцлага тооцдог байх	Бүх хүүхэд суурь боловсролыг үнэ төлбөргүй, заавал эзэмшихээр хуульдаа заасан байх.

Хүний эрхийн талаар үүрэг хариуцлага хүлээх зарчмын дагуу төр нь иргэнийхээ эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах үүргийг хүлээдэг. Энэ нь Монгол Улс Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төрд даалгасан байдгаар илэрнэ. 1992 оны Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хоёрдугаар бүлэгт 80 орчим эрх, эрх чөлөөг тусгайлан нэрлэж, баталгаажуулсан байх бөгөөд Үндсэн хуулийн оршил хэсгээс бусад бүлгүүдэд хүний эрхтэй холбогдолтой олон заалт, зарчмуудыг тусгасан байдаг. Хүний эрхийн олон улсын суурь баримт бичиг болох Хүний эрхийн Биллд тусгагдсан, үндсэн эрхүүдийг манай улсын Үндсэн хуульд бүрэн хэмжээгээр тусгаж чадсан гэж судлаачид үздэг байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн заасан байдаг нь манай улсын хувьд хүний эрхийг хангах гол баталгааг тодорхойлж буй хэрэг юм.

Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд 2003 онд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа, механизмыг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг тууштай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх, төрөөс хүний эрхийг хангах зохион байгуулалт, эрх зүйн баталгааг өргөтгөн, зохистой механизмыг бүрдүүлэх зэрэг энэхүү үндэсний хөтөлбөрийн гол зорилтууд юм.

“...Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг)

Үндсэн хууль, олон улсын гэрээнд хүн бүрийн эдлэх ёстой эрхүүдийг баталгаажуулж, төрийн хүлээх үүргийг зааж өгсөн байдаг. Тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-т заасны дагуу “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг яс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.” Жишээлбэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шашин шүтэх, эс шүтэх зэрэг хууль тогтоомжоор баталгаажуулан шууд хэрэгжүүлдэг эрх, эрх чөлөө бий.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 2 дугаар зүйлийн 1-д заасны дагуу “Энэхүү Пактад оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн

эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, байгаа бүх боломжийнхоо хэрээр зохистой арга хэмжээг авах үүрэгтэй” гэж заасан.

Харин сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн хамгаалал хүртэх эрх зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлэх нь төрийн үйл ажиллагаа, эдийн засаг, нийгмийн хөгжил, бусад нөөц бололцооноос шууд хамаардаг. Тиймээс дээрх баримт бичигт заасан үүргийг дэлгэрүүлэн тайлбарлавал:

- А) “Дэвшилттэйгээр хангах” гэдэгт эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л эрхийг богино хугацаанд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болохыг хүлээн зөвшөөрч, эрхүүдийг хүндэтгэн хангах арга хэмжээг нэн даруй авч аажим аажмаар хангахыг ойлгоно.
- В) “Бүх боломжийнхоо хэрээр” гэдэгт улсуудын эдийн засаг, санхүүгийн бололцоо, бусад нөөц харилцан адилгүй тул тодорхой цаг хугацааны дараа эрхүүдийг бүрэн дүүрэн хэрэгжүүлж болно. Гэхдээ үүнийг төрөөрөө хангалттай нөөц бололцоотой болох хүртлээ эрхүүдийг хамгаалахгүй гэж буруугаар тайлбарлаж болохгүй. Харин өөрийн чадах хэрээр эрхүүдийг эдлэх явдлыг сайжруулахаар бүхийл талаар хичээх ёстой.
- С) “Зохистой арга хэмжээг авах” гэдэгт оролцогч улсууд энэ Пактад нэгдэн орсны дараа богино хугацаанд авч хэрэгжүүлэх зорилгод чиглэсэн дэвшилттэй алхам хийнэ гэсэн үг. Эрх бүртэй холбоотой нөхцлийг харгалзан тэдгээрт тохирсон зохистой арга хэмжээг өөрсдөө шийдвэрлэн авч хэрэгжүүлэх ёстой.

Төрийн үйлчилгээ ямар байх ёстой вэ?

Төрийн зүгээс эрхүүдийг хэрэгжүүлэхдээ төрийн үүргийг хэрэгжүүлэх нөөц, чадавх, боломж бололцоог хангасан байхын зэрэгцээ эрхүүдийн мөн чанарыг сайтар анхаарч, үзүүлэх үйлчилгээгээ хүний эрхийн тодорхой зарчимд нийцүүлэх шаардлагатай. Үүнд:

Хүрэлцээтэй байх: Төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар хуульчлаад зогсохгүй тухайн байгууллагын барилга байгууламж, тоног төхөөрөмж, ширээ сандал, ариун цэврийн өрөө, ундны цэвэр ус, мэргэжлийн боловсон хүчин, тэдний боломжийн цалин хөлс зэрэг асуудлыг шийдсэн байна.

Хүртээмжтэй байх: Ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр үйлчлэх, аливаа нэгэн үйл ажиллагаанд хүн бүр оролцох тэгш боломжоор хангагдсан эсэхээр хэмжигддэг.

Хүлээн зөвшөөрөгдсөн байх: Төрийн зүгээс шаардлагатай дүрэм журмыг ойлгомжтой байдлаар тогтоох, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх, төрийн үйлчилгээ авах боломжийг орчны болон мэдээллийн түвшинд бүрдүүлсэн байх зэрэг асуудлыг хамарна.

Цаг үетэйгээ зохицсон байх: Төрийн бодлого, үйлчилгээ нь нийгмийн өөрчлөлт, хөдөлгөөнд таарч зохицсон байна. Эмзэг бүлгийн хувьд тэдний хэрэгцээнд нийцсэн байхаас гадна тухайн үйлчилгээгээр дамжин бусад эрхүүдийг дэмжсэн байвал зохино.

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ:

ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХИЙН ЖИШЭЭН ДЭЭР

Эрүүл байх нь хүний үндсэн эрхийн нэг бөгөөд бусад эрхээ эдлэхэд нэн шаардлагатай эрх юм. Хүн бүр хүний зэрэгтэй, аз жаргалтай амьдрахад нөлөөлөхүйц хүрч болох дээд түвшинд эрүүл байх эрхтэй. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх гэдэг нь Засгийн газрууд хүн бүрийн эрүүл байх эрхийг баталгаажуулсан байх явдал бөгөөд энэ нь хүрч болох дээд түвшинд эрүүл байх боломжууд байдаг.

Эрүүл байх эрхийг зөвхөн биеэ эрүүл байлгах явцуу утгаар ойлгож болохгүй. Эрүүл байх эрхэнд хувь хүний эрх чөлөө болон эрх мэдэл хоёулаа багтдаг байна. Эрүүл байх эрхээ эдлэх эрх чөлөөтэй байна гэдэг нь хувь хүн биеийн эрүүл мэндээ хянах, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх


чөлөөгөө эдлэх, эрүү шүүлт, тохиролцоогүй эмнэлгийн үйлчилгээ, туршилт зэргээс ангид байхыг хэлнэ. Харин эрх мэдэлтэй байна гэдэг нь хүмүүсийн хүрч болох дээд түвшинд эрүүл байхын тулд тэгш боломжоор хангадаг эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй байхыг хэлнэ.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хэрхэн баталгаажуулсан байдаг вэ?

Хүний эрүүл байх эрхийг олон улсын гэрээгээр баталгаажуулсан байдаг. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 25.1 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл байх шаардлагыг хангахуйц хоол хүнс, хувцас, орон байртай байх, эмнэлгийн тусламж болон нийгмийн хамгааллыг хүртэх эрхтэй” гэж заажээ. Эрүүл байх эрхийг хамгийн өргөн утгаар тусгасан олон улсын гэрээ бол 1966 онд батлагдсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт бөгөөд түүний 12.1 дүгээр зүйлд: “Энэхүү Пактад оролцогч улсууд хүн бүрийн бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрхийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- (a) нялхсын эндэгдлийг багасгах, хүүхдийн эрүүл чийрэг өсөлтийг хангах;
- (b) гадаад орчны болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйг бүх талаар сайжруулах;
- (c) халдварт өвчин, тухайн нутгийн өвчин, мэргэжлийн болон бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тийм өвчинтэй тэмцэх;
- (d) өвчилсөн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, сувилах нөхцлийг бүгдэд бий болгох” хэмээн баталгаажуулсан байдаг.

Пактын 12.1 дүгээр зүйлд тусгагдсан “хүрч болох дээд түвшинд эрүүл байх” гэдэг ойлголт нь хувь хүний биеийн биологийн онцлог болон нийгэм, эдийн засгийн нөхцөл мөн тухайн гишүүн орны нөөц боломжийн аль алианаас хамаардаг ч зөвхөн төр, хүн хоёрын хоорондын харилцаагаар шийдэгдэх боломжгүй олон асуудлууд байдаг гэжээ. Тухайлбал, төр хувь хүнийг өвчин тусах шалтгаан болгоноос хамгаалаад байж чадахгүй харин хүрч болох дээд түвшинд эрүүл байлгахын тулд төрөл бүрийн эмчилгээний тоног төхөөрөмж, эм, эмнэлэг, үйлчилгээ нөхцөлөөр хангах явдал юм.



НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо дээр дурдсан 12.1 дүгээр зүйлийн эрүүл байх эрхийг 14 дүгээр зөвлөмжид тусган тайлбарлахдаа зөвхөн эрүүл мэндийн зохистой үйлчилгээгээр цаг хугацаанд нь үйлчлүүлэх эрхтэй гэдгээр хязгаарлалгүй бусад эрүүл байх нөхцлийг бүрдүүлэх аюулгүй ундны ус, шаардлагад нийцсэн ариун цэврийн нөхцөл, хоргүй хоол хүнсний хангамж, орон байр, ажлын болон байгаль орчны эрүүл байдал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой боловсрол, мэдээлэл авах боломж зэрэг эрүүл мэндийн шийдвэрлэх чухал асуудлуудыг багтаасан юм.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арванзургадугаар дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”, мөн зүйлийн 6 дахь хэсэгт “Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” гэж заажээ. Аливаа улсын төрийн гол үүрэг бол хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хангах, хамгаалах явдал юм. Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн асуудлаар төр дараах үүргийг хүлээдэг байна.

Хүндэтгэх: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, алагчлахгүй байх зарчмын дагуу хүртээхэд саад учруулахгүй байх үүрэгтэй. Түүнчлэн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, хүрээлэн буй орчны бохирдлыг бий болгож болохуйц үйл ажиллагаа гэх мэт хүний эрүүл мэндэд нөлөө үзүүлэх үйлдлийг зогсоох үүрэгтэй.

Хамгаалах: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд хүн бүр тэгш эрхтэйгээр хүртэх боломжийг хангах, хохирохоос урьдчилан сэргийлсэн хууль бодлого хэрэгжүүлэх, хохирлыг барагдуулах шударга механизм бүрдүүлэх, бусад арга хэмжээг авах үүрэгтэй.

Хангах: Үндэсний эрүүл мэндийн бодлогыг хүлээн зөвшөөрөх, төсвөөс хангалттай хувийг эрүүл мэндийн салбарт зарцуулах, шаардлагатай үйлчилгээгээр хангах буюу хувь хүн шаардлага хангасан, хангалттай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд эрүүл мэндийн асрамж, сувилгааны үйлчилгээ, ундны цэвэр ус зэрэг орно.

Эрүүл мэндийн салбар дахь төрийн үйлчилгээ ямар байх ёстой вэ?

Хүрэлцээтэй байх: Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм тариа, үйлчилгээ, эмч, эмнэлгийн ажилтнууд, хөтөлбөр зэрэг нь гишүүн орны дотор хүрэлцэхүйц хэмжээнд байх шаардлагатай. Тухайн тоног төхөөрөмж, эмчилгээ, үйлчилгээ, эм тарианы хангамж нь гэрээнд нэгдэн орсон гишүүн орны хөгжлийн түвшин болон бусад олон хүчин зүйлээс шалтгаална. Үүнд: ундны ус, хангалттай ариун цэврийн нөхцөл, эмнэлэг амбулатори зэрэг эрүүл мэндтэй холбоотой барилга байгууламжууд, орон нутгийн хэмжээнд өрсөлдөх цалин хөлс бүхий бэлтгэгдсэн мэргэшсэн боловсон хүчин, ДЭМБ-ын гол хэрэглээний эмийн хөтөлбөрөөс батлагдсан эм зэрэг орно.



Хүртээмжтэй байх: Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, үйлчилгээ зэрэг нь хэнийг ч ялгаварлан гадуурхахгүйгээр хүн бүрт хүртээлтэй байх ёстой. Хүртээмжтэй байдал гэдэг нь дараах дөрвөн хүрээг хамарна:

- **Ялгаварлан гадуурхахгүй байх**-эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, үйлчилгээ бүх нийтэд, ялангуяа хүн амын хамгийн эмзэг ба доод давхаргын хувьд ч гэсэн хуулиар болон амьдрал дээр ялгаваргүйгээр хүртээлтэй байх;




- **Бодит хүртээмж**-эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, үйлчилгээ хүн амын бүхий л хэсэгт ялангуяа эмзэг бүлэг болон эмэгтэйчүүд, хүүхдүүд, өсвөр насныхан, ахмад настан,

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ХДХВ/ДОХ-ын халдвартай амьдарч буй хүмүүст хангалттай бодитой байх ёстой. Хүртээмжтэй байдал гэдэг нь цаашилбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байшинд орох тусгай замаар хангагдсан байх;

• *Эдийн засгийн боломж*- эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, үйлчилгээ нь бүх хүмүүст төлж чадахуйц боломжийн үнэтэй байх;

• *Мэдээлэл авах боломж*-эрүүл мэндийн асуудалтай холбоотой мэдээллийг хайх, олж авах, хэлэх, илэрхийлэх зэрэг орно. Харин хувь хүний эрүүл мэндтэй холбоотой нууцыг чандлан хадгална.

Нийцтэй байх: Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, эмчилгээ үйлчилгээ нь анагаах ухааны ёс зүй болон уламжлалт ёс заншилд тохирсон буюу өөрөөр хэлбэл, хувь хүн, цөөнх, ард иргэд болон хэсэг бүлэг хүмүүсийн зан үйлийг хүндэтгэсэн, хүйсийн болон насны онцлогт нийцсэн, өвчтөний нууцыг хадгалж, эмчилгээ, үйлчилгээ хийн эрүүл мэндийг сайжруулах чадавхтай байх ёстой.



Чанартай байх: Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эм тариа, эмчилгээ, үйлчилгээ нь хүмүүсийн ёс заншилд нийцсэн байхаас гадна шинжлэх ухаан, анагаах ухааны шаардлагад тохирсон сайн чанартай байх ёстой. Мөн дадлага туршлагатай эмнэлгийн ажилтнууд, шинжлэх ухаанаар батлагдсан хугацаа нь дуусаагүй эм тариа, багаж төхөөрөмж, ундны цэвэр ус болон ариун цэвэр орчингоор хангагдсан байх ёстой.

Эрх зөрчигдвөл хаана хандах вэ?

Таны Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан эрх,эрх чөлөөг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүн зөрчсөн тохиолдолд Эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хороодод хандахаас гадна холбогдох төрийн байгууллага болон шүүхэд хандаж болно.

Эмчлүүлэгчийн эрх

Шинжлэх ухаан техникийн ололт дэвшил, өвчний оношилгоо, эмчилгээний аргууд нь тодорхой цаг хугацааны туршид сайжирсаар ирсэн ч хүн төрөлхтөн амьдрал ахуйгаа өөрчлөн хөгжүүлэх тусам өвчин үүсгэгч хүчин зүйлүүд нь улам ихээр нэмэгдсээр байна. Ард иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлын төлөө анхаарал хандуулж, хамгаалах нь аливаа улс орон бүрийн төр засгийн үндсэн үүргийн нэг юм. 1948 онд батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар хүн төрөлхтний ам бүлийн гишүүн бүхэнд “угаас заяасан нэр төр” болон “тэдний адил тэгш, салшгүй эрх”-ийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ нь бүх хүний тэгш, үндсэн эрх, нэр төр, үнэ цэнэ дээр үндэслэж эмчлүүлэгчийн эрх болгон хөгжүүлсэн ойлголт юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь олон улсын хүний эрхийн хуулиудад хүний нэр төр, үнэ цэнэ, эрхэм зэргийг баталгаажуулахад хувь нэмэр оруулаад зогсохгүй мөн эмчлүүлэгчийн эрхийн стандартуудыг тодорхойлоход хувь нэмрээ оруулж чаджээ. Эмчлүүлэгчийн эрх нь улс орны нийгэм, соёлын давамгайлж буй хэм хэмжээнээс хамаарч хувьсан өөрчлөгдөх шинжтэй ч тухайн улсын хууль тогтоомжоор баталгаажуулснаас илүүтэйгээр эмчлүүлэгчийн эрхтэй холбоотой олон улсад хэд хэдэн асуудлыг эн тэргүүнд авч үздэг. Энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээх, эрүүл мэндийн нууцыг чандлан хамгаалах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний зөвшөөрлийн үндсэн дээр явуулах, эмнэлгийн цэвэр аюулгүй орчныг бүрдүүлэх зэрэг эрхийн наад захын баталгаа байдаг.

Тэгвэл эмчлүүлэгчийн эрхийн ойлголт өндөр хөгжсөн улс болох Америкийн эмнэлгийн нийгэмлэг нь эмчлүүлэгчийн эрхийн дараах жагсаалтыг гаргажээ.

Эмчлүүлэгч өөрийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг авах эрх

Эмчлүүлэгч өөрийн эрүүл мэнд, эмчилгээ үйлчилгээ, эмч, эмнэлгийн тоног төхөөрөмж, эмчилгээний үнийн талаарх мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой үг хэллэгээр авах эрхтэй. Гадаадын иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг сайтар ойлгоогүй бол эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж буй ажилтнаас тодруулж асуух эрхтэй. Ингэснээр эмчлүүлэгч өөрийн эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээтэй холбоотой чухал мэдээллийг авч зөв шийдвэрийг гаргана.

Эмч болон эмчилгээний төрлийг сонгох эрх

Эмнэлэг болон эмчийг өөрөө сонгох, тусламж үйлчилгээг хүлээн авах явцад эмчийг солих санал тавих эрхтэй.

Түргэн тусламжийн үйлчилгээг хүртэх эрх

Эмчлүүлэгчийн эрүүл мэндэд аюултай байж болох хүчтэй өвдөлт, гэмтэл бэртэлт, гэнэтийн өвчин илэрвэл холбогдох шинжилгээг өгөх, тогтворжуулах зэрэг яаралтай түргэн тусламжийн үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хүртэх эрхтэй.

Эмчилгээний шийдвэр гаргахад оролцох эрх

Эмчлүүлэгч эмчилгээний шийдвэрийг гаргахад оролцож өөрийн эмчилгээний төрөл, эмчилгээний сөрөг болон давуу талуудыг мэдэх, эмчилгээ үйлчилгээнээс татгалзах эрхтэй. Эмчлүүлэгч өөрөө бие даан шийдвэр гаргах боломжгүй бол түүнийг төлөөлөх эрх бүхий хүнийг шийдвэр гаргуулахаар сонгож болно.

Хүндэтгүүлэх ба ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх

Эмчлүүлэгч эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж буй эмч, ажилтан харилцан бие биедээ хүндэтгэлтэй хандах ба эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний ажилтнууд хэнийг ч үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, шашин шүтлэг, сэтгэцийн болон бие бялдрын хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, өвчний түүхээр нь ялгаварлан гадуурхаж үл болно.

Эрүүл мэндийн нууцаа хамгаалуулах эрх

Эмчлүүлэгч өвчний талаарх мэдээллээ эмчлэгч эмчдээ хэлэх, нууцаа хамгаалуулах, түүнийг үйлчлүүлэгч өөрөө зөвшөөрсөн эсвэл хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд задруулахгүй байх баталгаагаар хангагдах эрхтэй.

Гомдол хүсэлт гаргах эрх

Эмчлүүлэгч өөрийн эмч, эмнэлгийн ажилтнуудаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гомдол гаргах эрхийг эдэлнэ.

Эмчлүүлэгчийн хариуцлага

Эмчлүүлэгч эрхээ эдлэхийн зэрэгцээ тодорхой үүргийг хүлээдэг байна. Тухайлбал, эмчлүүлэгчийн хэрэглэж байгаа эм тариа, эрүүл мэндийн нөхцөл байдал, эрүүл мэндийн, хагалгааны түүх зэрэг шаардлагатай мэдээллийг эмчлэгч эмчдээ өгөх үүргийг хүлээнэ. Эмчлүүлэгч эмчийн заавар, эмчилгээг цаг тухайд нь хийх, биеийн тамираар хичээллэх, архи, тамхи хэрэглэхгүй байх зэрэг өөрийн эрүүл мэндийг сайжруулахын төлөө амьдралынхаа хэв маягт анхаарах үүргийг хүлээнэ. Мөн эмч, сувилагч, бусад

эмчлүүлэгчиддээ хүндэтгэлтэй хандаж, эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрөө цаг тухайд төлөх үүргийг хүлээнэ гэжээ.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт Иргэн эрүүл мэндээ хамгаалах талаар дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ гэж заажээ.

- Эмч, эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авах;
- Өрхийн эмчээ сонгон бүртгүүлэх;
- Өөрийн эрүүл мэндийн тухай мэдээллийг эмч, эрүүл мэндийн байгууллагаас авах;
- Халдварт өвчнөөс бусад тохиолдолд эмчилгээ, оношлогоо, шинжилгээ хийлгэхээс татгалзах;
- Хүний эрүүл мэндэд харш үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний талаар холбогдох байгууллагад өргөдөл, гомдол гаргах;
- Эрүүл мэндийн боловсролоо дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллага, ажилтнаас мэдээлэл авах;
- Хуулийн хүрээнд өөрийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийн нууцыг хадгалуулах.

Иргэн эрүүл мэндээ хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

- Эрүүл мэндийн боловсрол эзэмших, хэвшүүлэх, амьдрал ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар зохиож байгаа ажилд оролцох;
- Халдварт өвчин тархахаас сэргийлж, хөл хорионы дэглэмийг сахиж мөрдөх;
- Хүний эрүүл мэнд болон нийгэмд аюул бүхий өвчин, хордлого, осол, гэмтэл, орчны сөрөг хүчин зүйлийн талаар эрүүл мэндийн байгууллагад цаг тухайд нь мэдээлэх;
- Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлт зан үйлээс татгалзах, сэргийлэх, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх үйлдлийг таслан зогсоох талаарх эрүүл мэндийн байгууллагын шаардлагыг биелүүлэх;
- Халдварт өвчний үзлэг, шинжилгээнд өөрийн санаачилгаар болон эмч, эмнэлгийн байгууллагын шаардлагаар орох;
- Эмнэлгийн яаралтай тусламжаас бусад эмнэлгийн тусламжийг өрх, сум, тосгон, сум дундын эрүүл мэндийн байгууллагын ерөнхий мэргэжлийн эмчийн илгээх бичгээр авах;
- Эрүүл мэндийн ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж байхад саад учруулахгүй, нэр хүнд, бие махбодид нь халдахгүй байх;
- Эрүүл мэндийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй, эрүүл мэндийн байгууллагын нэр хүндийг унагаах зорилго бүхий ташаа мэдээлэл өгөхгүй байх.

Эдгээр эрхийг баталгаатай эдлэхэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдээс гадна иргэдийн эрхээ мэдэх, зөрчигдсөн тохиолдолд сэргээлгэхийг шаардах хүний эрхийн боловсрол чухал юм.

Төр үүргээ биелүүлж чадахгүй бол яах вэ?

Иргэд төрийн холбогдох байгууллага, удирдлагатай хариуцлага тооцохыг шаардах, зөрчигдсөн эрхээ сэргээх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр төрөөс шаардах эрхийг баталгаажуулсан. Холбогдох байгууллага гэдэгт тухайн албан хаагч, эсвэл байгууллагын дээд

шатны удирдах эрх бүхий этгээдэд, мөн иргэний болон захиргааны хэргийн шүүхэд, Хүний эрхийн Үндэсний Комисст, Үндсэн хуулийн цэцэд хандаж өөрийн эрхээ шаардаж болно.

Нэмж унших эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр
3. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал
4. “Хүний эрх” НҮБ-ын ажилтнуудад зориулсан гарын авлага, Улаанбаатар хот, 2002 он
5. Хүний эрхийн товч тайлбар, ХЭҮК, Улаанбаатар хот, 2012 он
6. “Хүний эрх” эмхэтгэл, ХЭҮК, Улаанбаатар хот, 2014 он

Дасгал. Динамика (эрх мэдлийн алхалт)

Нийгмийг өөрчлөхөд шаардагдах хүний эрхийн боловсролын үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хүний эрхэд суурилсан хандлагыг ашиглах нь нэн чухал. Нийгэмд байгаа эрх мэдлийн тэнцвэргүй байдал, түүний шалтгаан нөхцөл, нийгэмд ялгаварлагдсан, орхигдсон бүлэг хүмүүст хүрч ажиллах нь хүний эрхийг хамгаалагч бидний үүрэг байдаг.

Энэхүү дасгал нь 2 хэсгээс бүрдэнэ.

А хэсэг: Динамика дасгалд оролцогчдыг оролцуулна.

Б хэсэг: Чиглүүлэгч бүлгийн хэлэлцүүлгийг өрнүүлнэ.

А хэсэг: Динамика (15 минут)

Нийгэмд эзлэх байр сууриар өөр өөр дүрүүдийг оролцогч бүрт тараан өгч нэгэн шугаманд зогсооно. Дүрээ бие биедээ харуулахгүйг оролцогчдод сануулж, нэгэн шугаманд жагсаж зогссон оролцогчдоос урьдчилан бэлтгэсэн асуулт асууна, тийм гэж хариулбал урагшаа нэг алхана, үгүй гэж хариулбал хойш нэг алхана.

Б хэсэг: Хэлэлцүүлэг (15 минут)

Чиглүүлэгч 10 орчим асуулт асуусны дараа дараах асуултын дагуу хэлэлцүүлэг өрнүүлнэ.

- Динамика дасгалын явцад хойшоо алхсан хүмүүст бид хэрхэн хүрч ажиллах вэ?
- Хүний эрх нийгэмд байгаа эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг зохицуулж чадах уу?

Урьдчилан бэлтгэсэн асуултууд:

1. Би төрийн байгууллагын албан хаагчтай уулзах боломжтой
2. Би өдөр тутмын сонинг байнга уншдаг
3. Би радио дуртай үедээ сонсох боломжтой (техникийн болон цаг зав бий)
4. Би дунд сургуульд элсэн орох гэж байгаа
5. Би эрүүл аюулгүй орчинд амьдарч чаддаг

6. Би төрийн үйлчилгээг хүртэхдээ ямар нэгэн ялгаврлан гадуурхалт, гутаан доромжлолд өртдөггүй
7. Би шаардлага гарвал хувийн эмнэлэгт төлбөр төлж эмчилгээ хийлгэдэг
8. Би өдөрт хамгийн багадаа 3 удаа иж бүрэн хооллож чаддаг
9. Би өөрийн жижиг бизнесээ эрхлэн явуулах боломжтой
10. Би төсвөөс зарцуулах мөнгөн дүнг сонирхон асууж чаддаг
11. Би хувьдаа хуулийн зөвлөх эсхүл хуульч хөлсөлж авах боломжтой.

Урьдчилан бэлтгэсэн дүрүүд:

Орон нутгийн захиргаанд зөвлөх	16 настай биеэ үнэлэгч, эмэгтэй
Сумын засаг дарга	30 настай бэлэвсэн эмэгтэй, 3 хүүхэдтэй, ажилгүй, дүрвэгч
Орон нутгийн сургуульд багш эмэгтэй	Ядуусын хороололд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй, өсвөр насны охин
Дүүргийн цагдаа 52 настай, эрэгтэй	Орон нутгийн прокурор
Бага сургуулийн сурагч хүү, 12 настай	17 настай ажил мэргэжилгүй залуу
Бага сургуулийн сурагч хүү, 12 настай	НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн төлөөлөгч, эрэгтэй
5 хүүхэдтэй 31 настай бэлэвсэн эмэгтэй Үндэсний Хөгжлийн ТББ-ын тэргүүн, эмэгтэй	Улс төрийн намын тэргүүн, эрэгтэй
Хувцасны үйлдвэрт ажилладаг эмэгтэй, сард 100.000 төг-ийн орлоготой	Орон нутгийн сэтгүүлч, эмэгтэй, 26 настай
Үндэсний ТВ сувгийн захирал, эрэгтэй, 47 настай	Улсдаа эхний тавд багтах баян эмэгтэй, 37 настай
Яллагдагч, эрэгтэй, 23 настай	Орон нутгийн дунд сургуулийн багш, эрэгтэй

Чиглүүлэгч асуултыг өөрчлөх мөн шинээр дүр нэмж оруулах боломжтой.

Зорилго

Хүний эрхийг ямар нөхцөлд, ямар шалгуураар хязгаарладаг талаар ойлголтыг өгөх

Зохиомжит дасгал

10 мин

Бидний мэдэх 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн кейсийг ашиглан оролцогчидтой хэлэлцүүлэг өрнүүлнэ. Онц байдал зарлаж тодорхой эрхүүдийг хязгаарласан. Асуулт:

- Ямар эрхүүдийг хязгаарласан бэ?
- Хүний эрхийн хязгаарлалтыг зохих ёсоор хийсэн үү?
- Хүний эрх зөрчигдсөн эсэх?

Чиглүүлэгчийн уншсан байх мэдээлэл

Хүний эрх хязгааргүй юу?

Аливаа эрх эдлэх нь ямагт үүргийг өөртөө дагуулдаг ойлголт юм. Түүнээс гадна эрх гэдэг нь хязгааргүй боломж биш бөгөөд тодорхой хэм хэмжээгээр хязгаарлагдаж болох зүйл аж.

Хүний эрхийг ХЯЗГААРЛАЖ БОЛНО.

Зайлшгүй нөхцөл байдал үүссэн, бусад хүний эрх эрх чөлөөг хамгаалах зорилгын үүднээс гагцхүү хуулиар хүний эрхийг хязгаарлах нь ардчилсан нийгэмд төрөөс хүний эрхийг хангах чухал зарчим болдог.

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгаа нь хөндөгдсөн эрхийг сэргээх хууль зүйн боломжийг бүрдүүлэх, бусдын эрх эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх, зөрчигчдөд хууль зүйн хариуцлага оногдуулах зэргээр илрэлээ олдог. Өөрөөр хэлбэл хүний эрхийг хуульд заасан үндэслэл журмын дагуу хязгаарлах нь бусдын эрх эрх чөлөөг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх зорилготой байдаг тул зарим тохиолдолд хүний эрхийн баталгаа болдог байна. Тодруулбал гоц халдварт өвчин дэгдлээ гэхэд тухайн орон нутагт байгаа хүмүүсийн дунд хөл хорио тогтоож, өөр зүг зорчихыг тодорхой хугацаанд хязгаарладаг. Энэ нь олон нийтийн дунд өвчин тарж хүмүүсийн эрүүл мэнд доройтох, ноцтой байдалд орохоос урьдчилан сэргийлж байгаа арга хэмжээ юм.

Ардчилсан нийгэмд хүний эрхийн хязгаарлалтыг хоёр тохиолдолд хийдэг. Эхнийх нь бусдын эрх эрх чөлөөг зөрчсөн этгээдийн тодорхой эрхийг хууль тогтоомжид заасан үндэслэлээр шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр хязгаарладаг бол удаах нь:

1. Үндэсний аюулгүй байдал
2. Нийгмийн хэв журам
3. Нийтийн эрүүл мэнд
4. Ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно.

Хүний эрхийг хязгаарлахдаа:

Хүний эрхийг ямар нөхцөлд, хэрхэн хязгаарлахыг хуулиар урьдчилан зохицуулсан байх ёстой;

- Ийнхүү хязгаарлах нь шударга ёс, хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн байх ёстой;
- Хүний эрхийг хязгаарлах хэмжээ нь хязгаарлах болсон зорилготой тэнцүү чанартай байх ёстой. (Хязгаарлалт зорилгоос хэтэрсэн байж болохгүй) Жишээлбэл, жагсаал цуглааныг албадан тараах журмыг хуульд нарийвчлан заагаагүй бөгөөд нийгмийн хэв журам, нийтийн эрүүл мэнд, ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөөнд хохирол учруулахааргүй илт тайван жагсаал, цуглааныг албадан тараах нь хүний эрхийн зөрчил болно.

Төр нь хүний зарим эрхийг хязгаарлах эрхтэй ч ямар ч тохиолдолд дараах эрхүүдийг хязгаарлаж болохгүй. Үүнд: хүний амьд явах, эрүү шүүлтээс ангид байх, өөрийнх нь сайн дурын зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн, эсвэл шинжлэх ухааны туршилтаас ангид байх, боолчлол, сайн дурын бус боолын байдлаас ангид байх, үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх зэрэг эрх, эрх чөлөө хамаарна.

Хүний эрхийг хязгаарлах нь олон улсын стандартаар хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Тухайлбал нийгмийн аюулгүй байдлыг хамгаалахад шаардлагатай онцгой нөхцөл байдал үүссэн, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүний үндсэн эрх эрх чөлөөг хамгаалах гэх мэт. Гэхдээ хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээ нь зохистой түвшинд буюу хэтрэхгүй байх зарчимд нийцэх учиртай. Онц байдал тогтоосон үед хүний эрх зөрчигдөх магадлал өндөр байдаг тул төрөөс онц байдал тогтоосон үед тухайн нөхцөл байдалд тохируулан хязгаарлалтыг зохистой хэмжээнд, түр зуурын хугацаанд хийх нь чухал байдаг.

I. Хязгаарлалтын нөхцөлүүд

- A. Хязгаарлалтыг зөвтгөхтэй холбогдох, тайлбарласан шинжтэй ерөнхий зарчмууд
- B. Тодорхой хязгаарлалтын нөхцөлүүдтэй холбогдох, тайлбарласан шинжтэй ерөнхий зарчмууд
 - i. “хуульд заасны дагуу”
 - ii. “ардчилсан нийгэмд”
 - iii. “нийтийн дэг журам (ordre public)”
 - iv. “нийтийн эрүүл мэнд”
 - v. “нийтийн ёс суртахуун”
 - vi. “үндэсний аюулгүй байдал”
 - vii. “нийтийн аюулгүй байдал”
 - viii. “бусдын эрх, эрх чөлөө” эсхүл “бусдын эрх, алдар хүнд”
 - ix. “нийтийн шүүх хурал дахь хориг”

II. Онц байдлын үеэр хязгаарлалт хийхэд анхаарах асуудлууд

- A. “Улс орны амьдралд заналхийлэх онц байдал”
- B. Онц байдал зарлах, мэдэгдэх, зогсоох
- C. “Нөхцөлөөс үүдэлтэй хүндрэлийг зайлшгүй шаардсан байх”
- D. Татгалзаж болшгүй эрхүүд

- Е. Онц байдал болон сөрөг дагаварт татгалзах арга хэмжээг танилцуулах, ашиглах зарим ерөнхий зарчмууд
- Ү. Хүний эрхийн хороо болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын чиг үүрэг, үүрэгт анхаарсан зөвлөмжүүд

I. ХЯЗГААРЛАЛТЫН НӨХЦЛҮҮД

A. Хязгаарлалтыг зөвтгөхтэй холбогдох, тайлбарласан шинжтэй ерөнхий зарчмууд*

1. Тухайн Пактын нэр томъёонд зааснаас илүүтэйгээр Пактаар баталгаажуулсан эрхүүдэд хязгаарлалт, эсвэл учир шалтгааныг ашиглаж болохгүй.
2. Пактад дурдсан хязгаарлалтын хүрээг холбогдох эрхүүдийн мөн чанаруудад аюул заналхийлэх замаар тайлбарлаж болохгүй.
3. Хязгаарлалтын бүх нөхцөл нь зайлшгүй, асуудалд хамаарах эрхүүдийн талд тайлбарлана.
4. Бүх хязгаарлалт нь илэрхий, холбогдох эрхийн хүрээнд тайлбарлана.
5. Пактаар хүлээн зөвшөөрсөн тухайн эрхэд тавигдах бүх хязгаарлалт нь хуульд заасан, Пактын заалт, зорилготой нийсэн байна.
6. Пактад заасан хязгаарлалтыг тодорхойлсноос өөрөөр ямар ч зорилгоор ашиглаж болохгүй.
7. Хязгаарлалтыг дур зоргын шинжтэй ашиглаж болохгүй.
8. Тавьсан хязгаарлалт бүрээс татгалзах, зүй бусаар ашигласны улмаас хохирлоо барагдуулах боломжтой байна.
9. Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхэд тавигдах хязгаарлалт нь Пактын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн эсрэг ялгаварлан гадуурхаж болохгүй.
10. Пактад заасны дагуу шаардагдсан хязгаарлалт нь “шаардлагатай” байсан ч энэхүү нэр томъёо нь хязгаарлалтыг:
 - (a) тухайн Пактын холбогдох зүйлээр хүлээн зөвшөөрсөн, хязгаарлалтыг зөвтгөх нөхцөлүүдийн нэгэнд суурилсан,
 - (b) тулгарч буй нийтийн эсхүл нийгмийн хэрэгцээнд хариу үзүүлдэг,
 - (c) хууль ёсны үүднээс ханддаг,
 - (d) дээрх зорилгод харилцан тэнцэхүйц байна.Хязгаарлалтын хэрэгцээт байдалд хийх үнэлгээ бүрийг объектив байдлаас хийнэ.
11. Хязгаарлалтыг хэрэглэхдээ төр тухайн хязгаарлалтын зорилгод хүрэхэд шаардлагатайгаас илүү хориглосон арга хэмжээ хэрэглэж болохгүй.
12. Пактаар баталгаажуулсан эрхэд тавигдсан хязгаарлалтыг зөвтгөх үүргийг төр хүлээнэ.
13. Аливаа хоригууд Пактад хүлээн зөвшөөрсөн бусад эрхүүдтэй нийцэх тухай Пактын 12 дугаар зүйлд заасан шаардлага нь Пактад хүлээн зөвшөөрсөн бусад эрхүүдэд тавих хязгаарлалтуудтай маргаангүй байна.
14. Пактын хязгаарлалтын нөхцлүүд нь тухайн улсын заавал биелүүлэх өргөн хүрээний олон улсын бусад үүргээр хамгаалсан хүний эрх эдлэхийг хориглохоор тайлбарлаж болохгүй.

B. Тодорхой хязгаарлалтын нөхцөлүүдтэй холбогдох, тайлбарласан шинжтэй ерөнхий

* Эдгээр зарчмууд дахь “хязгаарлалт” гэсэн нэр томъёо нь Пактад ашигласан “хориг” гэсэн нэр томъёог агуулсан болно.

зарчмууд

"хуульд заасны дагуу"

15. Хүний эрхийг эдлэхэд тавих хязгаарлалт нь Пакттай нийцсэн бөгөөд хязгаарлалт тогтоосон үеэс хүчин төгөлдөр болох нийтлэг үйлчлэх үндэсний хуулиар хангаагүй бол байж болохгүй.
16. Хүний эрхийг эдлэхэд тавих хязгаарлалтыг тогтоосон хууль тогтоомж нь дур зоргын эсвэл учир шалтгаангүй байж болохгүй.
17. Хүний эрхийг эдлэх явдлыг хязгаарлаж байгаа эрх зүйн дүрэм журам нь хүн бүрт илэрхий, хүртээмжтэй байна.
18. Хүний эрхийн хязгаарлалтыг хууль бус эсвэл зүй бусаар тогтоох буюу ашиглахын эсрэг зохистой аюулгүй хамгаалал, үр нөлөөтэй нөхөн сэргээх арга хэмжээг хуулиар хангана.

"ардчилсан нийгэмд "

19. "Ардчилсан нийгэмд" гэсэн хэллэг нь хязгаарлалтын нөхцлүүдэд цаашид хязгаарласан хориг тогтоодог гэж тайлбарлаж болно.
20. Хязгаарлалт тогтоосон улс нь хязгаарлалт тухайн нийгмийн ардчилсан чиг үүрэг гүйцэтгэхэд саад болохгүйг харуулсан байхыг шаардана.
21. Хэдийгээр ардчилсан нийгмийн дан ганц загвар байхгүй ч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг нийгмийг энэ тодорхойлолттой нийцэж байна гэж үзэж болно.

"нийтийн дэг журам (ordre public)"

22. Пактад ашигласан "нийтийн дэг журам" гэсэн хэллэг нь нийгмийн чиг үүргийг гүйцэтгэх явдлыг баталгаажуулах дүрэм журмын нийлбэр эсвэл нийгмийг байгуулсан суурь зарчмуудын цогц гэж тодорхойлж болно. Хүний эрхийг хүндэтгэх нь нийтийн дэг журмын (ordre public) хэсэг юм.
23. Нийтийн дэг журам (ordre public) нь энэ хэсэгт хязгаарлагдсан тодорхой хүний эрхийн зорилгын хүрээнд тайлбарлана.
24. Нийтийн дэг журмыг хадгалах хариуцлага хүлээсэн төрийн байгууллагууд буюу агентлагууд нь парламент, шүүх, холбогдох бусад хараат бус этгээдүүдээр дамжуулан, өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хяналт тавих субъект болно.

"нийтийн эрүүл мэнд"

25. Нийтийн эрүүл мэнд нь хүн амын эсвэл хүн амын салангид гишүүдийн эрүүл мэндэд ноцтой аюул заналын эсрэг арга хэмжээ авахыг төрд зөвшөөрөхийн тулд тодорхой эрхийг хязгаарлах газарт тооцож болно. Эдгээр арга хэмжээ нь өвчин эсвэл гэмтлээс урьдчилан сэргийлэх, эсвэл өвчтэй, гэмтсэн хүмүүст халамж үзүүлэхэд тусгайлан чиглэх ёстой.
26. Үүний тулд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын олон улсын эрүүл мэндийн зохицуулалтыг агуулна.

"нийтийн ёс суртахуун"

27. Нэг соёлоос нөгөө соёлын хооронд удаан хугацаанд нийтийн ёс суртахуун нь өөрчлөгдөж ирсэн тул хүний эрхийг хязгаарлах үндсийн нэгийг нийтийн ёс суртахуун болгосон улсын

хувьд тодорхой сонголтын хүрээг эдлэхдээ хүй элгэний суурь үнэт зүйлсийг хүндэтгэх баталгааг хязгаарлалтад зүй ёсоор тавихыг заана.

28. Сонголтын хүрээг улсууд Пактад заасны дагуу үл ялгаварлах журамд ашиглахгүй үлдээнэ.

"үндэсний аюулгүй байдал"

29. Тодорхой эрхийг хязгаарлах арга хэмжээг үндэстний оршихуй эсвэл газар нутгийн бүрэн бүтэн байдал, хүч хэрэглэхийн эсрэг улс төрийн тусгаар байдал, хүч хэрэглэх заналхийллээс хамгаалахын тулд хийсэн бол үндэсний аюулгүй байдал гэж зөвтгөж болно.

30. Үндэсний аюулгүй байдал нь хууль, дэг журамд заналхийлсэн зөвхөн орон нутгийн эсвэл харьцангуй салангид аюулаас урьдчилсан сэргийлэхийн тулд хязгаарлалт тогтоох шалтгаан болохгүй.

31. Үндэсний аюулгүй байдлыг тодорхой бус эсвэл дур зоргын хязгаарлалт тогтоохын тулд шалтгаан болгож ашиглаж болохгүй ба зөвхөн хангалттай аюулгүй арга хэмжээ, эрх хамгаалах үр нөлөөтэй хэрэгсэл байгаа үед зүй бус үйлдлийн эсрэг хэрэглэж болно.

32. Хүний эрхийн дэс дараалсан зөрчил нь үндэсний бодит аюулгүй байдлыг дордуулж, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг аюулд учруулж болзошгүй. Энэ зөрчилд хариуцлага хүлээх улс нь үндэсний аюулгүй байдлыг тухайн зөрчилд үзүүлэх эсэргүүцлийг далдлах, эсвэл хүн амын эсрэг залхаан цээрлүүлэх туршлага үйлдэхэд чиглэсэн арга хэмжээг зөвтгөхөд ашиглаж болохгүй.

"нийтийн аюулгүй байдал"

33. Нийтийн аюулгүй байдал гэдэгт хүмүүсийн аюулгүй байдал эсвэл тэдний амь нас, бие махбодын бүрэн бүтэн байдал, тэдний өмчид ноцтой хохирол учрах аюулаас хамгаалахыг хэлнэ.

34. Нийтийн аюулгүй байдлыг хамгаалах хэрэгцээ нь хуулиар хангасан хязгаарлалтыг зөвтгөж болно. Үүнийг тодорхой бус эсвэл дур зоргын хязгаарлалт тогтоохын тулд шалтгаан болгож ашиглаж болохгүй ба зөвхөн хангалттай аюулгүй арга хэмжээ, эрх хамгаалах үр нөлөөтэй хэрэгсэл байгаа үед хэрэглэж болно.

"бусдын эрх, эрх чөлөө" эсхүл "бусдын эрх, алдар хүнд"

35. Бусдын эрх, эрх чөлөөний хүрээ нь Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөөний хүрээнээс гарч Пактад заасан эрхүүдэд хязгаарлалт болох боломжтой.

36. Пактаар хамгаалсан эрх болон хамгаалаагүй эрхийн хооронд зөрчилдөөн гарсан бол Пакт хамгийн суурь эрх, эрх чөлөөг хамгаалахыг эрэлхийлдэг байдлыг хүлээн зөвшөөрөх, хэлэлцэхдээ анхаарна. Энэ тохиолдолд илүү их жинг Пактад заасан хязгаарлалтад орохгүй эрхүүд дарна.

37. Бусдын алдар хүндэд суурилсан хүний эрхэд тавигдах хязгаарлалт нь төрийг эсвэл төрийн албан хаагчдыг олон нийтийн байр суурь, эсвэл шүүмжлэлээс хамгаалахад ашиглаж болохгүй.

"нийтийн шүүх хурал дахь хориг"

38. Шүүх дараах зүйлсийг хуулиар тодорхойлсноос бусад тохиолдолд бүх шүүх олон нийтэд нээлттэй байна. Үүнд:

- (a) Хэвлэл, эсвэл олон нийтийг шүүх хуралдаанд оролцогчдын эсвэл тэдний гэр бүлийн, насанд хүрээгүй хүмүүсийн хувийн амьдралд хамаарах ашиг сонирхол нь нээлттэй шүүх хурлын үеэр зарлах тодорхой баримт материалтай хамааралтайг үндэслэн шүүх хурлын бүх буюу зарим хэсгээс гаргаж болно.
- (b) шүүхийн шударга байдалд хохирол учруулахуйцаар нийтэд мэдээлэх буюу ардчилсан нийгэм дэх нийтийн ёс суртахуун, нийтийн дэг журам, эсвэл үндэсний аюулгүй байдалд аюул заналхийлсэн явдлаас зайлсхийх зайлшгүй шаардлагын үүднээс гаргасан байна.

II. ОНЦ БАЙДЛЫН ҮЕЭР ХЯЗГААРЛАЛТ ХИЙХЭД АНХААРАХ АСУУДЛУУД

A. "Улс орны амьдралд заналхийлэх онц байдал"

- 39. Оролцогч улс нь зөвхөн улс орны амьдралд заналхийлсэн үл давтагдах, бодит эсвэл болох гэж байгаа аюултай нөхцөл тулгарсан тохиолдолд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 4 дүгээр зүйлд заасан өөрийн үүргээс татгалзсан арга хэмжээг (цаашид "татгалзах арга хэмжээ" гэх) авч болно. Улс орны амьдралд заналхийлэх гэдэгт:
 - (a) бүх хүн амд эсвэл тухайн улсын газар нутгийн бүх эсвэл зарим хэсэгт нөлөөлж байгаа
 - (b) хүн амын бие махбодын бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнол эсвэл тухайн улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал буюу Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхүүдийг баталгаажуулах, хамгаалахад зайлшгүй шаардлагатай байгууллагуудыг орших эсвэл үндсэн үйл ажиллагаагаа явуулахад аюул заналхийлэхийг хэлнэ.
- 40. Улс орны амьдралд ноцтой, болох гэж байгаа аюул заналхийлэлд багтдаггүй дотоодын зөрчил, үймээн самуун нь 4 дүгээр зүйлд зааснаар татгалзсаныг зөвтгөхгүй.
- 41. Эдийн засгийн хүндрэл бэрхшээлээр татгалзах арга хэмжээг зөвтгөхгүй.

B. Онц байдал зарлах, мэдэгдэх, зогсоох

- 42. Пактад заасан өөрийн үүргээс татгалзсан оролцогч улс нь улс орны амьдралд заналхийлсэн тул онц байдал тогтоосон тухай албан ёсоор зарлана.
- 43. Онц байдал зарлах тухай үндэсний хуульд заасан журмыг онцгой байдлаас өмнө тогтооно.
- 44. Пактад заасан өөрийн үүргээс татгалзсан оролцогч улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан Пактын бусад оролцогч улсад ямар зүйлсээс татгалзсан, эхлүүлсэн шалтгааныг яаралтай мэдэгдэнэ.
- 45. Мэдэгдэл нь оролцогч улсуудад Пактад заасан өөрийн эрхийг эдлэх, үүргээс чөлөөлөгдөхийг зөвшөөрөх хангалттай мэдээллийг агуулна. Тодруулбал үүнд:
 - (a) Пактын татгалзсан зүйлүүд;
 - (b) үндсэн хуулийн заалтын хамт онц байдал тогтоосон хуулбар, хууль тогтоомж, эсвэл оролцогч улсууд татгалзах хүрээг бодитойгоор үнэлэн дүгнэхэд туслахын тулд онц байдал тогтоосон зарлиг;
 - (c) онц байдал тогтоох хүчин төгөлдөр хугацаа болон зарласан байх үе;
 - (d) онц байдал зарлахад хүргэсэн баримт бүхий нөхцөл байдлын талаарх товч тодорхойлолтын хамт төр татгалзах шийдвэр гаргахад хүргэсэн шалтгааны тайлбар;
 - (e) мэдэгдэлд урьдчилан заасан эрхүүдээс татгалзсан тухай зарлигийн хуулбаруудыг

оролцуулан Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхүүдээс татгалзах арга хэмжээг авснаар гарах үр нөлөөг таамагласан товч тодорхойлолт багтана.

46. Оролцогч улсууд Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан олгох Пактад заасан өөрийн үүргийг гүйцэтгэхээр дэлгэрэнгүй мэдээллийг шаардаж болно.
47. Татгалзлын хэлбэрээс хамаарч яаралтай мэдэгдэл гаргаж чадаагүй оролцогч улс бусад улсын өмнө хүлээсэн өөрийн үүргийг зөрчсөнд тооцох ба эсрэг тохиолдолд Пактад заасан журмын дагуу боломжит хамгаалалтыг зөрчсөн байж болно.
48. 4 дүгээр зүйлийг мөрдлөг болгон татгалзах эрхийг өөртөө олгосон оролцогч улс нь улс орны амьдралд аюул заналхийлж байгаа онц байдлыг дуусгавар болгохын тулд хамгийн богино хугацаанд уг татгалзлыг зогсооно.
49. Оролцогч улс нь холбогдох татгалзлыг зогсоосон огноог Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар дамжуулан, бусад оролцогч улсуудад мэдээлнэ.
50. 4 дүгээр зүйлд заасан татгалзалыг зогсооход Пактаар хамгаалсан бүх эрх, эрх чөлөө бүрэн дүүрэн нөхөн сэргээнэ. Татгалзах арга хэмжээний үргэлжилсэн үр дагаврын дүгнэлтийг аль болох түргэн хийнэ. Шударга бус зүйлсийг засах, татгалзах арга хэмжээний үеэр шударга бус явдлаас эсвэл уг арга хэмжээний үр дагаварын улмаас хохирсон хүмүүст нөхөн төлбөр олгох арга хэмжээг авна.

C. "Нөхцөлөөс үүдэлтэй хүндрэлийг зайлшгүй шаардсан байх"

51. Татгалзах арга хэмжээний ноцтой байдал, үргэлжлэх хугацаа, газарзүйн хүрээ нь улс орны амьдралд аюул заналхийлсэн үйлдлээс хамаарч зайлшгүй шаардлагатай байх ба түүний мөн чанар, хир хэмжээтэй тэнцүү байна.
52. Холбогдох үндэсний байгууллагууд нь онцгой байдлын улмаас тулгарсан тодорхой аюулаас хамаарч авсан буюу санал болгосон аливаа татгалзах арга хэмжээний шаардлагыг тус тусдаа үнэлэх үүрэгтэй.
53. Пактын хязгаарлалтын тусгай нөхцөлүүдэд заасны дагуу энгийн арга хэмжээг зөвшөөрөх тухайн нөхцөлийн хэрэглээ шаардлагыг чанд шаарддаггүй арга хэмжээ нь улс орны амьдралд заналхийлсэн аюулаас хамааран тохирохуйц байна.
54. Зайлшгүй шаардлагын зарчмыг объектив байдлаар ашиглана. Арга хэмжээ бүр бодит, тодорхой, тухайн үеийн эсвэл болох гэж байгаа аюулд чиглэсэн ба гагцхүү боломжит аюулыг ойлгох чадвар төсөөлөлд тулгуурлаж болохгүй.
55. Тухайн улсын үндсэн хууль, онц байдлыг зохицуулах хууль нь татгалзах арга хэмжээний зайлшгүй байдлын талаар хууль тогтоох байгууллагын бие даасан шуурхай, ээлжит хэлэлцүүлгээр хангана.
56. Үр нөлөөтэй эрхийг хамгаалах хэрэгсэл нь тэдэнд нөлөөлж байгаа татгалзах арга хэмжээ нь тухайн нөхцөлийн хэрэглээ шаардлагатай нийцэхгүй байна гэж шаардлага тавьж буй хүмүүст тохиромжтой байна.
57. Тухайн нөхцөлийн хэрэглээ шаардлагад татгалзах арга хэмжээ хэрэгтэй эсэхийг тодорхойлоход үндэсний эрх мэдэл бүхий байгууллагуудын шийдвэрийг эцсийн гэж хүлээн зөвшөөрөхгүй.

D. Татгалзаж болохгүй эрхүүд

58. Оролцогч улс нь улс орны амьдралд аюул заналхийлсэн онц байдлын хугацаанд ч амьд явах эрх; эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх чөлөө; сайн дурын зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн, эсвэл шинжлэх ухааны туршилтаас ангид байх эрх чөлөө; боолчлол, сайн дурын бус боолын байдлаас ангид байх эрх чөлөө; гэрээнээс үүдэлтэй

өрийн улмаас хорихгүй байх эрх; буцааж хэрэглэсэн эрүүгийн хууль тогтоомжийн улмаас илүү хүнд ял яллах, эсвэл оноохгүй байх эрх; хуулийн өмнө этгээд гэдгийг хүлээн зөвшөөрөх эрх; үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөний Пактын баталгаанаас татгалзаж болохгүй. Улс орны амьдралыг хадгалах зорилготой байсан ч эдгээр эрхээс татгалзаж болохгүй.

59. Өөрийн хууль тогтоомжийн хүрээнд бүх хүмүүст эдгээр эрхийг эдлүүлэхийг баталгаажуулах (2 дугаар зүйлийн 2.1), зөрчлийн эсрэг үр нөлөөтэй эрх хамгаалах хэрэгслийг баталгаажуулах арга хэмжээг батлах (2 дугаар зүйлийн 2.1) өөрийн үүргийн нэг хэсэг болгон Пактад оролцогч улсууд нь хууль ёсны болон бүрэн бус хууль ёсны бүлгийн зүгээс дур зоргоор, шүүхээс гадуур хүний амь бүрэлгэж, эсвэл хүчээр алга болоход хүргэж байгаа эсэх, хоригдсон хүмүүс эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалагдсан эсэх, өнгөрсөн үед хамаарах хууль эсвэл зарлигийн дагуу ямар ч хүнийг буруутгахгүй буюу шийтгэхгүй байхыг баталгаажуулахын тулд онцгой байдлын хугацаанд урьдчилсан тусгай арга хэмжээ авна.
60. Ердийн шүүхүүд нь онц байдлын хугацаанд ч татгалзаж болохгүй эрхийг зөрчсөн тухай аливаа гомдлыг шийдвэрлэх өөрийн шүүн таслах мэдэлтэй байна.

Е. Онц байдал болон сөрөг үр дагаварт татгалзах арга хэмжээг танилцуулах, ашиглах зарим ерөнхий зарчмууд

61. Улс орны амьдралд аюул заналхийлсэн учир хариу арга хэмжээ авахаар олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрсөн эрхүүдээс татгалзах нь эрх зүйн орчинд хэрэгжихгүй. Энэ нь хуулиар зөвшөөрсөн ба нийтлэг үйлчлэх хэд хэдэн эрх зүйн зарчимд хамаарна.
62. Онц байдал зарлах нь улс орны амьдралд аюул заналхийлсэн зүйл байгаа бол хир хэмжээг нь тодорхойлохын тулд нөхцөл байдлын объектив үнэлгээнд суурилсан бат итгэл үнэмшилтэйгээр хийсэн байна. Онц байдал зарлах, Пактын үүргээс татгалзах үр дүн бүхий үйлдлийг бат итгэл үнэмшилгүй хийсэн бол олон улсын эрх зүйн зөрчил болно.
63. Онц байдлын үеэр тодорхой татгалзах үйлдлийг зөвшөөрсөн Пактын заалтуудыг хязгаарлагдмал байдлаар тайлбарлана.
64. Онц байдлын үед эрх зүйт ёс оршсоор байна. Татгалзах нь улс орны амьдралд аюул заналхийлсэн үйлдлийн эсрэг зохих хариу авах зорилготой зөвшөөрөгдсөн, хязгаарт онцгой эрх болно. Татгалзаж байгаа улс нь хуульд заасан өөрийн үйлдлийг зөвтгөх үүрэг хүлээнэ.
65. Пакт нь хүний эрхийн үндсэн зорилгод хамаарах бүх журамд захирагдана. Пактын 5 дугаар зүйлийн 5.1-т Пактад заасан үйлдэлд тавих бодитой хязгааруудыг тогтоосон байна. Үүнд:

Одоогийн Пактад заасан аль ч зүйлийг ямар нэг улс, бүлэг эсвэл этгээдэд энэхүү баримт бичигт хүлээн зөвшөөрсөн эсвэл одоогийн Пактад заасан аливаа эрх, эрх чөлөөг илүү их хэр хэмжээтэй хязгаарлалтаар устгахад чиглэсэн дурын үйл ажиллагаа явуулах буюу үйлдэл хийх эрхтэйгээр тайлбарлаж болохгүй.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлийн 29.2-т хуулийн туйлын зорилгыг заасан байна. Үүнд:

Хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхэд хүн бүр гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх явдлыг болон ардчилсан нийгэм дэх зөвхөн ёс суртахуун, нийтийн дэг журам, нийтлэг сайн сайхан байдлыг хамгаалах зорилгоор зөвхөн хуулиар тодорхойлсон хязгаарлалтуудад захирагдана.

Эдгээр заалт нь нөхцөл байдал нь улс орны амьдралд аюул заналхийлсэн үйлдэлд суурилж, үүний улмаас эрх мэдэл бүхий этгээд татгалзахыг бүрэн зөвшөөрсөн тохиолдолд бүрэн байдлаар хүчин төгөлдөр үйлчилнэ.

66. Пакт дахь тусгайлсан үүргээс татгалзахыг зөвшөөрдөг онц байдлын талаар бат итгэл үнэмшилтэйгээр зарлах үйлдэл нь олон улсын үүргээс нийтлэг байдлаар ухрахыг зөвшөөрөхгүй. Пактын 4 дүгээр зүйлийн 4.1 болон 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт нь олон улсын эрх зүйн дагуу хүлээх бусад үүрэгтэй нийцэхгүй байгаа татгалзах үйлдлийг тод томруун байдлаар хориглодог. Иймээс Женевийн болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцуудад заасны дагуу онц байдалд үйлчлэх олон улсын үүргийг тусгайлан анхаарч харгалзах ёстой.
67. Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд Дайны хохирогчдыг хамгаалах тухай 1949 оны Женевийн Конвенцуудын оролцогч улс нь ямар ч тохиолдолд хараат бус, тал харахгүй байх (1949 оны конвенцуудад 3 дүгээр зүйлд нийтлэг байдаг) заавал байвал зохих баталгааг санал болгох шүүхээр шүүлгэх эрхийг түдгэлзүүлж болохгүй. 1977 оны Нэмэлт протоколын дагуу дараах эрүүгийн мөрдөн байцаах ажиллагаатай холбоотой эрхүүдийг протоколд оролцогч улс бүхий л тохиолдолд хүндэтгэнэ. Үүнд:
- (a) өөрчлөлтийн талаар шуурхай мэдэгдэх, шаардлагатай эрх, хамгаалах арга хэрэгслийг олгох үүрэг;
 - (b) хувь хүнийг эрүүгийн хариуцлагын үндсэн дээр зөвхөн яллах;
 - (c) өнгөрсөн үед хамаарах эрүүгийн хууль тогтоомжийг үндэслэн илүү хүнд ялаар яллагдахгүй эсвэл шийтгэгдэхгүй байх эрх;
 - (d) гэмт буруугүйн презумци;
 - (e) яллагдсан этгээдийг шүүх хуралд байлцуулах;
 - (f) яллагдагч өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэм буруугаа өчих үүрэг хүлээхгүй байх;
 - (g) буруутгагдсан этгээдэд шүүхийн болон бусад эрх хамгаалах хэрэгслийн талаар зөвлөх үүрэг багтана.
68. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хүний эрхийн гол конвенцууд нь албадан хөдөлмөр, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, ажлын байран дахь тэгш эрх, үйлдвэрчний эвлэл, ажилтнуудын эрх зэрэг асуудалтай холбоотой онц байдлын үеэр татгалзахыг зөвшөөрөөгүй олон тооны эрхийг агуулах бусад эрхийг нөхцөл байдлын хэрэгцээ шаардлагатай зайлшгүй нийцсэн үед л татгалзахыг зөвшөөрдөг.
69. Онц байдлын хугацаанд ч ямар нэгэн улс болон Пактад оролцогч болоогүй улсыг хамруулан дараах эрхээс түдгэлзэх, эсвэл зөрчиж болохгүй. Үүнд:
- (a) амьд явах эрх;
 - (b) эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх болон сайн дурын зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн, эсвэл шинжлэх ухааны туршилтаас ангид байх эрх чөлөө;
 - (c) боолчлол, сайн дурын бус боолын байдлаас ангид байх эрх чөлөө;
 - (d) Пактад тодорхойлсон эрүүгийн ял шийтгэлийг буцааж хэрэглэхгүй байх эрх багтана.
- Олон улсын заншлын эрх зүй нь эдгээр суурь эрхүүдээс бүхий л нөхцөлд татгалзахыг хориглодог.
70. Хэдийгээр дур зоргоор баривчлах, хорихоос хамгаалуулах (9 дүгээр зүйл) болон эрүүгийн гэмт хэргийг тогтооход шударга, нийтийн сонсгол хийх эрх (14 дүгээр зүйл) нь зайлшгүй шаардлагатай онцгой нөхцөл байдлын хэрэгцээ шаардлагын улмаас хууль ёсны дагуу хязгаарлалтад өртөж болох ч тодорхой үндсэн эрхээс хүний нэр төрийг үгүйсгэх явдал ямар ч боломжийн онц байдлын үед шаардлагатай байж болохгүй. Эдгээр үндсэн эрхийг хүндэтгэх нь татгалзаж болохгүй эрхийг эдлэх явдлыг баталгаажуулах, эдгээр эрхийн

- зөрчлийн эсрэг үр нөлөөтэй эрх хамгаалах хэрэгслээр хангахад чухал болно. Ялангуяа:
- (a) бүх баривчлах, хорих үйлдэл, хорих газар нь боломжтой бол нэгдсэн байдлаар бүртгэсэн байх, нийтэд шуурхай хүргэх боломжоор хангах;
 - (b) шүүхийн мөрдөн байцаалт буюу шүүх хурал хойшилсон эсвэл гэмт хэрэгт буруутгахгүй саатуулсан эсэхээс үл хамааран хэнийг ч тодорхойгүй хугацаагаар саатуулахгүй байх;
 - (c) өөрийн гэр бүл, найз нөхөр, эсвэл өмгөөлөгчтэй холбогдохгүйгээр саатуулагдаж болохгүй;
 - (d) найруулах саатуулагдсан этгээдийг үргэлжлүүлэн хорих шаардлагатай бол хараат бус хяналтын шүүхээр тодорхой хугацаанд шалгасан байна;
 - (e) гэмт хэрэгт буруутгагдсан этгээд нь хуулиар байгуулсан тохирох, хараат бус, тал харахгүй шүүхээр шударга шүүлгэх эрхтэй;
 - (f) энгийн иргэд жирийн шүүхэд хандах ба цэргийн эсвэл тусгай шүүх байгуулах шаардлагатай тулгарвал түүний тохиромжит байдал, хараат бус, шударга байдлыг зохих эрх мэдэл бүхий байгууллага тодорхой хугацаанд шалгасан байна;
 - (g) эрүүгийн гэмт хэрэгт буруутгагдсан аливаа этгээд нь гэмт буруугүйн презумци эдлэх ба шударгаар шүүлгэхийг баталгаажуулахын тул наад зах нь дараах эрхийг эдэлнэ:
 - өөрийн ойлгодог хэлээр дэлгэрэнгүй байдлаар буруутгагдсан хэргийн талаар мэдээлэх авах эрх,
 - цагаатгах нотлох баримт бэлтгэх хангалттай хугацаатай байх эрх, өөрийн өмгөөлөгчтэй нууц хадгалж уулзах эрх,
 - хэрэв төлбөрийн чадваргүй бол эрх зүйн туслалцааг өөрийн сонгосон өмгөөлөгчөөс авах эрх,
 - шүүх хуралд оролцох эрх,
 - өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэм буруугаа өчихгүй байх эрх,
 - цагаатгах гэрчийг оролцуулах, асуулт тавих эрх,
 - зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэхээр тохирох хамгаалалт бүхий аюулгүй байдлыг хангасан шүүх журмын дагуу нийтийн өмнө байх эрх,
 - дээд шатны шүүхэд нэхэмжлэл гаргах эрх;
 - (h) хянан шийдвэрлэх ажиллагааны тохирох тэмдэглэлийг бүхий л хэрэгт хөтөлнө,
 - (i) ямар ч этгээд нэгэнт буруутгагдсан, эсвэл шийтгэгдсэн гэмт хэрэгт дахин шийтгэгдэх ёсгүй.

Нэмж унших эх сурвалж

Нэгдсэн Үндэстний Байгууллага, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, НҮБ-ын Ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, цөөнхийг хамгаалах талаарх дэд комисс, Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын заалтуудын хязгаарлалт болон татгалзах тухай Сиракусагийн зарчим, Хавсралт, НҮБ Баримт бичиг E/CN.4/1984/4 (1984).

Зорилго

Хүний эрхийн зөрчлийг бусад зөрчлөөс ялгах.

Дасгал

Алхам 1

Оролцогчдыг 5-6 хүнтэй бүлэгт хувааж даалгавар өгнө. Бүлэг тус бүр хүний эрхийн зөрчлийг зохиож “фото шот” буюу нийт 3 удаагийн зөрчлийн үйл явдлыг өрнүүлсэн үргэлжилж буй фото зургийг үйлдлээрээ бий болгоно. Бүлэг тус бүр фото шотыг үзүүлбэрээр үзүүлж бусад бүлгийнхнээр таалгана. Алхам 2

Мөн хуучин бүлгээрээ зөрчлийг арилгасан кейсыг зохиож “фото шот” буюу нийт 3 удаагийн зургаар харуулж бусад бүлгийнхнээр таалгана.

Чиглүүлэгчийн уншсан байх мэдээлэл

Аливаа улсад хүний эрх, эрх чөлөө нь үндэсний болон олон улсын эрх зүйгээр хамгаалагдсан гүйцэтгэх засаглалын хүрээнд хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хязгаарлах явдал гаргахаас сэрэмжилж чадсан, зөрчигдсөн тохиолдолд сэргээх шударга шүүхийн тогтолцоо бий болсноор хүн эрх, эрх чөлөөгөө хангагдаж, хамгаалагдсанд тооцох боломжтой юм. Мөн түүнчлэн хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хүний эрхийн үндэсний байгууллага, Үндсэн хуулийн шүүх, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үүрэг оролцоог орхигдуулах аргагүй. Ер нь хүний ямар эрх, яагаад, яаж зөрчигдөж байгаа, түүний буруутай эзэн, шалтгаан нь юу вэ гэдэг бол цөм асуудал мөн.

“Хүний эрхийн зөрчил” гэдэгт үндэсний хууль тогтоомж, олон улсын болон бүс нутгийн гэрээ, конвенцоор баталгаажуулсан хүний эрхийг төр өөрийнхөө ямар нэгэн үйлдлээр зөрчсөн, эсхүл төрөөс хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үүрэг биелэгдээгүй байхыг хэлнэ. Түүнчлэн төр хүний эрхийн хамгаалалтыг сулруулах, түүнээс татгалзах нь хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогддог.

Хүний эрхийн зөрчил нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, нэгдэн орсон олон улсын гэрээгээр баталгаажуулсан хүний эрхийн хэрэгжилтээр тодорхойлогдох боловч эрүү, иргэн, захиргааны эрх зүй гэх мэт салбар эрх зүйгээр зохицуулах харилцаанаас үүдэн гарсан зөрчил нь хүний эрхийн зөрчилд хамаарахгүй.

Эрүү, иргэн, захиргааны эрх зүйн харилцаанд гарч буй зөрчил ч гэсэн хүний эрхийн зөрчил байж болно.

Аливаа салбар эрх зүйгээр зохицуулагдаж буй нийгмийн тодорхой төрлийн харилцааг тухайн салбар эрх зүйн харилцаа гэдэг. Тиймээс иргэний, захиргааны, эрүүгийн эрх зүйн харилцааны явцад зөрчигдсэн эрх нь тухайн салбар эрх зүйгээр зохицуулагдах бөгөөд салбар эрх зүйг сахин хамгаалах тогтолцоог хуулиар бий болгосон байгаа. Энэ нь хууль, шүүхийн байгууллага юм.

Жишээ нь: Иргэн Д нь хулгайд эд зүйлээ алдаж, түүний өмчлөх эрх зөрчигджээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд хүний өмчлөх эрхийг баталгаажуулж, хуулиар хамгаалсан байдаг. Иргэн Д-ийн хувьд гэмт халдлагын улмаас өмчлөх эрх нь зөрчигдсэн талаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах эрх бүхий харьяалах байгууллагад гомдол гаргаж, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн хэм хэмжээний дагуу хууль сахиулах болон шүүхийн байгууллагаар зөрчигдсэн эрхээ сэргээлгэж болно.

Мөн “Иргэн Б, иргэн Ц-д зээлүүлсэн мөнгөө авч чадахгүй байгаагаас түүний өмчлөх эрх, шударгаар өмч хөрөнгө олж авах, нэмэгдүүлэх эрх зөрчигдөж байна” гэж байгаа нь хүний эрхийн зөрчил мөн гэж үзэх боловч энэ тохиолдолд иргэний хуулийн дагуу иргэний журмаар шүүхэд нэхэмжлэл гаргаж эрхээ сэргээлгэх боломжтой.

Мөн “Иргэн Б ажлаас үндэслэлгүй халагдсан талаар удаа дараа шүүхийн шийдвэрээр ажилдаа эгүүлэн тогтоогдож, дөрвөн жил гаруй хугацаанд энэ асуудлаар хөөцөлдөж шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гурван удаа ажилдаа орсон. Тухайн байгууллагын удирдлагаас “чамайг ажлаа хийхийг чинь харнаа”, “чи энд байя гэж бодож байгаа бол олон юм яриад байхгүй шүү”, “ажлын цагаар энэ байрнаас гарвал зөвхөн надаас чөлөөний хуудас бичүүлж гарах ёстой”, “шүүхийнхээ ажлыг зогсооно шүү” гэх зэргээр тайван ажиллаж, хөдөлмөрлөхөд нь саад учруулж, ажлын байрны дарамт үзүүлж байна. Иймд эдгээр албан тушаалтны хууль бус үйлдлийг таслан зогсоож хөдөлмөрлөх эрхийг хангаж өгнө үү гэсэн гомдлыг Хүний эрхийн Үндэсний Комисст ирүүлсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.”, Арван зургадугаар зүйлийн 4-т “... Хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах эрхтэй.” гэж тус тус заасан байна. Мөн Монгол Улс Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас батлан гаргасан Ялгаварлан гадуурхахгүй байх (Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) 111дүгээр конвенцийг 1969 онд соёрхон баталсан байна. Тус конвенцийн 1 дүгээр зүйлийн “а”-д “Ялгаварлан гадуурхах” гэдэг нь “арьс үндэс, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэс угсаа буюу нийгмийн гаралд үндэслэн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш боломж, хандлагыг үгүйсгэх буюу зөрчихөд хүргэж байгаа аливаа ялгаварлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдлийг ойлгоно.” гэжээ.

Иймд иргэн Б-ийн ажил хөдөлмөрөө хэвийн явуулах нөхцөл боломжийг хангаж ажиллах, түүнд ажлын байрны дарамт шахалт үзүүлж буй нэр бүхий албан тушаалтнуудад холбогдох дүрэм журмын дагуу дотоодын шалгалт хийж хариуцлага тооцох, цаашлаад байгууллагынхаа ажилчдыг хөдөлмөр эрхлэхэд нь аливаа ялгаварлал, хавчин гадуурхалтыг гаргахгүй байх талаар анхаарал хандуулж холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дах хэсэгт заасныг үндэслэн шаардлага хүргүүлж байсан бодит жишээ байна.

Иргэнээс төрийн захиргааны, хууль сахиулах болон шүүхийн байгууллагад хандаж байгаа үйл явцад, эсхүл тэдгээр байгууллагаас чиг үүргээ хэрэгжүүлэх үйл явцад хуулиар баталгаажуулсан хүний эрх зөрчигдсөн тохиолдолд ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ болно.

Хүний эрхийн зөрчилтэй холбоотой бусад мэдээлэл

Хүний эрхийн хамгаалагчид Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсанаас хойш жаран жил өнгөрсөн ч гэсэн бодит байдлаас хол зөрүүтэй зүйлс байсаар байгааг хүлээн зөвшөөрдөг. Дэлхийн өнцөг булан бүрт зөрчил тулгарч байна. Жишээлбэл, Эмнести Интернэшнл олон улсын байгууллагын 2009 оны Дэлхийн тайлан болон бусад эх сурвалжуудыг харахад хүмүүс:

- Багадаа 81 улсад эрүү шүүлт, зүй бус явдалд өртөж
- Багадаа 54 улсад шударга бус шүүхтэй нуур тулж
- Багадаа 77 улсад өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөгөө хязгаарлуулсан байна.

Үүгээр зогсохгүй ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг маш олон байдлаар гадуурхахын зэрэгцээ хэвлэл нь олон улсад чөлөөтэй биш, үүнтэй санал нийлээгүй хүмүүсийг тогтмол дуугүй болгож байна. Сүүлийн жарны хугацаанд зарим хүмүүс ахиц дэвшлийг олсон ч өнөөдөр дэлхий дээр хүний эрхийн зөрчил “тахал” мэт нэрвэсээр байна.

Дэлхий дахин дахь хүний эрхийн үнэн бодит нөхцөл байдлыг таниулахын тулд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зургаан зүйлийн зөрчлийг жишээ болгон үзүүлье.

ЧӨЛӨӨТЭЙ АМЬДРАХ ЭРХ

“Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй”

Афганистан Улсад болсон зэвсэгт мөргөлдөөний үеэр 2007 онд ойролцоогоор 6500 хүн үхсэн бөгөөд эдгээрийн тал орчим хувь нь босогчдын гарт амиа алдсан. Олон зуун иргэдийг зэвсэгт бүлгүүдийн амиа хорлосон дайралт хөнөөжээ.

Албан ёсны эх сурвалжид дурдсанаар, Бразил Улсад 2007 онд багадаа 1260 хүн цагдаагийн гарт амь үрэгдсэн нь урьд гараагүй өндөр тоо ажээ. Бүх тохиолдлыг “эсэргүүцлийн улмаас” гэж албан ёсоор тодорхойлж, мөрдөн байцаалт хийгээгүй байна.

Уганда Улсад долоо хоног бүр 1500 хүн дотооддоо дайжсан хүмүүсийн хоноглох газар үхдэг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр эдгээр хоноглох газруудад хагас сая хүн нас бараад байна.

Вьетнам Улсын эрх мэдэлтнүүд 75000 орчим мансууруулах бодисын донтон, биеэ үнэлэгчдийг хэт олон хүнтэй 71 “засан хүмүүжүүлэх” газарт хүчээр байрлуулж, ХДХВ/ДОХ-ын халдвар бүхий хүмүүжигчдийг “өндөр эрсдэлтэй” гэсэн тэмдэг хаддаг боловч ямар ч эмчилгээ үзүүлдэггүй байна.

БООЛЧЛОЛООС АНГИД БАЙХ

“Хэнийг ч боолчлох буюу бусдын эрхшээлд байлгах ёсгүй. Аливаа төрлийн боолчлол болон боолын худалдааг хориглоно.”

Уганда Улсын хойд хэсэгт Бурхны эсэргүүцлийн армийн партизанууд сүүлийн хорин жилд 20000 гаруй хүүхдийг барьцаалж, тэднийг армийн цэрэг эсвэл бэлгийн хэрэгцээг хангах боол болгосон байна.

Бүгд Найрамдах Гвинея-Бисау Улсад хүүхдийг таван настайгаас нь Сенегалын Улсын өмнөд хэсэгт байрлах хөвөнгийн талбайд ажиллуулахаар худалдах, эсвэл нийслэл хотдоо гуйлгачин болгодог байна. Гана Улсад 5-14 настай хүүхдийг сургуульд сургах, сайхан ирээдүйг худал амлах замаар хуурч, загасчлах салбарын цалин хөлсгүй ажил хийлгэдэг байна.

Ази тивийн хувьд, Япон Улс бол худалдагдсан эмэгтэйчүүд, ялангуяа Филиппин, Тайланд Улсаас ирэх эмэгтэйчүүдийг хүлээн авагч гол улс юм. НҮБ-ын Хүүхдийн сангийн тооцооноор Филиппин Улсад 60000 биеэ үнэлэгч хүүхэд байна.

АНУ-ын Төрийн департаментийн тооцооноор 600-820 мянган хүнийг жил бүр хилийн чанадад худалдаалдаг ба тэдний тал нь хүүхэд (Ирак Улсаас дүрвэсэн охид, эмэгтэйчүүд) ажээ. Канад, АНУ, Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улсыг хамруулан бараг бүх улсад хохирогчдод зориулсан туслах үйлчилгээ байхгүй бөгөөд засгийн газрын зүгээс улиг болсон албадан гаргах, түгшээх зэрэг арга хэмжээ авдаг.

Бүгд Найрамдах Доминикан Улсад хүний наймааны бүлгийн үйл ажиллагаа нь Гаитийн 25 цагаач ажилчдыг бүтэж үхэхэд хүргэжээ. 2007 онд хоёр иргэн, хоёр цэргийн алба хаагч энэ үйл ажиллагааны улмаас баривчлах ял авчээ.

Сомали Улсад 2007 онд 1400 гаруй дотооддоо дүрвэсэн Сомаличууд болон Этиопчууд хууль бусаар хил давахыг оролдож байгаад далайд амь насаа алджээ.

ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС АНГИД БАЙХ

“Хэнд ч эрүү шүүлт тулган эсхүл хэнтэй ч хэрцгийгээр, хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй.”

АНУ-ын эрх мэдэлтнүүд 2008 онд 270 хоригдлыг Куба Улсын Гуантанамогийн буланд ямар нэгэн хэрэгт буруутгалгүй, эсвэл шүүх хуралгүйгээр хорьж, “усан тавцан” гэх живүүлдэн тамладаг эрүү шүүлт хэрэглэхийг үргэлжлүүлсэн байна. Өмнөх Ерөнхийлөгч Жорж Буш олон улсын хэм хэмжээг зөрчсөн үйлдэл болохыг үл тоон, Тагнуулын Ерөнхий Газарт нууцаар баривчлах, байцаахыг үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байна.

Судан Улсын баруун хэсэгт байрлах Дарфур гэх бүс нутагт хүчирхийлэл, гэмт хэрэг, хүүхэд, эмэгтэйчүүдийг булаах явдал хөл толгойгоо алдсан ба гадны бүх тусламжийг тасалсан. Ялангуяа эмэгтэйчүүд цадиггүй дайралтын золиос болж, таван 7 хоногийн хугацаанд дотооддоо дайжсан хүмүүсийн хоноглох газарт 200 гаруй хүчиндэх гэмт хэрэг гарсан ч эрх баригчдын зүгээс гэмт хэрэгтнийг шийтгэх ямар ч оролдлого хийгээгүй.

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад эрүү шүүлт, зүй бусаар харьцах явдал нь засгийн газрын аюулгүй алба болон зэвсэгт бүлгийн дунд нийтлэг болсон ба баривчлах байранд зодох, саваадах, хүчиндэх энгийн үзэгдэл болжээ. Заримдаа хоригдлуудыг нууц хорих газарт шилжүүлдэг байна. 2007 онд Бүгд Найрамдах Гвард (ерөнхийлөгчийн харуул) Киншаса муж дахь Тусгай албаны цагдаагийн хэлтэс нь засгийн газрыг шүүмжилсэн гэж олон хүмүүсийг дур мэдэн баривчилж, эрүүдэн шүүсэн байна.

ЗОРЧИХ ЭРХ ЧӨЛӨӨ

- “1. Хэн боловч улсынхаа дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй.*
- 2. Хэн боловч аливаа улс орныг, түүний дотроо эх орноо орхин явах, эх орондоо эргэж очих эрхтэй.”*

Мьянмар Улсад мянга мянган иргэнийг хорьсоны дотор 700 гаруй улс төрийн хоригдол байх ба тэдний дунд Нобелийн шагналт Дау Аунг Сан Суу Кью ч бий. Түүний улс төрийн үйл ажиллагааны хариу болгож, түүнийг сүүлийн арван найман жилийн хугацаанд гэрийн хорионд оруулсан ба эх орноо орхивол суллах засгийн газрын саналыг татгалзсан байна.

Алжир Улсад дүрвэгсэд, хоргодох газар хайсан хүмүүс ямагт баривчлах, хөөж гаргах, зүй бусаар харьцах явдлын хохирогч болдог. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрвэгчдийн дээд комиссарын газраас албан ёсны дүрвэгчийн статус авсан Сахарын доод талын Африкийн улс орнуудаас ирсэн 28 хүнийг ямар нэгэн хуулийн зөвлөх, хэлмэрчгүйгээр Алжир Улс руу хууль бусаар нэвтэрсэн хэмээн буруутгаж, Мали Улс руу шилжүүлжээ. Тэднийг ямар ч хүнс, ус, эмнэлгийн тусламжгүйгээр цөлд байрлах Малигийн зэвсэгт бүлэг идэвхтэй байгаа нэгэн хотын дэргэд буулгажээ.

Кени Улсад эрх мэдэлтнүүд Сомали Улсад болсон зэвсэгт мөргөлдөөнөөс дүрвэсэн олон мянган хүмүүст хилээ хааснаар олон улсын дүрвэгсдийн эрх зүйг зөрчжээ. Хоргодох байр хайсан хүмүүсийг шүүх хурал, ямар нэгэн хэрэгт буруутгалгүй хууль бусаар Кени Улсын хил дээрээс баривчилж, хүчээр Сомали Улсад эргүүлэн өгчээ.

Уганда Улсын хойд хэсэгт 1.6 сая иргэд шилжин суурьшигчдын газарт амьдарч байна. Зэвсэгт мөргөлдөөнд хамгийн ихээр өртсөн Алчоли бүс нутагт 2005 онд 1.1 сая хүний 63 хувь нь шилжин явж, одоог хүртэл өөр газар амьдарсаар байгаа бөгөөд 2007 оныг 7000 хүн өөрийн эх газраа эргэн очжээ.

БОДОЖ СЭТГЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

“Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана.”

Мьянмар Улсад цэргийн хунтын дэглэм тайван замаар жагсаж байсан лам нар руу дайрч довтлон, сүм хийдийг хааж, өмч хөрөнгийг хураан эвдэлж, буудах, зодох, баригдсан жагсагчидтай зүй бусаар харьцах, тэдний найз нөхөд, гэр бүлийн гишүүдийг барьцаалсан байна.

БНХАУ-д Фалун Гунг сургаалийг дагагчид баривчлагдсан байхдаа эрүү шүүлт, зүй бус үйлдлийг золиос болсон бол Христүүд төрөөс заасан сувгаас гадуур шүтэж биширсэн гэж шийтгүүлсэн байна.

Казакстан Улсад Алмата хотын ойр байрлах нэгэн хүй элгэний орон нутгийн удирдлага Харе Кришна урсгалын гишүүдэд бүгд хамаарах 12 байшинг устгахыг зөвшөөрч, эдгээр байшинг хууль бусаар тухайн газарт барьсан хэмээн худал буруутгасан байна. Зөвхөн энэ хүй элгэнд амьдрах Харе Кришна урсгалыг дагагчдын байшинг л устгажээ.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ

“Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.”

Судан Улсад олон тооны хүний эрхийн хоёр хамгаалагчдыг үндэсний тагнуулын алба, аюулгүй албаныхан баривчилж, эрүүдэн шүүсэн байна.

Этиоп Улсад нэр хүндтэй хүний эрхийн хамгаалагчийг худал буруутган, гурван жил хорих ял оноожээ.

Сомали Улсад нэгэн алдартай хүний эрхийн хамгаалагчийн амийг хөнөөсөн байна.

Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад төрийн зүгээс хүний эрхийн хамгаалагчид руу дайрч, заналхийлж, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хорьдог. 2007 онд Хэвлэлийн тухай 2004 онд батлагдсан хуулийн заалтыг төр ашиглан, сонинуудад хяналт тогтоож, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан байна.

ОХУ-д улс төрийн байр суурийг үгүйсгэж, хараат бус олон нийтийн мэдээллийн хэрэгслийг дарамтлах буюу хааж, төрийн бус байгууллагуудыг дарамталсан байна. Олон нийтийн тайван жагсаал цуглааныг хүчээр тарааж, хуульчид, хүний эрхийн хамгаалагчид, сэтгүүлчид рүү заналхийлж, дайрсан байна. 2000 оноос хойш төрийн бодлого, үйл ажиллагаанд шүүмжлэлтэй ханддаг 17 сэтгүүлчид бусдын гарт хөнөөгдсөн боловч хэргийг шийдээгүй хэвээр байна.

2008 онд Ирак Улсад олон нийтийн мэдээллийн сүлжээний дор хаяж 37 Ирак ажилтан нас барсан бол 2003 оны 3 дугаар сарын дайралтаас хойш нийт 235 хүн үхсэн нь дэлхий дээрх сэтгүүлчдэд хамгийн аюултай газар болоод байна.

АРДЧИЛАЛТАЙ БАЙХ ЭРХ

1. *“Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй”.*
2. *“Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй”.*

3. "Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно."

Зимбабве Улсад олон зуун хүний эрхийн хамгаалагчид, Ардчилсан өөрчлөлтийн төлөө хөдөлгөөн гэсэн гол сөрөг хүчин болсон намын гишүүд тайван цуглаанд оролцсоныхоо төлөө баривчлагджээ.

Пакистан Улсад хуульчид, сэтгүүлчид, хүний эрхийн хамгаалагчид, улс төрийн идэвхтэнүүд нь ардчилал, эрх зүйт ёс, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг шаардсаны төлөө баривчлагдсан байна.

Куба Улсад 2007 оны эцсээр 62 улс төрийн хоригдол өөрийн улс төрийн үзэл бодол, үйл ажиллагааны төлөө хоригдсон хэвээр байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон олон улсын хүний эрхийн эрх зүйн бүхий л хэсэгт хүний эрх оршин байна. Багаар бодоход зарчмын хувьд эдгээр эрхийг ихэнх улс орнууд хүлээн зөвшөөрч, олон үндсэн хуулийн амин зүрх болж байна. Гэсэн хэдий ч дэлхийн нөхцөл байдал нь уг тунхаглалд зааснаас хэтэрхий хол хөндий ажээ.

Заримд нь хүний эрхийг бүрэн дүүрэн биелүүлэх явдал цаг хугацаа, орон зайн хувьд хол, хүрч болошгүй зорилт юм. Олон улсын хүний эрхийн дүрэм журам хүртэл хүчин төгөлдөр болох, гомдлын дагуу ажиллахад олон жил, их хэмжээний мөнгө зарцуулах боломжтой. Эдгээр олон улсын дүрэм журам нь хориглох чиг үүргийг гүйцэтгэх боловч хүний эрхийн зохих хамгаалалтаар хангахад учир дутагдалтай нь өдөр бүр тохиох зүй бус үйлдлийг илэрхийлэх энгийн бодит байдлаас харагдаж байна.

Ялгаварлан гадуурхалт дэлхий дахинд "тахал" мэт тарсан. Олон мянган хүн өөрийн санааг хэлснийхээ төлөө шоронд байна. Эрүү шүүлт, шүүх хуралгүйгээр улс төрийн шалтгаантай баривчлах, хорих явдал нь зарим ардчилсан улсад газар авч, буруу зүйлийг дэмжиж, амьдралд ашигласаар байна.

Гэхдээ та өөрчлөлтийг хийж чадна. Өөрийн эрхээ мэдэж авах, бусдад эрхийг нь хэлж өгөх, улс орондоо юу болж байгааг мэдэж байх, таны эрхийг хөндөж байвал дуугарах, дуу тань сонсогдохгүй өөртэй адил бодолтой хүмүүстэй нэгдэн илүү чангаар дуугарцгаая!


Дасгал:

"Манай улсад тохиолдож буй хүний эрхийн нийтлэг зөрчлүүд" сэдэвт Оюуны зураглал хийцгээе

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	Үндсэн санаа, ойлголт, асуудлынхаа талаар эргэцүүлэхдээ ашигладаг арга.	30 минутаас 1 цаг хүртэл	Эхлэлийн

Оюуны зураглал нь санаа бодлуудаа холбож зураглахад ашигладаг аргачлал юм. Санаа, ойлголт, асуудал зэрэг хэдэн үгээ төв хэсэгт бичсэний дараа холбогдох санаа, ойлголтоо нэмнэ. Санаа бүр хоорондоо ямар нэгэн түүх өгүүлэх шижмээр холбоотой. Оюуны зураглал хийхдээ

уулзалтын үеэр “ноорог” байдлаар тэмдэглэх, хананд хадсан цаасан дээр зурах, хангалттай цаг байвал илүү нарийвчлан зурах зэргээр ашиглаж болно. Оюуны зураглал хийхдээ дараах зааврыг ашиглаж болно. Үүнд:



Population solutions mind map, available at www.learningfundamentals.com.au.

Хамгийн багадаа гурван өнгөөр сэдвийнхээ зургийг төв хэсэгт зурж эхлэх.

1. Өөрийн оюуны зураглалдаа зураг, тэмдэг, нууц үг, хэмжигдэхүүн ашиглах.
2. Түлхүүр үгсээ сонгож, том болон жижиг үсэг хэвлэн ашиглах.
3. Үг/зураг бүрээ дангаар харуулж, холбогдох шугамд нь байрлуулах.
4. Төв хэсэгт байрлуулсан зургаас эхэлсэн шугам бүр холбогдох. Төвийн шугам өргөн эхэлж, цацрах байдлаар төвөөс холдох тусам нарийсах.
5. Үг/зургийн доорх шугам нь үг эсвэл зурагтайгаа адил урттай байх.
6. Харахад ялгарч харагдах, бүлэглэхдээ олон өнгө ашиглах.
7. Өөрийн гэсэн оюуны зураглал хийх загвар боловсруулах.
8. Өөрийн оюуны зураглалдаа зарим зүйлээ цохон тэмдэглэх, холбоос тогтоох.
9. Цацрагаа нарийсгах, тоогоор эрэмбэлэх, мөчрүүдээ ерөнхийлөн тоймлох замаар зураглалаа ямагт тодорхой болгох.

СЭДЭВ 6:

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН МЕХАНИЗМ

НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТОГТОЛЦООНЫ ТОЙМ


Дэлхий нийтийг хамарсан гай гамшиг болох 60 сая гаруй хүний амь насыг авч одсон Дэлхийн II дайны дараа дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, энх тайвныг бусниулахад хүргэж болзошгүй аливаа асуудлыг шударга ёс, олон улсын эрх зүйн дагуу эв зүйгээр шийдвэрлэх, улс орнуудын найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх, хүний эрхийг ямар ч ялгаваргүйгээр хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор дэлхийн улс гүрнүүд санаа нэгдэн Нэгдсэн үндэстний байгууллагыг (НҮБ) байгуулсан билээ. НҮБ нь анх 1945 оны 10-р сарын 24-нд АНУ-ын Калифорни муж улсын Сан-Франциско хотод 51 гишүүн оронтойгоор үндэс сууриа тавьж байсан бол эдүгээ 193 улсыг эгнээндээ нэгтгэсэн олон улсын байгууллага болж чаджээ.

НҮБ-ын Дүрмийн 1 дүгээр зүйлд олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах, хөгжлийг дэмжих, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх хөхиүлэн дэмжих явдлыг НҮБ-ын эрхэмлэвэл зохих үндсэн зорилгууд хэмээн тодорхойлсон байдаг. Ийм ч учраас НҮБ нь дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа бүхий олон байгууллагаас бүрддэг.

Хүний эрх эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих явдал нь НҮБ-ын үйл ажиллагааны үндсэн 3 зорилгын нэг болохын хувьд хүний эрхийг хамгаалах бүхэл бүтэн тогтолцоо НҮБ-ын системд томоохон байр суурь эзэлж байдаг. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1948 оноос эдүгээг хүртэл нийт 80 орчим хүний эрхийн олон улсын гэрээ, конвенци, тунхаглалыг батлан гаргаад байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагууд байгуулагдаж ажиллаж байна.

НҮБ-ын Хүний эрхийн тогтолцоог дүрмийн үндсэн дээр байгуулагдсан, хүний эрхийн гэрээнд үндэслэн байгуулагдсан байгууллагууд гэсэн үндсэн хоёр төрөлд хуваан үздэг бөгөөд доорхи схемд цэнхэр өнгөөр ялган үзүүлэв.

НҮБ-ын хүний эрхийн тогтолцоо



Хүний эрхийн зөвлөл

Хүний эрхийн Зөвлөл нь (ХЭЗ) нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 3 сарын 15-ны өдрийн 60/251 тоот шийдвэрийн үндсэн дээр, 60 гаруй жилийн хугацаанд НҮБ-ын хүний эрхийн асуудлыг хариуцан ажилласан НҮБ-ын Хүний эрхийн комиссын оронд хүний эрхийн асуудлыг хариуцан ажиллахаар байгуулагдсан НҮБ-ын Засгийн газар хоорондын үндсэн байгууллага юм. Хүний эрхийн комисс нь НҮБ-ын ЭЗНЗ-д харъяалагддаг байсан бол ХЭЗ нь Ерөнхий Ассамблейд шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл ЭЗНЗ-тэй ижил статустай болсон гэсэн үг. Ерөнхий Ассамблейн 60/251 тоот шийдвэрийн дагуу Хүний эрхийн комиссоос уламжлан өвлүүлсэн бүхий л үүрэг хариуцлага, хүний эрхийг хамгаалах механизм, тэдгээрийн мандатыг дахин хянан үзэж, шаардлагатай бол сайжруулах үүргийг ХЭЗ-д олгосон. Ийнхүү ХЭЗ нь 2007.06.18-ны өдөр гаргасан 5/1 тоот шийдвэрээрээ өөрийн бүтэц-зохион байгуулалтын баримт бичгийг батлан гаргасан бөгөөд үүндээ Ерөнхий Ассамблейгээс өгсөн чиглэлийн дагуу ажлынхаа шинэ аргачлал, хэлэлцэх асуудал, гомдол хэлэлцэх процесс, ХЭЗ-ийн Зөвлөх хороо (Human Rights Council Advisory Committee), ХЭЗ-ийн ажлын үндсэн механизм болох Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR), Тусгай хэрэгслүүдийн мандат зэрэг гол асуудлуудыг тусгасан.

ХЭЗ нь хүний эрхийн ужиг болсон ноцтой зөрчлүүдийг үүсгэж буй нөхцөл байдалд анхаарлаа хандуулах, энэ талаар зөвлөмж гаргах үндсэн зорилготой байгууллага гэж ойлгож болно. ХЭЗ нь үйл ажиллагаандаа түгээмэл, шударга, чиглэл зорилготой байх, урьдчилан сонгохгүй байх, харилцан ойлголцож, хамтран ажиллах, тодорхой уян хатан, ил тод, хариуцлагатай байх, тэнцвэртэй байх, хүртээмжтэй, олон талт байх, хүйсийн тэгш байдлыг хүндэтгэх зарчмыг баримтлан ажиллана.

ХЭЗ нь нууц санал хураалтаар, 3 жилийн хугацаагаар Ерөнхий Ассамблейн гишүүдийн олонхоос шууд сонгогдсон 47 гишүүн улсаас бүрдэнэ. Гишүүнчлэл нь газар зүйн бүсийн төлөөллийг тэнцвэртэй хангасан байх ёстой. НҮБ-ын гишүүн бүх улс ХЭЗ-ийн гишүүн байж болох ба ХЭЗ-ийн гишүүнээр сонгогдохдоо хүний эрхийг хангах, хамгаалах асуудалдаа тодорхой хувь нэмэр оруулахыг анхаарах бөгөөд сайн дурын үүрэг, амлалт авах үүрэгтэй. ХЭЗ-ийн гишүүд нь гишүүнийхээ бүрэн эрхийн хугацаанд UPR буюу Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээр орох бөгөөд хүний эрхийг хангах, хамгаалахад дээд зэргээр анхаарч, ХЭЗ-тэй байнга холбоотой ажиллана.

Хүний эрхийн зөвлөл нь:

- a) Хүний эрхийн боловсрол, сургалтыг дэмжин, тухайн гишүүн улстай зөвшилцсөний үндсэн дээр техникийн тусламж үзүүлэн чадавхийг нь бэхжүүлнэ.
- b) Хүний эрхийн тодорхой асуудлуудыг хэлэлцэх талбар болж ажиллана.
- c) Олон улсын хүний эрхийн хэм хэмжээг боловсронгуй болгох чиглэлээр ЕА-д хандан зөвлөмж гаргана.
- d) Улс орнуудаас сайн дураар хүлээсэн хүний эрхийн үүрэг болон НҮБ-ын дээд хэмжээний уулзалт, хурлаас гарсан хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн зорилт, амлалт, үүргийн хэрэгжилтийг шаардах үүрэгтэй.
- e) Үнэн бодит мэдээлэл дээр үндэслэн UPR-ийг явуулна.
- f) Яриа хэлэлцээ, хамтын ажиллагаагаараа хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулах ба хүний эрхийн онцгой нөхцөл байдалд яаралтай хариу арга хэмжээ авна.
- g) ХЭДК-тай холбоотой Хүний эрхийн комиссын үүрэг, хариуцлагыг хүлээн авч үргэлжлүүлнэ.
- h) Хүний эрхийн салбарт Засгийн газар, бүсийн байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд болон иргэний нийгэмтэй нягт хамтран ажиллана.
- i) Хүний эрхийг хангах, хамгаалах талаар зөвлөмж гаргана.
- j) Жил бүр үйл ажиллагаагаа ЕА-д тайлагнана.

ХЭЗ нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах гол механизмуудыг ашигладаг:

A. ХЭ-ийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлгийн механизм (UPR)

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлэг нь “бүх гишүүн улсуудынхаа хүний эрхийн үүрэг, амлалтын биелэлт, хүний эрхийн төлөв байдлыг үнэн бодит мэдээлэлд үндэслэн дүгнэх хэлэлцүүлгийг 4 жил тутамд 1 удаа хийх” зорилго бүхий цоо шинэ механизм юм.

B. ХЭЗ-ийн Зөвлөх Хороо

ХЭЗ-ийн үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох үүрэг бүхий Зөвлөх Хороо нь өөрийн итгэл үнэмшлийн үндсэн дээр ажиллах 18 шинжээчдээс бүрдэж ажилладаг. Зөвлөх хороо нь судалгаа, шинжилгээнд үндэслэн ХЭЗ-ийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар хэлбэр, арга зүйн зөвлөмжийг өгдөг. Зөвлөх хорооны гишүүдийг бүс нутгийн харъяалал, хүний эрхийн мэдлэг туршлага, ёс зүй зэргийг нь харгалзан НҮБ-ын гишүүн улсуудаас өөрийн орны хүний эрхийн үндэсний байгууллага, болон иргэний нийгмийн байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээр нэр дэвшүүлэн ХЭЗ-ийн хуралдаанаас нууц санал хураалтаар сонгоно. Зөвлөх хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байдаг.

C. Гомдол гаргах процедур

Ерөнхий Ассамблейгээс олгосон эрхийн дагуу ХЭЗ нь “дэлхийн улс орнуудын аль ч цэгт гарсан, хүний эрхийн ноцтой болон ужиг зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авч шалгах” эрхтэй. Гомдол нь дараах шаардлагыг хангасан байна:

- Гомдол нь илэрхий улс төрийн агуулгагүй байх ба НҮБ-ын дүрэм, ХЭТТ болон хүний эрхийн бусад хэм хэмжээгээр баталгаажсан хүний эрхийг зөрчсөн тухай байх,
- Зөрчигдөж буй эрх, түүнийг хэрхэн зөрчсөн талаар тодорхой дурдсан байх,
- Бүдүүлэг үг хэллэг хэрэглээгүй байх,
- Эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн нэг буюу бүлэг хүмүүс гомдол гаргах эрхтэй ба хүний эрх, эрх чөлөөний талаар үнэн бодит, шууд мэдээлэл бүхий бусад этгээд, ТББ гомдол гаргаж болно. Гэхдээ гомдол нь НҮБ-ын Дүрэмд харшлаагүй, улс төрийн сэдэлгүй байх,
- Гомдолд дурьдсан мэдээлэл нь дам мэдээлэл боловч хангалттай нотлох баримтаар нотлогдсон байх,
- Хэвлэл мэдээлэлд нийтлэгдсэн мэдээлэлд үндэслээгүй байх,
- Тухайн зөрчил өмнө нь НҮБ-ын тусгай хэрэгслүүд, гэрээний хороод, НҮБ-ын бусад байгууллага, тэдгээртэй төсөөтэй бүсийн хүний эрхийн байгууллагуудаар шийдвэрлэгдээгүй байх,
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь үр дүн муутай эсвэл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удааширсанаас бусад тохиолдолд дотоодын хүний эрхийг хамгаалах механизмуудыг гүйцээсэн байх.

Хүний эрхийн ноцтой зөрчлүүдэд ХЭЗ-ийн анхаарлыг хандуулах, гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг бүхий хоёр ажлын хэсэг (Working group on communications and Working group on Situations) ажилладаг. Эдгээр ажлын хэсгийг хүйсийн тэнцвэрт байдал болон бүс нутгийн төлөөллийг харгалзан ХЭЗ-ийн Зөвлөх хорооноос байгуулна⁴.

ХЭЗ-ийн гомдол хянан шалгасан Ажлын хэсгээс дараах арга хэмжээнүүдийн аль нэгийг авч болно:

- а) Хэргийг цаашид хэлэлцэх шаардлагагүй бол хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох

⁴ ХЭЗ-ийн 5/1 тоот шийдвэрээс дэлгэрэнгүйг үзнэ үү

- b) Холбогдох улсаас нэмэлт мэдээлэл ирүүлэхийг шаардах, хариу иртэл, гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг сунгах
- c) Хэргийг судлан ХЭЗ-д тайлагнах үүрэг бүхий өндөр мэргэшсэн шинжээчийг томилох
- d) Гомдлыг олон нийтэд ил тод хэлэлцэх
- e) Холбогдох улсын чадавхийг дээшлүүлэх, техникийн болон арга зүйн бусад туслалцаа үзүүлэхийг ХЭДКГ-аас хүсэх

D. Тусгай хэрэгслүүд

Ерөнхий Ассамблейгээс ХЭЗ-д олгосон эрхийн хүрээнд “Тусгай хэрэгсэл” (Special procedures) хэмээх хүний эрхийн бие даасан этгээд, эсхүл бүлгийг хүний эрхийг хамгаалах механизм болгон байгуулан ажиллаж байна.

UPR БУЮУ ХҮНИЙ ЭРХИЙН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

A. UPR-ийн тухай ойлголт, ач холбогдол

UPR буюу Ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь НҮБ-ын гишүүн 193 улс дахь хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутамд дүгнэн хэлэлцдэг өвөрмөц үйл явц юм. Энэ нь ХЭЗ-д суурилсан, үр нөлөө бүхий шинэ арга хэрэгсэл бөгөөд 2006 оны 3-р сарын 15-ны өдөр НҮБ-ын ЕА-н 60/251 тоот шийдвэрийн үндсэн дээр ХЭЗ-ийг байгуулахад нэг үндсэн чиг үүрэг нь болон батлагдсан.

Гэрээний хороод нь зөвхөн тухайн гэрээний гишүүн орнуудад хамааралтай бөгөөд зөвхөн тухайн гэрээнийхээ хэрэгжилтийг хянан хэлэлцдэг. Гэтэл НҮБ-ын гишүүдээс олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрт нэгдэн ороогүй олон улс орон гэрээний хороодын хяналтаас гадуур үлддэг байв. Харин UPR бий болсноор аль нэгэн гэрээгээр хязгаарлагдахгүй хүний эрхийн бүхий л асуудлыг нэг дор авч хэлэлцэх боломж олгосноос гадна НҮБ-ын гишүүн бүх улсыг хамрах болсноороо илүү ач холбогдолтой бөгөөд одоогийн байдлаар энэ төрлийн өөр механизм байхгүй байгаа юм.

UPR-ийн бас нэгэн онцлог нь бүх улсуудад ялгаваргүй, тэгш хандах, хэлэлцүүлэгт орж байгаа улстай хамтран ажиллах зарчимд үндэслэдэг ба улс орнууд дахь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүний эрхийг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулахад төр засагт туслах, техникийн туслалцааны асуудлыг ч мөн авч үздэг.

UPR-ийн эцсийн зорилго нь бүх дэлхийн хүмүүсийн тусын тулд улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлыг газар дээр нь сайжруулахад оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд улс орнууд дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, хүний эрх зөрчигдсөн тохиолдол бүрт анхаарлаа хандуулах боломжийг эрэлхийлэх бөгөөд улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн салбар дахь сайн туршлагаа хуваалцах, бие биенээсээ суралцах боломжийг олгох, хүний эрхийн асуудлаа сайнаар шийдвэрлэх чадавхийг бэхжүүлэх зорилготой.

B. UPR-ийг хэн явуулах вэ?

UPR-ийг ХЭЗ эрхлэн явуулах ба зөвлөлийн 47 гишүүдээс бүрдсэн UPR-ийн Ажлын хэсэг нь гардан явуулна. UPR-д орж буй улсын хүний эрхийн төлөв байдлыг Ажлын хэсгээр авч хэлэлцэх ба Ажлын хэсгийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг ХЭЗ-ийн Бүгд хурлаар хэлэлцэн батална. Ажлын хэсгийн хуралдааныг удирдан явуулах, ажлын хэсгийн илтгэлийг бэлтгэх үүрэг бүхий 3 илтгэгчийг (Гурвал) ХЭЗ-ийн гишүүдийн дундаас шодох аргаар сонгоно. Гэхдээ газар зүйн өөр өөр бүсийн төлөөлөл байх ёстой. UPR-т орж буй тухайн улс 3 илтгэгчийн нэгийг нь өөрийн хамаарах бүсээс сонгохыг санал болгож болно. Гурвал нь Ажлын хэсгийн хуралдааны үеэр хэлэлцүүлэгт орж буй улсад тавигдах асуулт болон хэлэлцэх асуудлуудыг урьдчилан бэлтгэж болно. ХЭДКГ нь Гурвалыг шаардлагатай тусламж, мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

В. UPR юунд үндэслэх вэ?

UPR-ийн хэлэлцүүлэгт орж буй улсын хүний эрхийн төлөв байдлыг үнэлэхдээ тухайн улс нь хүний эрхийг хангах хамгаалах талаар олон улсын хүлээсэн дараах үүрэг амлалтуудаа хэрхэн биелүүлж байгааг дүгнэн үзнэ. Үүнд:

- НҮБ-ын дүрэм;
- ХЭТТ;
- Нэгдэн орсон хүний эрхийн олон улсын болон бүс нутгийн гэрээ, хэлэлцээр;
- Тухайн улсаас ХЭЗ-ийн гишүүнд нэр дэвшихдээ авсан болон олон улсын өмнө авсан бусад үүрэг амлалтууд;
- Түүнчлэн олон улсын хүний эрхийн хэм хэмжээ болон олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн харилцан хамааралт байдлаас хамааран хэлэлцүүлэгт олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг хэрэглэж болно.

Ингэхдээ дараах баримт бичгүүдэд үндэслэн хэлэлцүүлэг явагдана.

1. UPR-т орж буй улсын Засгийн газрын бэлтгэн ирүүлсэн Үндэсний илтгэл. Үндэсний илтгэл нь 20 хуудаснаас ихгүй байх ба хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг бүх талуудтай өргөнөөр зөвлөлдсөний бэлтгэхийг зөвлөсөн.
2. НҮБ-ын хүний эрхийн тусгай хэрэгслүүд, гэрээний хороод, бусад хүний эрхийн болон төрөлжсөн байгууллагуудын мэдээллийн эмхэтгэл. Эдгээр байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг ХЭДКГ 10 хуудсанд багтаан эмхэтгэнэ.
3. Төрийн бус байгууллага, хүний эрхийн үндэсний байгууллагууд зэрэг холбогдох бусад талуудаас ирүүлсэн мэдээлэл. Нэг илтгэл 5 хуудаснаас ихгүй байх ба ХЭДКГ тэдгээр мэдээллийг нэгтгэж, 10 хуудас эмхэтгэл бэлтгэнэ.

Г. UPR-т ТББ-ууд, хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг

ХЭЗ нь хуучин НҮБ-ын ХЭК-ын зарим чиг үүргийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй байгууллагын хувьд тухайн үед мөрдөж байсан зарим нэг журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Үүний нэг нь ХЭЗ-ийн үйл ажиллагаанд ТББ-уудын оролцох журмын талаарх ХЭК-ын үед дагаж мөрдөж байсан Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1990/31 тоот тогтоолыг дагаж мөрдөж байна. Энэ тогтоолын дагуу зөвхөн ЭЗНЗ-ийн зөвлөх болон тусгай статус бүхий ТББ-ууд ХЭЗ-ийн үйл ажиллагаанд оролцох, аман болон бичгэн мэдэгдэл, мэдээлэл хийх боломжтой юм. Гэхдээ ийм статусгүй ТББ нь статус бүхий ТББ-тай хамтран эсвэл уламжлан ХЭЗ-ийн хуралдаанд мэдээлэл, мэдэгдэл хүргүүлж болно.

UPR нь ТББ-уудын оролцоог илүү нэмэгдүүлж чадсанаараа давуу талтай шинэ механизм болж чадсан. Учир нь Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн статусаас үл хамааран ямар ч ТББ UPR-т тайлан мэдээлэл хүргүүлэх, Ажлын хэсгийн хуралдаан болон түүний шийдвэрийг хэлэлцэн батлах ХЭЗ-ийн Бүгд хуралд оролцох боломжтой юм.

ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүд (Special procedures)

“Тусгай хэрэгсэл” нь хуучин ХЭК-оос байгуулагдсан, эдүгээ ХЭЗ-д уламжлагдсан, улс оронд үүссэн тодорхой асуудлаар, эсвэл сэдэвчилсэн асуудалд анхаарч ажилладаг механизмын ерөнхий нэр юм. Одоогийн байдлаар 36 сэдэвчилсэн асуудлаар ажилладаг (*thematic mandates*), 12 тодорхой улсын (*country mandates*) асуудлаар ажилладаг тусгай хэрэгслийн эрх эзэмшигчдийг ХЭЗ-өөс томилон ажиллуулж байна.

ХЭДКГ нь эдгээр тусгай хэрэгслүүдийг эрхээ хэрэгжүүлэхэд нь бодлого, судалгаа, ложистик талаас нь дэмжлэг үзүүлдэг. Тусгай хэрэгсэл нь дараах байдлаар ажиллаж болно:

А. Хувь хүний гомдлыг шалгах, харуу өгөх (Communications)

Ихэнх Тусгай хэрэгслүүд нь хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шалгах бүрэн эрхтэй бөгөөд хэрэв гомдол мэдээлэл хүлээн авсан тохиолдолд холбогдох Засгийн газраас нь тодруулахаар “Яаралтай захидал” (urgent appeals эсвэл letters of allegation)-ыг илгээдэг. Хувь хүний зүгээс ирүүлэх гомдолд хүний эрхийн зөрчлийн хохирогч, холбогдогч, гомдлыг шилжүүлж буй этгээдийн талаарх мэдээлэл, зөрчил болсон газар, өдөр, зөрчил хэрхэн үйлдэгдсэн талаарх мэдээлэл зэргийг агуулсан байх ёстой.

Б. Улс орнуудад албан айлчлал хийх (Country visits)

Ихэнх Тусгай хэрэгслүүд нь улс орны хэмжээн дэх хүний эрхийн нөхцөл байдлыг шалгах, зөрчлийн баримт цуглуулах зорилгоор тухайн улсад очиж ажилладаг. Энэ тохиолдолд тухайн улсын Засгийн газраас урилга хүсдэг бөгөөд зөвшөөрсөн тохиолдолд Тусгай хэрэгсэл нь тухайн улсад очиж, хүний эрхийн нөхцөл байдалтай биечлэн танилцаж, шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдээс нэмэлт мэдээлэл хүснэ. Зарим улс орон “байнгын урилга”-тай бөгөөд Монгол Улс үүнд багтаж байна. Өөрийн айлчлалынхаа үр дүнд Тусгай хэрэгслийн эрх эзэмшигч нь холбогдох дүгнэлт зөвлөмжийг агуулсан илтгэлийг бэлтгэн хэлэлцүүлдэг.

В. Сэдэвчилсэн асуудлаар судалгаа явуулах

Хэм хэмжээ, стандарт тогтоох зорилгоор энэ ажлыг хийж болно.

Г. Илтгэл хэвлүүлэх, хэвлэлийн хурал хийлгэх

Д. Улс орны түвшинд техникийн хамтын ажиллагааны хүрээнд зөвлөгөө өгөх

Ж. Хүний эрхийг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаануудыг явуулах

Өөрийн мандатын хүрээнд олон нийтийн хүний эрхийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг явуулж болно.

Тусгай хэрэгслийн төрөл

Тусгай хэрэгсэл нь 1 дүгээрт, хувь хүн (Тусгай илтгэгч, НҮБ-ын ЕНБД-ын Тусгай төлөөлөгч, Бие даасан шинжээч гэсэн нэртэй байж болно), 2 дугаарт, ихэвчлэн 5 гишүүдээс бүрдэх (бүс бүрээс нэг хүний төлөөлөл бүхий) ажлын хэсэг байж болдог.

Тусгай хэрэгслийн мандат нь тэдгээрийг байгуулж буй шийдвэрээр тодорхойлогддог. Тусгай хэрэгслийн мандат эзэмшигчид нь үүргээ биелүүлсний төлөө ямар нэг цалин хөлс, санхүүгийн дэмжлэг авдаггүй бөгөөд өөрсдийн мэдлэг чадавхиа бүрэн зориулж ажилладаг.

Тусгай хэрэгслийн эрх эзэмшигчдэд тавигдах шаардлага нь мэргэшил, туршлага, хувь хүний шалгуур гэх мэт нэлээд өндөр бөгөөд үүнд ИНБ-аас нэр дэвшүүлж болно. Түүнчлэн Тусгай хэрэгслийн эрх эзэмшигчид хэн ч, хэзээ ч гомдол гаргаж болдог давуу талтай.

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН ГАЗАР (ХЭДКГ)

НҮБ-ын Хүний эрхийн хөтөлбөр нь хүн бүрийн эрхийг газар сайгүй хамгаалж, хөхиүлэн дэмжиж ажилладаг бөгөөд энэ нь НҮБ-ын янз бүрийн агентлаг, институциуд, механизмуудаар дамжиж хэрэгждэг. Эдгээрийн дотроос ХЭДКГ нь Хүний эрхийн зөвлөл, гэрээний хороод зэрэг хүний эрхийн бусад хөтөлбөрүүд, байгууллагуудад чиглэн ажиллах зорилго бүхий тэргүүлэгч байгууллага юм. ХЭДКГ-ын үндсэн зорилго нь хүн бүрт, бүхий л эрхийг нь эдлүүлэх, тэднийг эрхээ эдэлж чаддаг болгохын тулд чадавхижуулах, эрхийг нь хэрэгжүүлэх баталгааг бий болгоход хувь нэмрээ оруулах явдал болно. Товчоор хэлбэл, ХЭДКГ нь хүн бүрт, бүх эрхийг нь эдлүүлэх, хамгаалах, хөхиүлэн дэмжихийн тулд НҮБ-ын дүрмээр олгогдсон өвөрмөц мандат бүхий газар гэж ойлгож болно.

ХЭДКГ-ын ажлын тэргүүлэх чиглэл нь “хүний эрхийн олон улсын гэрээнүүдийн хэрэгжилтийг хангахын тулд улс орнууд, орон нутгийн түвшинд нягт хамтран ажиллах, ХЭДКГ үүнд тэргүүлэгч үүрэгтэй байх, иргэний нийгмийн байгууллагууд болон НҮБ-ын агентлагуудтай ХЭДКГ-ын нягт хамтын ажиллагаа” болно. Энэ зорилгоо хэрэгжүүлэх үүднээс ХЭДКГ нь улс орнуудын Засгийн газар, Парламент, шүүх эрх мэдлийн байгууллага, цагдаа, хорих ял эдлүүлэх байгууллага, хүний эрхийн үндэсний байгууллага, ТББ болон иргэний нийгмийн бусад субъектүүдтэй хамтран ажилладаг. ХЭДКГ нь статусын хувьд НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын нэгэн хэсэг бөгөөд энэ байгууллага 1993 онд Хүний эрхийн дээд комиссарын албан тушаал бий болсноор байгуулагдсан.⁵ ХЭДКГ-ын Женев болон Нью-Йоркод орших төв байр, 11 улс дахь салбар оффис, 7 бүсийн хэмжээний оффист нь нийт 1000 гаруй ажиллагсадтай (2014 оны 4 сарын байдлаар).

ХЭДК-ын мандатын хүрээнд ажлыг нь төрөлжүүлэн авч үзвэл:

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭЭД КОМИССАРЫН ГАЗРЫН МАНДАТ

Ерөнхий Ассамблейгээс 1993 оны 12 сарын 20-ны 48/141 тоот шийдвэрээр олгосон мандатын дагуу ХЭДК нь дараах бүрэн эрхийг эдэлдэг:

Хүн бүрт, бүх эрхийг нь эдлүүлэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах

Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор НҮБ-ын системийн эрх бүхий байгууллагуудад зөвлөмж гаргах

Хүний эрхийн үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэх

Хүний эрхийн боловсрол, олон нийтэд мэдээлэл түгээх НҮБ-ын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

Хүн бүрт эрхийг нь эдлүүлэхэд учирч буй бэрхшээлийг даван туулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд анхаарах

Хүний эрхийн хэрэгжилтийг баталгаажуулах үүднээс Засгийн газруудтай ярилцлага зохион байгуулах

Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх

НҮБ-ын системийн байгууллагуудын хүрээнд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах,

НҮБ-ын хүний эрхийн механизмыг боловсронгуй болгох, үр нөлөөг нь нэмэгдүүлэх

- Тодорхой сэдэвчилсэн ажлынхаа (thematic issues) хүрээнд ХЭДКГ нь уур амьсгалын өөрчлөлт, жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг тулгамдаад буй хүний эрхийн тодорхой асуудлуудаар ажилладаг. Өөрөөр хэлбэл, ХЭДКГ нь хүний бүхий л төрлийн эрхийг хамгаалах, дэмжин ажиллах эрх хэмжээтэй болохын хувьд, тулгамдаад буй эрхийн тодорхой төрлүүдэд тусгайлан анхаарч болно.

⁵ Ерөнхий Ассамблейн 1993 оны 12 сарын 20-ны 48/141 тоот шийдвэр

- Стандарт тогтоох ажлын (standard-setting) хүрээнд, хүний эрхийн олон улсын хэм хэмжээг бий болгоход хувь нэмрээ оруулан ажилладаг.
- Мониторингийн ажлын хүрээнд ХЭДКГ нь, хүний эрхийн олон улсын стандарт, хэм хэмжээнүүдийн хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор ажилладаг. Энэ хүрээнд, ХЭДКГ нь ХЭЗ-ийг дэмжиж, өдөр тутмын ажлыг эрхлэн хэрэгжүүлдэг. Түүнчлэн ХЭЗ-өөс сонгогддог Тусгай хэрэгслүүд (тусгай илтгэгч, бие даасан шинжээч, ажлын хэсэг зэрэг)-ийн үйл ажиллагааг дэмжиж ажилладаг.
- Хэрэгжүүлэх ажлын хүрээнд, хүний эрхийн ноцтой зөрчил, хямрал үүсэх, хурцдахаас урьдчилан сэргийлэх үүднээс улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, шаардлагатай тохиолдолд төлөөлөгчөө илгээн ажиллуулах зэргээр ажилладаг.
- Хүний эрхийн боловсролыг дэмжих. Энэ ажлын хүрээнд ХЭДКГ нь НҮБ-ын системийн байгууллагууд дотроо болон олон нийтэд чиглэсэн хүний эрхийн тодорхой ажлыг зохион байгуулах, дэмжих, мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулдаг. Тухайлбал, олон нийтийн хүний эрхийн боловсролыг дэмжих үүднээс НҮБ-ын хүний эрхийг хамгаалах механизмууд (ХЭЗ, Тусгай хэрэгслүүд, гэрээний хороод зэрэг) болон тодорхой эрхийн асуудлаар цуврал мэдээллийн хуудсууд, гарын авлагыг тогтмол хэвлүүлэн үнэгүй тараадаг.

НҮБ-ын гэрээний хороод

Гэрээний хороод бол “Гэрээнд үндэслэсэн байгууллага” (Treaty based bodies)-ын ангилалд хамаарах бөгөөд гэрээний хороодын үндсэн үүрэг нь хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийг хянах явдал юм. Гэрээний хороод нь ИБУТЭТОУП, ЭЗНСЭТОУП зэрэг хүний эрхийн олон улсын гол гол гэрээнүүдэд үндэслэн байгуулагдсан бөгөөд ХЭДКГ-ын зүгээс Ажлын албаараа дамжуулан тэдэнд ажлын аргачлал болон илтгэл дээр ажиллах процесс ажиллагаанд нь туслалцаа үзүүлдэг байна. Одоогийн байдлаар 9 гэрээний хороод үйл ажиллагаагаа явуулж байна.

Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих хороод тодорхой мандаттай бөгөөд доорх мандатууд нь гэрээний хороо бүрт харилцан адилгүй байдаг.

- Оролцогч улсаас гэрээний хэрэгжилтийн талаар илтгэл хүлээн авч, хянан хэлэлцэх
- Хувь хүний гомдлыг хянан хэлэлцэх: Тухайн гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн талаар гомдол илгээх
- Улс хоорондын гомдлыг хэлэлцэх: Хүний эрхийн гэрээний гишүүн улсын зүгээс өөр гишүүн улс уг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байна гэж үзвэл Гэрээний хороонд гомдол гаргах
- Шалгах (Inquiry): Гэрээний гишүүн улс нь хүний эрхийг ноцтой зөрчиж буй талаарх бодитой мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тухайн улсыг дуудаж асуух, нэмэлт мэдээлэл ирүүлэхийг хүсэх, шаардлагатай тохиолдолд тухайн улсад айлчлах зэргээр хүний эрхийн зөрчлийнх нь асуудалд дүгнэлт, зөвлөмж гаргах
- Үзлэг шалгалт хийх: Тодорхой газруудад Хорооны үзлэг шалгалт хийх эрх хэмжээг оролцогч улсууд хүлээн зөвшөөрөх

Гэрээний хороод нь хүний эрхийн олон улсын хэрэгжилтийг гишүүн улсууд хэрхэн хангаж байгааг хянадаг, бие даасан шинжээчдийн бүлэг бөгөөд бүх гишүүн улсууд тухайн гэрээнд нэгдэн ормогц гэрээний хэрэгжилтийн талаар тодорхой үе шаттайгаар тайлагнах үүрэг хүлээдэг. Гэрээний хороодын зүгээс илтгэл бүрийг хянан үзэж, зөвлөмж, дүгнэлтийг багтаасан “Дүгнэлт зөвлөмж” (concluding observations)-ийг гаргадаг. Гэрээний хороодоос оролцогч улсуудад хандаж гаргасан дүгнэлт, зөвлөмж нь заавал биелэгдэх шинжтэй, хууль зүйн үр дагаврыг агуулдаггүй

хэдий ч, гишүүн улсуудад үүнийг хэрэгжүүлэх ёс зүйн үүрэг хариуцлага оногддог. Гэрээний хороодоос гаргасан “Дүгнэлт зөвлөмж” (Concluding observations)-д “Гэрээний хорооноос тухайн улсад хандаж гаргасан Зөвлөмжийг олон нийтэд түгээх, сурталчлах”-ыг зөвлөсөн байдаг.

Хүснэгт. Хүний эрхийн гэрээний хороодын мандат, илтгэл хэлэлцэх процесс

№	Хүний эрхийн гэрээ (нэмэлт протокол) батлагдсан огноо	Хяналт тавих гэрээний хороо	Мандат
1	ИУТЭОУП, Нэмэлт протокол, 2-р нэмэлт протокол	Хүний эрхийн Хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүний гомдол хэлэлцэх, улс хоорондын гомдол хэлэлцэх
2	ЭЗНСЭОУП, Нэмэлт протокол	ЭЗНСЭ-ийн Хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүний гомдол хэлэлцэх
3	Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц	АҮЯГБХУК-ийн Хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүний гомдол хэлэлцэх, улс хоорондын гомдол хэлэлцэх, эрт анхааруулах, нэн даруй нягтлах журам
4	Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, Нэмэлт протокол	ЭЯГБХУК-ийн Хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүн болон хамтаар гаргасан гомдол хэлэлцэх, шалгах-inquiry
5	Эрүүдэн шүүхийн эсрэг Конвенц	Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүний гомдол хэлэлцэх, шалгах-inquiry, улс хоорондын гомдол хэлэлцэх
	ЭШЭК-ийн нэмэлт Протокол	ЭШ-ээс урьдчилан сэргийлэх дэд хороо	Үзлэг шалгалт хийх, Үндэсний механизмд зөвлөгөө өгөх
6	Хүүхдийн эрхийн тухай Конвенц, 1,2-р нэмэлт Протокол	Хүүхдийн эрхийн хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүний гомдол хэлэлцэх
7	Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай ОУ-ын конвенц, 1990	Цагаач ажилчдын эрхийн Хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүний гомдол хэлэлцэх
8	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тухай Конвенц, Нэмэлт Протокол	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн Хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүний гомдол хэлэлцэх
9	Сураггүй алга болгохын эсрэг конвенц	Сураггүй алга болгохын эсрэг Хороо	Илтгэл хэлэлцэх, хувь хүний гомдол хэлэлцэх

Нэр томъёоны тайлбар

Гомдол гаргах процесс (Communication procedure): Хүний эрхийн ноцтой болон ужиг зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авч, шалгах процесс. Гомдол хүлээн авч хянан шалгах эрхийг ХЭЗ-ийн ихэнх Тусгай хэрэгслүүд, зарим Гэрээний хороод эдэлдэг.

Гэрээний хороод (Treaty bodies): Хүний эрхийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий, бие даасан шинжээчдээс бүрдсэн байгууллага

Дүгнэлт зөвлөмж (Concluding observations): Гишүүн улсуудаас илгээсэн анхны болон ээлжит илтгэлийг хэлэлцэж, Гэрээний хорооноос гаргадаг, дүгнэлт, зөвлөмж бүхий баримт бичиг

Country visit: Ихэнх Тусгай хэрэгслүүд нь улс орны хэмжээн дэх хүний эрхийн нөхцөл байдлыг шалгах, зөрчлийн талаарх баримтыг цуглуулах зорилгоор тухайн улс руу очиж газар дээр нь очдог. Энэ тохиолдолд тухайн улсын Засгийн газраас урилга хүсдэг бөгөөд зөвшөөрсөн тохиолдолд энэхүү айлчлалыг хийдэг байна.

НҮБ-ын ХЭДК (Хүний эрхийн дээд комиссар), UNHCHR: 1993 онд бий болсон бөгөөд ХЭДК-ыг тэргүүлдэг, НҮБ-ын хүний эрхийн асуудал хариуцсан гол албан тушаалтаныг ойлгоно.

UPR буюу Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлэг:

НҮБ-ын гишүүн бүх улсын хүний эрхийн үүрэг, амлалтын биелэлт, хүний эрхийн төлөв байдлыг үнэн бодит мэдээлэлд тулгуурлан 4 жил тутамд дүгнэж хэлэлцэх ХЭЗ-ийн тусгай механизм юм.

UPR-ийн ажлын хэсэг: Ажлын хэсэг нь UPR-ийг гардан явуулдаг. Өөрөөр хэлбэл UPR-т орж байгаа улсын хүний эрхийн төлөв байдлыг 3 цагийн турш авч хэлэлцэн, зөвлөмж, дүгнэлт гаргадаг үйл явц юм. Ажлын хэсэгт Хүний эрхийн зөвлөлийн 47 улс оролцоно. Ажлын хэсгийн хурадаанаас гарсан шийдвэрийг Хүний эрхийн зөвлөлийн бүгд хуралдаанаар хэлэлцэн батлана.

UPR-ийн Үндэсний илтгэл: UPR-т орж буй улсын Засгийн газрын бэлтгэн ирүүлсэн хүний эрхийн төлөв байдлын илтгэл юм. Үндэсний гэж нэрлэсэн учир нь илтгэлийг бэлтгэхэд үндэсний хэмжээний холбогдох бүх талуудтай өргөнөөр зөвлөлдөх зарчмаар бэлтгэхийг НҮБ-ын ХЭЗ-өөс зөвлөсөнтэй холбоотой.

Тодорхой эрхийн чиглэлээр олгогдсон мандат (Thematic mandate): Зөвхөн тодорхой эрхийн чиглэлээр, тухайлбал, зохистой орон байраар хангагдах эрхийн чиглэлээр дэлхийн улс орнуудын хаана ч ажиллах эрхтэй ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүдэд олгосон мандат юм.

UPR-ийн Гурвал илтгэгч: Ажлын хэсгийн хуралдааныг удирдан явуулах, ажлын хэсгийн илтгэлийг бэлтгэх үүрэг бүхий илтгэгч нарыг хэлнэ. 3 илтгэгчийг Хүний эрхийн зөвлөлийн гишүүдийн дундаас шодох аргаар сонгоно. Гурвал нь Ажлын хэсгийн хуралдааны үеэр хэлэлцүүлэгт орж буй улсад тавигдах асуулт болон хэлэлцэх асуудлуудыг урьдчилан бэлтгэж болно. ХЭДК нь Гурвалыг шаардлагатай тусламж мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

Тодорхой улсын чиглэлээр ажиллахаар олгогдсон мандат (Country mandate): Зөвхөн тодорхой улс оронд, бүх эрхийн салбарт ажиллуулахаар ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүдэд олгосон мандат юм.

Тусгай хэрэгсэл (Special procedures): “Тусгай хэрэгсэл” нь хуучин Хүний эрхийн Комиссоос байгуулагдсан, одоо Хүний эрхийн зөвлөлд уламжлагдсан байна. Улс оронд үүссэн тодорхой асуудлаар, эсвэл сэдэвчилсэн асуудалд анхаарч ажилладаг механизмын ерөнхий нэр юм. Нэг болон бүлэг этгээдүүд ХЭЗ-ийн Тусгай хэрэгслээр ажиллаж болох ба Тусгай илтгэгч, Хараат бус шинжээч, Ажлын хэсэг гэх мэт өөр өөр нэртэй байж болно.

ХЭДК (Хүний эрхийн дээд комиссарын газар), OHCHR: Хүн бүрт, бүх эрхийг нь эдлүүлэх, хамгаалах, хөхүүлэн дэмжихийн тулд НҮБ-ын дүрмээр олгогдсон өвөрмөц мандат бүхий газар юм. НҮБ-ын хүний эрхийн механизмууд болох ХЭЗ, Тусгай хэрэгслүүд, Гэрээний хороодын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

ХЭЗ (Хүний эрхийн зөвлөл)HRC: НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2006 оны 3 сарын 15-ны өдрийн 60/251 тоот шийдвэрийн үндсэн дээр, 60 гаруй жилийн хугацаанд НҮБ-ын хүний эрхийн асуудлыг хариуцан ажилласан НҮБ-ын ХЭК-ын оронд хүний эрхийн асуудлыг хариуцан ажиллахаар байгуулагдсан НҮБ-ын Засгийн газар хоорондын үндсэн байгууллага юм.

ХЭЗ-ийн Зөвлөх хороо (Human Rights Council Advisory Committee): ХЭЗ-ийн үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий, өөрийн итгэл үнэмшлээр ажиллах 18 шинжээчээс бүрдсэн бүтцийг хэлнэ.

Шалгах (Inquiry): Гэрээний гишүүн улс нь хүний эрхийг ноцтой зөрчиж буй талаарх бодитой мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тухайн улсыг дуудаж асуух, нэмэлт мэдээлэл ирүүлэхийг хүсэх, шаардлагатай тохиолдолд тухайн улсад айлчлах зэргээр хүний эрхийн зөрчлийн асуудалд нь дүгнэлт, зөвлөмж гаргах үйл явц юм.

Анхны илтгэл (Initial report): Оролцогч улсуудаас нэгдэн орсон хүний эрхийн гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу (ихэвчлэн 1-2 жилийн дараа) гэрээний хэрэгжилтийн талаар бэлтгэн Гэрээний хороонд илгээдэг анхны илтгэл юм.

Ээлжит илтгэл (Periodic report): Гишүүн улсуудаас нэгдэн орсон хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн талаарх анхны илтгэлээ илгээсний дараа Гэрээний хорооны хүссэн үед (ихэвчлэн 4-5 жилийн дараа) гэрээний хэрэгжилтийн төлөв байдлын талаар бэлтгэн Гэрээний хороонд илгээдэг илтгэлийг хэлнэ.

Яаралтай захидал (Urgent appeals or letters of allegation): Хувь этгээдээс хүний эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн гомдлыг хүлээн аваад ХЭЗ-ийн Тусгай хэрэгслүүд тодруулга авахаар холбогдох гишүүн улс руу илгээдэг захидал юм.

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

Зорилго

Сэдвийн зорилго нь хүний эрхийн баримт бичгүүд, түүний төрлүүдтэй танилцах

Чиглүүлэгчийн уншсан байх мэдээлэл

Олон улсын хууль гэж юу вэ?

Олон улсын хууль нь улс орон хоорондын харилцааг зохицуулдаг хууль тогтоомж бөгөөд хэдэн зууны туршид боловсронгуй болсоор иржээ.

Олон улсын хуулийн төрөл:

- Улс хоорондын хэлцэл, ерөнхий нэрээрээ гэрээ, конвенц буюу пакт
- Заншлын хэм хэмжээ

Гэрээ конвенц нь улс орны Засгийн газрууд хоорондоо хэлцэл хийснээр тус бүртээ хууль зүйн үүрэг хүлээдэг ба “нэгдэн орох” эсхүл “соёрхон батлах” замаар гэрээний талууд болсон нөхцөлд л тэрхүү үүргийг хүлээдэг байна. Өөрөөр хэлбэл гэрээнд нэгдэн ороогүй улс орнуудад тэрхүү үүрэг хамаарахгүй гэсэн үг.

Харин олон улсын заншлын хэм хэмжээний хувьд бүх улсын Засгийн газрууд үүрэг хүлээж түгээмэл байдлаар биелүүлэхийг шаарддаг. Олон улсын заншлын хэм хэмжээ гэрээ конвенц шиг бичигдмэл хэлбэрээр байдаггүй улс орны туршлагаас үүдэн гардаг учир даган биелүүлэх дүрэм журмыг тодорхойлоход хүндрэлтэй энэ нь эцэст нь маргаантай болгож гуйвуулахад хүргэдэг. Олон улсын шүүхүүд өөрсдийн шүүх болон хуулийн байгууллагаар дамжуулан олон улсын заншлын хэм хэмжээний агуулгыг үндэслэн нилээн дэлгэрэнгүй гарын авлага гаргаж байна.

Сэдвийн хүрээнд оролцогчдоос асуух асуулт:

Эрх үүрэг хариуцлага нь харилцан хамааралтай юу? Тухайлсан нэг эрх дээр ярилцана. “Та бүхэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй хэдий ч бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэх үүргийг хүлээсэн байдаг. Үүргээ биелүүлээгүй бол хариуцлага хүлээнэ” зэрэг байдлаар тайлбарлана.

Дасгал.

Хүснэгт 1-д багтсан механизмыг самбарт тогтооно. Харин хүснэгт 2-т багтсан механизмыг оролцогчдод тараан өгч алинд хамаарахыг олуулж хичээлийг бататгана.

Чиглүүлэгч оролцогчдыг самбарт ойртон суухыг урьж, наасан хувилбарыг чиглүүлэн механизмыг тус бүрээр тайлбарлана.

Хүснэгт 1

Хүний эрхийн Зөвлөл
Хүний эрхийн Дээд Комиссарын Газар
Гэрээний хороод
Тусгай журмууд
Түгээмэл тогтмол хэлэлцүүлэг
Бусад

Хүснэгт 2

НҮБ-ын дүрэмд үндэслэгдсэн, Ерөнхий Ассамблейд шууд хамаардаг, Засгийн газар хоорондын үндсэн байгууллага
Гэрээнд үндэслэгдэн байгуулагдсан, бие даасан шинжээчдээс бүрдсэн хороод
Тодорхой улсын асуудлаар ажилладаг: Бурунди, Кампуж, Сомали, Судан гм. (Тухайлбал, Гомдол гаргах журам, Зөвлөх Хороо, цөөнхийн асуудлаарх форум, Ажлын хэсэг гм)
Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хороо (ЭЗНСЭОУП)
Хүний эрхийн хороо (ИУТЭОУП)
Сэдэвчилсэн асуудлаар ажилладаг: Үзэл бодлоо илэрхийлэх, шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх, хүний эрхийн боловсрол, хүний эрхийг хамгаалагчдын, эрүү шүүлт, хоол хүнс, эрүүл мэнд, ядуурал гм.
Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хороо (АҮЯГБХУК)
Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хороо (ЭЯГБХУК)
Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо (ЭШЭК)
Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо (ЭШЭК-ийн нэмэлт Протокол)
Хүүхдийн эрхийн хороо (ХЭК)
Цагаач ажилчдын эрхийн Хороо (ЦАТГБХК)
Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн Хороо (ХБХЭК)
Сураггүй алга болгохын эсрэг Хороо (САБЭК)
НҮБ-ын ЕНБДГ-ын нэгэн хэсэг бөгөөд Хүний эрхийн Зөвлөл, гэрээний хороод зэрэг хүний эрхийн бусад хөтөлбөрүүд, байгууллагуудад чиглэн ажиллах зорилго бүхий тэргүүлэгч байгууллага.

Дасгал.

Хүний эрхийн олон улсын гэрээнүүд болон механизмын үндсэн шинж. (Хүний эрхийн олон улсын гэрээнүүдийн онцлог шинж, ялгааг танин мэдэж, ойлгох ач холбогдолтой)

Даалгавар (3-4 хүний бүрэлдэхүүнтэй багууд нь аливаа нэг олон улсын гэрээг урьдчилан бэлтгэсэн хүснэгтийн дагуу гишүүн бүрийн оролцоотойгоор бусад оролцогчдод дэлгэрэнгүй, ойлгомжтой хэлбэрээр тайлбарлана.)

Үүнд: Дүрд тоглох, зураг зурах, мэдээллийг багцалж хүргэх гэх мэт аргачлалаар тайлбарлана.

Олон улсын хүний эрхийн гэрээний онцлог шинж

Загвар болгож зарим хүний эрхийн олон улсын гэрээний тухай мэдээллийг оруулав.

Хүүхдийн эрхийн тухай конвенц

Олон улсын хүний эрхийн гэрээний онцлог шинж		
Нэр Хүүхдийн эрхийн тухай конвенц	<p>Хүчин төгөлдөр болсон огноо.....</p> <p>1989 онд батлагдаж, 1990 онд хүчин төгөлдөр хэрэгжиж ирсэн, 54 зүйлтэй</p> <p>Конвенц нь дөрвөн үндсэн зарчим дээр үндэслэнэ. Эдгээр зарчмууд нь хүүхэд бүр өөрийн эрхээ эдлэхэд баримтлана.</p> <p>Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх</p> <p>Хүүхэд бүх өөрийн үзэл бодол, саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхтэйг баталгаажуулсан.</p> <p>Үл ялгаварлан гадуурхах, тэгш боломж</p> <p>Хүүхэд бүх насанд хүрэгчидтэй адил үнэлэгдэж, адил эрхтэй юм. Конвенц нь Хүүхэд бүр адил тэгш эрхтэй байна гэсэн зарчимд тулгуурлана. Энэ зарчим нь хүүхэд бол эрх эдлэх объект биш харин субъект юм гэсэн утга санаага агуулна. Түүнчлэн, хүүхэд бүр аливаа алагчилалгүйгээр бүх эрхээ эдлэх ёстой. Энэ нь эмэгтэй хүүхэд бүр эрэгтэй хүүхдийн адил ижил боломж эдэлнэ. Үүнтэй адил хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр бусад хүүхдийн адил тэгш эрхтэй байна.</p> <p>Амьд явах, эсэн мэнд хөгжих</p> <p>Хүүхэд бүр амьд явах жам ёсны эрхтэй. Хүүхэд бүр амьдрах, эсэн мэнд хөгжих нийгэм соёлын үйлчилгээг хүртэх эрхтэй.</p> <p>Хүүхдийн язгуур эрх ашгийг хангах</p> <p>Хүүхэд өсөн бойжиж насан хүртэл, нийгмийн хамгаалал, дэмжлэг авах хэрэгцээтэй байна. Энэ зарчим нь хүүхдийн язгуур эрх ашгийг хангах зорилгоор тэдний хэрэгцээнд үндэслэнэ. Конвенцийн 3(1) дүгээр зүйлд тодорхой заасан.</p>	Гишүүн улсын тоо 193 гаруй
Хамгаалж буй эрх	<p>Хүүхэд өөрийн эрхэд нь нөлөөлөхүйц, ямар нэгэн шийдвэрт оролцох, сонирхлоо илэрхийлэх, боломжтой болохыг зааж өгсөн. 4 зарчимтай: Хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх, үл ялгаварлан гадуурхах, тэгш боломж, амьд явах, эсэн мэнд бойжих, хүүхдийн язгуур эрх ашгийг хангах,- хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна.</p>	
Төрд хүлээлгэсэн үүрэг	<p>Эрхийг хэрэгжүүлэхдээ шаардлагатай хууль тогтоох, захиргааны бусад арга хэмжээг нөөц боллоцоондоо тулгуурлаж дээд зэргээр ашиглах, шаардлагатай бол олон улсын хамтын ажиллагааны хүрээнд тавина.</p>	
Хяналтын механизм	<p>Хүүхдийн эрхийн хороо нь конвенцийг хэрэгжүүлэх улс орнуудын үүрэгт хяналт тавих зорилгоор байгуулагдсан. Хороо нь арван найман бие даасан мэрэгжилтнүүдээс бүрдэнэ. Оролцогч улсууд Конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхийг хангах талаар авсан арга хэмжээ болон эдгээр эрхийг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшлийн талаархи тайланг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Хороонд хэлэлцүүлэхээр тухайн оролцогч улсын хувьд Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор үүний дараа таван жил тутамд ирүүлэх үүрэгтэй.</p>	
Олон нийтэд хүлээлгэсэн үүрэг, хариуцлага	<p>Эцэг эх, зохих тохиолдолд нутгийн ёс заншлын дагуу өргөтгөсөн гэр бүл, нийгэмлэгийн гишүүд, асран хамгаалагч болон хүүхдийн өмнөөс хуулийн дагуу хариуцлага хүлээх бусад этгээдийн хариуцлага, эрх үүргийг хүндэтгэн, хөгжиж буй хүүхдийн чадавхид нийцүүлнэ.</p>	

Ялгарах онцлог	18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ. Конвенцийн 6/2-зүйлээр оролцогч улсууд хүүхдийн амьдрах эрх, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангах үүргийг баталгаажуулсан. Хөгжих гэдгийг бие махбод, оюуны, сэтгэл санааны, нийгэм соёлын түвшинд хөгжих гэж тайлбарласан.
Тайлбар	<p>Конвенцид хүлээн зөвшөөрсөн эрхийг хангахад хүүхэд бүрт ямар нэг ялгаваргүйгээр хүртээх болно. Хүүхдийг эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч болон гэр бүлийн бусад гишүүний байдал, үйл ажиллагаа, үзэл бодол болон итгэл үнэмшлийг үндэслэн аливаа хэлбэрээр алагчлахгүй, бөгөөд шийтгэхээс хамгаалах бүхий зохистой арга хэмжээ авна.</p> <p>Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна.</p> <p>Хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад эцэг эх болон улс орны зүгээс анхаарлаа хандуулна гэснийг гуравдугаар зүйлд дэлгэрүүлэхдээ нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд анхаарна.</p> <p>Нэмэлт протокол</p> <p>Конвенц нь гурван нэмэлт протоколтой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • <u>Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн нэмэлт протокол</u> • <u>Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 2 дугаар нэмэлт протокол</u> • Мэдээлэл хүргүүлэх журмын тухай хүүхдийн эрхийн конвенцийн 3 дугаар нэмэлт протокол

Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай пакт

Олон улсын хүний эрхийн гэрээний онцлог шинж		
Нэр Эдийн засаг нийгэм соёлын эрхийн тухай пакт	<p>Хүчин төгөлдөр болсон огноо 1976.01.03</p> <p>Эдийн засаг нийгэм соёлын эрхүүдийн ач холбогдлыг тодорхойлсон. Эдгээр эрх нь хүн бэрхшээлээ арилгаж, чадавхаа бэхжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Хүний үнэ цэнэ нэр төр нь иргэн улс төр, эдийн засаг, нийгэм соёлын эрхийн суурь болдог. Эдгээр эрхүүдийг хангахад нийтлэг 2 элементүүдийг баримтлах ба үүнд аюулгүй ба тэгш байдал юм. Хүний аюулгүй байдалд нийгмийн аюулгүй байдал, харин тэгш байдалд нь хууль эрх зүйн өмнө тэгш боломж эдлэх асуудал.</p>	Гишүүн улсын тоо 160 гаруй
Хамгаалж буй эрх	<p>Конвенцийн</p> <p>6 дугаар зүйл: ажил, хөдөлмөр эрхлэх эрх</p> <p>7 дугаар зүйл: хөдөлмөрийн шударга, таатай нөхцлөөр хангагдах эрх</p> <p>8 дугаар зүйл: үйлдвэрчний эвлэл байгуулах, журмыг нь сахих үндсэн дээр сонгосон байгууллагадаа элсэн орох эрхтэй</p> <p>9 дүгээр зүйл: нийгмийн хангамжинд хамрагдах эрх</p> <p>10 дугаар зүйл: Гэр бүлээ хамгаалах эрх</p> <p>11 дүгээр зүйл: өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцлөө байнга сайжруулах эрх</p> <p>12 дугаар зүйл: эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх эрх</p> <p>13 дугаар зүйл: сурч боловсрох эрх</p>	

Төрд хүлээлгэсэн үүрэг	Конвенцид зааснаар улс бүр дангаараа болон олон улсын тусламж хамтын ажиллагаагаар тухайлбал эдийн засаг техникийн салбарт энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй.
Хяналтын механизм	<p>Конвенцийн 4-р зүйлд пактын дагуу хангах ёстой эрхийг эдлүүлэхдээ эдгээр эрхэд зөвхөн хуульд тодорхойлсон ёсоор хязгаарлалт тогтоож, болох бөгөөд энэ нь тэдгээрт эрхийн уг чанарт нийцсэн ардчилсан нийгэмд гагцхүү нийтийн сайн сайхан байдалд туслах зорилготой байх ёстой.</p> <p>Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн хороо нь 1985 онд байгуулагдсан ба бие даасан хараат бус 18 гишүүдээс бүрддэг.</p> <p>Хорооны гол үүрэг нь улс орнуудын пактын хэрэгжилтэнд хяналт тавих юм. Пактын 16-17 дугаар зүйлээр, оролцогч улс орнууд таван жил тутам нэг удаа конвенцийг хэрэгжүүлэхэд авсан арга хэмжээнүүд, тухайлбал шинээр гаргасан хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт, үр нөлөөний талаарх мэдээллийг багтаасан тайланг хороонд хүргүүлэх үүрэгтэй.</p>
Олон нийтэд хүлээлгэсэн үүрэг, хариуцлага	Эдийн засаг нийгэм соёлын бүх эрхийг эрэгтэй эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцлийг хангах үүрэгтэй.
Ялгарах онцлог	Арьс үндэс, арьсны өнгө, нас хүйс, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал эд хөрөнгийн байдал, төрсөн болон эрүүл мэндийн нөхцөл байдал, хөгжлийн бэрхшээлтэй зэргээс шалтгаалахгүй ялгаварлан гадуурхахгүй.
Тайлбар	<p>Бүх боломжит арга хэмжээг авах гэдэг нь зарим нэг тодорхой хууль бодлогыг бий болгох алхам багтана</p> <p>Конвенцийн хороо нь улс орнууд эрхийг хангах, хэрэгжүүлэх боломжгүй бүх арга хэмжээг аюух ёстой гэж заасан. Хорооны зүгээс "улс орнууд тайлагнахдаа зөвхөн авсан арга хэмжээг дурдахгүй, харин авах боломжтой ямар алхам байж болох талаар мэдээлэх хэрэгтэйг гэж тодруулсан".</p> <p>Хорооны зүгээс "бүхий л боломжтой арга хэмжээг авах" гэдэг нь хэрэгжүүлэх болон үр дүнд хүрэх үүрэгтэй шууд холбогдоно гэж тайлбарласан. Улс орнуудын зүгээс "бодлого журмууд нь эдийн засгийн хөгжлийг дэмжиж, ядуурал, бичиг үсэг үл мэдэх явдлыг бууруулж байгаагаар конвенцээр хүлээсэн үүргээ биелүүлж байна" гэж үзэж болохгүй.</p> <p>"Хууль тогтоомжийн арга хэмжээ авах" гэсэн нөхцөлийг улс орнууд конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эцсийн алхам нь биш юм гэдгийг Хорооны зүгээс тайлбарласан. Улс орнуудын зүгээс зөвхөн хууль батлан гаргаснаар хүлээсэн үүргээ биелүүлж байгааг батлах нь хангалтгүй юм. Тухайлбал: Хорооны зүгээс Канад улсын тайланг үнэлж дүгнэхдээ " хэрвээ тайланг зөвхөн хууль эрх зүйн хүрээнд анхаарал хандуулвал, хуулийн хэрэгжилт болон хуулийн хооронд том цоорхой гарч ирэх болно" гэдгийг зөвлөсөн.</p> <p>Нөгөө талаар хуультай холбогдуулан хорооны зүгээс "хууль эрх зүйн өөрчлөлт, шинэчлэл нь шүүх хуулийн өмнө бүх хүний эрхийг хүндлэх, ялангуяа эрх зүйн системд үүнийг анхаарч үзэх ёстой" гэж сануулсан.</p> <p>"Дэвшилттэйгээр хэрэгжүүлэх"</p> <p>"Дэвшилттэйгээр хэрэгжүүлэх" гэсэн утга санаа нь эдийн засаг, нийгэм соёлын эрхийг даруй хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц боломжуудыг бий болгох хэрэгцээн дээр үндэслэн гарсан. Нөгөө талаар Хорооны зүгээс тодруулахдаа "дэвшилттэйгээр хэрэгжүүлэх" гэдэг нь өөрөөсөө холдуудах, зайлсхийх шалтаг болохгүй юм.</p> <p>Ийм тайлбар нь активист нарт "gradualism in economic policies" буюу "эдийн засгийн өөрчлөлтийн аажмаар хийх" ойлголтын эсрэг хэтийн төлөвийн ойлголтыг өгдөг.Энэ нь нийгмийн халамжийг баталгаажуулахад удаан процесс байх ба цаашлаад хүн бүрийн эдийн засагт нөлөөлнө. Хорооны байр суурь нь эдийн засгийн өсөлт нь хүний эрхийг хангахтай холбогдсон процесс гэж үзсэн.</p>

Тайлбар	<p>Хорооны зүгээс “дэвшилттэйгээр хэрэгжүүлэх” үүргийг дүгнэхдээ энэ бол зөвхөн тогтвортой сайжруулахаар хязгаарлагдахгүй, харин ямар нэг ухралт байж болохгүй гэж тайлбарласан.</p> <p>“Зохистой арга хэмжээг байгаа бүх боломжийнхоо хэрээр авах” үүрэг түүний утга санаа.</p> <p>Эдийн засгийн нөөц боломж гэдэг нь эдийн засаг, нийгэм соёлын эрхүүдийг хангахад чухал элемент ба иргэний болон улс төрийн эрхийн дараа анхаарч үзэх гол үндэслэл юм. Хороо нь Конвенцийн эрхүүдийг хэрэгжүүлэхэд нөөц боломж чухал болохыг дурдахдаа, нөөц боломжуудыг бий болгосон нь үүргээ биелүүлсэнд тооцогдохгүй юм гэдгийг онцгойлсон. Жишээ нь: тодорхой тооны хүмүүс ядуурал, өлсгөлөнд амьдарч байгаа тохиолдол нь улс орнуудын зүгээс бүх хүний эрхийг хангахад дутагдалтай байгааг харуулж байгаа явдал юм.'</p> <p>Хороо нь 'minimum core obligations'-ийг боловсруулахдаа улс орнуудын зүгээс конвенцоор хүлээн үүргээ биелүүлэхэд нөөц боломж байхгүй гэдгийг шатлгаан болгохгүй зорилготой юм.</p>
---------	---

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

Олон улсын хүний эрхийн гэрээний онцлог шинж		
Нэр Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц	Хүчин төгөлдөр болсон огноо 2006 он	Гишүүн улсын тоо 147 гаруй
Хамгаалж буй эрх	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бүх эрхүүд, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино.</p> <p>Конвенцид зааснаар</p> <ul style="list-style-type: none"> • Амьд явах эрх • Хүмүүнлэгийн гамшиг болон эрсдэл бүхий нөхцөл байдалд хамгаалдагдах • Хуулийн өмнө эрх тэгш байх, • Шүүх ажиллагаанд хүртээмжтэй оролцох, • Эрх чөлөөтэй, халдашгүй байх, • Эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бус нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх, • Аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх эрх, • Чөлөөтэй, зорчих, иргэний харьяаллаа чөлөөтэй сонгох эрх, • Бие даан амьдрах эрх, • Үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэх, мэдээлэл хүртэх эрх чөлөө, • Хувийн нууцаа хүндэтгүүлэх, • Орон байр болон гэр бүлээ хүндэтгүүлэх, • Боловсрол олж авах, • Эрүүл мэндээ хамгаалуулах, • Нөхөн сэргээх, • Хөдөлмөр эрхлэх, • Нийгмийн халамж хүртэх, • Улс төр, нийгмийн амьдралд оролцох, • Соёлын амьдралд оролцох, чөлөөт цаг амралтаа өнгөрүүлэх, спортоор хичээллэх гм. 	

Хяналтын механизм	<p>Хүний эрхийн хороо нь пактад тодорхойлсон эрхийн зөрчлийн талаарх зөрчлийг хянах механизм бий болгосон. Хүний эрхийн хороо нь пактад оролцогч улс орнуудаас сонгогдсон 12-18 бие даасан шинжээчээс бүрддэг. Хорооны үүрэг нь;</p> <p>(a) Оролцогч улс орнуудын тайланг хянаж хэлэлцэх;</p> <p>(b) Ерөнхий зөвлөмж бэлтгэх;</p> <p>(c) Пакт болон пактын эхний нэмэлт протоколын хүрээнд зөрчигдсөн эрхийн талаарх хувь хүний гомдлыг хянах.</p>
Олон нийтэд хүлээлгэсэн үүрэг, хариуцлага	<p>Нийтлэг үүргүүд</p> <p>1. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчилалгүйгээр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг оролцогч улсууд хангаж, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээнэ. Эл зорилгоор оролцогч улсууд дараах үүрэг хүлээнэ:</p> <p>A) энэхүү конвенцид заасан эрхийг эдлүүлэхийн тулд хууль тогтоох, захиргааны болон холбогдох бусад арга хэмжээ авна;</p> <p>B) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчилах явдлыг үүсгэж байгаа бүхий л хууль тогтоомж, дүрэм журам, зан заншил, уламжлалыг арилгах, өөрчлөх бүхий л зохистой арга хэмжээг авна;</p> <p>C) төрийн бүх бодлого, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдлыг тусгана;</p> <p>D) энэхүү конвенцид үл нийцэх үйлдэл, эсхүл дадал зуршил гаргахаас татгалзаж, төрийн эрх бүхий албан тушаалтан, байгууллагыг энэхүү конвенцид нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх явдлыг хангана;</p> <p>E) аливаа этгээд, байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн зүгээс хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас алагчилах явдлыг устгахад чиглэгдсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авна;</p> <p>F) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тусгай хэрэгцээг хангахад чиглэсэн аль болох хамгийн бага тохируулга шаардагдах бөгөөд хамгийн бага үнэ өртөгтэй энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд тодорхойлсон түгээмэл загвар бүхий бараа, үйлчилгээ, тоног төхөөрөмж болон хэрэгслийг зохион бүтээх, боловсруулах, энэ талаар судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих, тэдгээрийг ашиглахад дэмжлэг үзүүлэх, түүнчлэн стандарт, гарын авлагыг боловсруулахдаа түгээмэл загварыг тусгуулах явдлыг дэмжинэ;</p> <p>G) хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирсон, юуны өмнө өртгийн хувьд хямд шинэ технологи, түүний дотор мэдээлэл харилцааны технологи, хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологийг боловсруулах, энэ талаар судалгаа шинжилгээ хийхийг хөхиүлэн дэмжих;</p> <p>H) хөдөлгөөн хөнгөвчлөх хэрэгсэл, тоног төхөөрөмж болон туслах технологи, ялангуяа шинэ технологи, тусламж үзүүлэх бусад хэлбэр, нэмэлт үйлчилгээ болон объектын талаархи мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох;</p> <p>I) туслалцаа, үйлчилгээг сайжруулах үүднээс энэхүү конвенцид заасан эрхийг эдлэхэд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харьцаж ажилладаг мэргэжилтнүүд, ажилтнуудыг сургах ажлыг дэмжих.</p> <p>2. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд эдгээр эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх нөхцөл байдлыг аажмаар бий болгох үүднээс оролцогч улс бүр олон улсын эрх зүйн дагуу нэн даруй үүсэх энэхүү конвенцоор хүлээлгэсэн үүрэгтэй үл харшлах байдлаар өөрийн боломжит нөөцийг дээд хэмжээгээр ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагаанд түшиглэнэ.</p> <p>3. Энэхүү конвенцийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого хөтөлбөрийг боловсруулж мөрдөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой бусад шийдвэрийг гаргахдаа оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй зөвлөлдөх бөгөөд тэднийг төлөөлөх байгууллагаар дамжуулан тэднийг идэвхтэй оролцуулна.</p>

Олон нийтэд хүлээлгэсэн үүрэг, хариуцлага	<p>4. Энэхүү конвенцийн аль ч заалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд эрхээ эдлэх давуу боломж олгосон аливаа улсын дотоодын хууль тогтоомж, эсхүл тухайн улсын хувьд хүчин төгөлдөр олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх явдалд нөлөө үзүүлэхгүй. Энэхүү конвенцид оролцогч аливаа улсын хууль тогтоомж, конвенц, дүрэм журам, зан заншлаар хүлээн зөвшөөрсөн буюу хэрэгжүүлж байгаа хүний аливаа эрх, үндсэн эрх чөлөөг энэхүү конвенцид тэдгээр эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөөгүй буюу доогуур хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн гэх шалтгаанаар хязгаарлах буюу бууруулж болохгүй.</p> <p>5. Энэхүү конвенцийн заалт бүхэн холбооны улсын хувьд бүх нутаг дэвсгэрт ямарваа нэгэн ялгаа, хязгаарлалтгүй үйлчилнэ.</p>
Ялгарах онцлог	<p>Энэхүү конвенцийн зарчмууд нь:</p> <p>A) сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;</p> <p>B) алагчилахгүй байх;</p> <p>C) нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;</p> <p>D) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний ялгаатай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;</p> <p>E) тэгш боломж олгох;</p> <p>F) хүртээмжтэй байх;</p> <p>G) эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй байх;</p> <p>H) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах.</p>
Тайлбар	<p>Энэхүү конвенцийн зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд оршино.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.</p>

Нэмж унших ном товхимол, эх сурвалж

1. Хүний эрхийн гэрээ, конвенциуд (<http://www.mn-nhrc.org/78>)
2. Хүний эрхийн Зөвлөлөөс баталсан тогтоолууд, Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжүүд
3. Хүний эрхийн гэрээний хороодоос батлан гаргасан ерөнхий санал, зөвлөмжүүдийн эмхэтгэл, Улаанбаатар хот, 2004 он
4. Хүний эрхийн олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит илтгэлүүд, НҮБ-ын холбогдох хороодоос Монгол Улсын Засгийн Газарт өгсөн Зөвлөмжийн эмхэтгэл (1977-2014), Улаанбаатар хот, 2014 он
5. “Эрх зүйн эх толь бичиг” С.Нарангэрэл, нэмж засварласан хоёр дахь хэвлэл, Улаанбаатар хот, 2008 он
6. “Олон Улсын хүний эрхийн билл” Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээний эмхэтгэл, ХЭҮК, Улаанбаатар хот, 2015 он
7. <https://www.youtube.com/watch?V=wp1v5ab2tou> Хүний эрх гэж юу вэ? Видео бичлэг

Тохиолдол шинжлэх:

Орон сууцаар хангагдах эрх ба албадан нүүлгэлт

Энэхүү тохиолдол нь нэгэн ижил нөхцөл байдалд орж байсан дэлхий дээрх цөөнх хүмүүст тохиолдсон явдлаас сэдэвлэсэн юм. Анук цөөнх гэдэг улс дэлхий дээр байхгүй бөгөөд зарим нөхцөл байдал нь Монгол улсад илрэлээ олсныг тохиолдол шинжлэх явцад харьцуулан шинжилнэ. Тиймээс оролцогчдод сонирхолтой байх бөгөөд өөрийн улс орны нөхцөл байдлыг харьцуулан гаргаж ирэх, шийдлийг эрэлхийлэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох, олон улсын гэрээ конвенцийн дагуу хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх зэрэг олон асуудлыг санал бодлоо хуваалцан хэлэлцэн, ойлгоход ач холбогдолтой юм. Тус тохиолдол нь Слатви болон Ванитаскан гэсэн хоёр улсад байрлах Анук гэдэг цөөнхийн нөхцөл байдлыг үзүүлдэг. Энэ хоёр улс хоёулаа олон улсын бүх үндсэн гэрээ, холбогдох нэмэлт протоколуудыг ямар нэгэн нэмэлт тайлбаргүйгээр соёрхон баталсан. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) Тусгаар тогтносон улс орнууд дахь уугуул болон овгийн хүмүүсийн тухай 169 дүгээр конвенцийг соёрхон баталсан. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1992 онд баталсан Үндэстний, угсаатны, шашны, хэлний цөөнхөд хамаарах хүмүүсийн тунхаглал бол заавал биелэгдэх шинжтэй баримт бичиг биш бөгөөд дээрх хоёр улс энэ тунхаглалд гарын үсэг зурсан.

Энэхүү Тохиолдол шинжлэх нь хоёр хэсэгтэй. Нэгт Анук цөөнхийн бүхий л нөхцөл байдлыг авч үзнэ. Дараагийн хоёр хэсэгт дараах хүний эрхийн тодорхой асуудлыг судална. Үүнд:

Тохиолдол шинжлэх – I хэсэгт Анук хүмүүсийн хоёр нэгдлийг хүчээр Слатвийн засгийн газар нүүлгэж, өөрсдийн ашиг тусын тулд Анукын газарт газрын тосны компани ажиллах боломж олгосон нөхцөлийг авч үзнэ.

Тохиолдол шинжлэх – II хэсэгт нүүлгэн шилжүүлснээс үүссэн эдийн засгийн хүнд байдлын улмаас нэгэн охинд тулгарсан нөхцөлийг авч үзнэ.

Зөвлөмж

1. Холбогдох материалууд:

Тохиолдол шинжлэх: Ерөнхий мэдээлэл

Газрын зураг

Тохиолдол шинжлэх I хэсэг, II хэсэг

2. Хэргийг уншихдаа:

Тухайн тохиолдлын мөн чанараас хамаарч 15-30 минутыг чухал мэдээллийг олж авахад зарцуулна. Оролцогч бүр юу болсон, хэн оролцсон, ямар асуудал болсон талаар нийтлэг ойлголттой эсэхийг нягтлаарай.

3. Чиглүүлэгч Тохиолдол шинжлэх аргыг хэрхэн гүйцэтгэхээ өөрөө шийдэх бөгөөд үр бүтээмжийг дээшлүүлэхэд анхаарч, цагаа хуваарилна. Бүлгүүдэд хуваагдах, эсвэл нэгдсэн байдлаар хэлэлцүүлэг өрнүүлж болно.
4. Сүүлчийн 30 минутын хугацааг дүгнэлт хийхэд зориулна. Оролцогчдын байр суурийг хүндэтгэн, чиглүүлэгч өөрийн саналыг хуваалцаарай.

Тохиолдол шинжлэх: Ерөнхий мэдээлэл

Анук хүмүүс нь хөрш зэргэлдээ Слатви, Ванутаскан гэсэн хоёр улсын хүн амын дунд цөөнхөд тооцогддог. Слатви улсад Анук 22 сая хүн амын 10 хүртэл хувийг, Ванутаскан улсад 3 сая хүн амын 5 хувийг эзэлдэг. Хоёр улс дахь Анук хүмүүсийн амьдарч буй газар нутаг хиллэн оршдог. Анук нь нүүдлийн амьдралын хэв маягтай, бараа зарах байдлаар аж амьдралаа залгуулдаг

боловч ихэнх Анукчууд газар нутгаасаа гарахгүй амьдардаг. Слатви, Ванутасканы засгийн газар Анукын газар нутгийг эртнээс уламжлан ирсэнд гэж үздэггүй.

Анук хүмүүсийн нийтлэг нэгдэл нь Анук биш нэгдлүүдээс тусдаа байдаг. Дэлхийн хоёрдугаар дайны дараа Слатви, Ванутаскан улсын хүн амаас Анукыг салгах явдал ихэссэн. Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь Анук болон нийт хүн амын арьс үндэс, шашин, соёлын ялгааны талаарх олон нийтийн санаа бодлыг дэвэргэхэд тусалсан. Анук нь гаднаас ирсэн, ядуу, засгийн газрын дэмжлэгийг авах хүсэлгүй гэж харж байсан, харсаар ч байна. Олон улс төрчид Анукын эсрэг үзэл бодлыг олны дунд илэрхийлж амжилттай карьер хөөсөн ажээ.


Анукыг цагдаа нар ямагт хууль бусаар баривчилдаг (Анук угсааны хүмүүс биш байсан ч). Олон Анук хүмүүс хулгай, хүчирхийлэл, зүй бус үйлдэлд өртсөн талаар цагдаад мэдээлэхэд үл тоох, эсвэл бүртгэж авахаас татгалздаг.

Засмал зам Анукын газар нутаг хүртэл үргэлжилдэг. Цэвэр ус, ариун цэврийн нөхцөл ярих боломжгүй. Бохир зайлуулах шугамгүй. Зарим эрүүл мэндийн үйлчилгээг авах боломжтой ч дундаж Анук хүнийн хувьд маш өндөр төлбөртэй.

Слатви улсад, энгийн нэгэн Анук гэр бүлийн сарын орлого 20 ам.доллар байдаг нь дундаж Слатви айлаас хамаагүй хол зөрүүтэй. Ванутаскан дахь Анук нь бага зэрэг дээр буюу сард 25 ам.долларын орлоготой.

Бага орлоготой уялдан, ажилгүйдлийн түвшин маш өндөр бөгөөд олон Анук эцэг эх өөрийн хүүхдээ асрамжийн газар өгөх (даац хэтэрсэн), гудамжинд мөнгө гуйлгахаар хөөх хэвийн үзэгдэл болсон. Хөвгүүд машин угаалга, засварын газар ажиллаж, охид бие үнэлэгч болдог. Сургуульд үлдэх боломжтой хүүхдийн хувьд, тэднийг Анук биш хүүхдээс салган, нэг багшид зуун суралцагч байхаар анги бүрдүүлдэг. Слатви, Ванутаскан улсад, Анук биш хүүхдийн сурч буй анги дахь багш суралцагчийн харьцаа 1:40 байдаг.

Слатви, Ванутаскан улсын газрын зураг



Тохиолдол шинжлэх, I хэсэг: Орон сууцаар хангагдах эрх, нүүлгэн шилжүүлэлт

2004 оны эхээр Слатвийн засгийн газар өөрийн улсын өмнөд хэсэгт газрын тосны талбай бий болгохоор үндэстэн дамнасан газрын тосны компанитай гэрээ байгуулж, гарын үсэг зурсан. Тус газрын тосны компани нь газрын тосны цооног ухахаар Анукын газар нутгийн зарим хэсэгт ажиллах болсон. Слатвийн засгийн газар, газрын тосны компанийн байгуулсан гэрээ нь Анукын ямар төлөөлөлгүйгээр байгуулагдсан. (Слатвийн засгийн газарт Анукын нэг ч төлөөлөл байхгүй,

Анукын газар нутгийг хөгжүүлэх шийдвэрийн талаар улс төрийн түвшинд ямар ч асуудал гараагүй.)

Гэрээнээс үүдэлтэй нэг үр дагавар бол нэг жилийн хугацаанд Анукыг хүчээр нүүлгэн шилжүүлэх байсан. Хоёр тосгоны 10000 гаруй хүмүүсийг зүүн хойд зүг үрүү хэт их хүнтэй Анукын газар нутаг уруу нүүлгэхээр хүчилсэн. Засгийн газар, газрын тосны компани нь шилжин суурьшсан Анук гэр бүлд 6 сарын цалинтай тэнцүү хэмжээний нөхөн төлбөрийг дасан зохицох, суурьшихад зарцуулах мөнгө өгөхөө амласан байна.

Анукын удирдагч нараас Слатвийн парламентад гаргасан гомдлыг үл тоосон. Хоёр тосгоны хэсэг Анук иргэд парламентын барилгын өмнө тайван замаар жагссан боловч цагдаагийн зүгээс хүч хэрэглэн, нулимс асгаруулах хийгээр тараасан байна. Цөөнгүй Анук хөнгөн бэртэж, 21 хүнийг амгалан тайван алдагдуулсан гэж баривчилжээ.

3 сарын 13-ны өдөр гэхэд хүчээр нүүлгэн шилжүүлэх өдрөөс хоёр долоо хоногийн өмнө ямар ч Анук гэрээ орхиогүй байжээ. Төрийн албан хаагчид 3 сарын 27-ны өдөр байшингаас хөөхийг байнга мэдэгдэж байлаа. Анук эсэргүүцэгчдийн жижиг бүлэг нь хоёр тосгоны ойролцоо байрлах Слатви, Ванутасканы хооронд байрлах хурдны гол замыг хаахаар шийджээ. Ялангуяа хоёр улсын хилийн дэргэдэх гүүрийг хаасан байна. Өөрийн машинуудыг хаалт болгон, хагас автомат буугаар зэвсэглэж, эсэргүүцэгч тээврийн замыг амжилттай хааж, хоёр улсын хоорондын хүнсний хангамжийн урсгалыг саатуулсан. Эсэргүүцэгчид гүүрийг дэлбэлэхээр заналхийлж, газрын тосны компанийг гарах, Анукын газар нутгийг орхихыг хүсчээ. Орон нутгийн ТББ маргааныг тайван замаар шийдэхийг хичээсэн ч эсэргүүцэгчид ярилцахыг огт хүсээгүй байна.

Засгийн газар шуурхай хариу үйлдэл авсан. Орон нутгийн цагдаагийн албан хаагч тухайн нөхцөл байдлыг гартаа авахыг хүссэн ч эсэргүүцэгчдийн бололцоог дутуу үнэлж, буудалцаан болжээ (цагдаа, эсвэл Анукаас хэн эхэлж галласан нь тодорхойгүй). Нэг цагдаа буудуулсны дараа хүчээ татсан байна.

Засгийн газрын зуучлагч, газрын тосны компанийн төлөөлөгч тухайн газар хоёр өдрийн дараа очиж, таван үеэрээ Анук тосгонд амьдарсан, өөрийн гэсэн аж ахуйтай залуу – эсэргүүцлийн удирдагчтай уулзахыг хүсчээ. Гурвалсан уулзалт үр дүнд хүрээгүй. Эсэргүүцэгчид гүүрэн дээрх хаалтаа үргэлжүүлсээр байв.

3 сарын 27-ны өдөр газрын тосны компани газар ухахаар бэлтгэж эхэлсэн ба цагдаагийн оронд засгийн газраас зэвсэгт хүчин илгээжээ. Хоёр долоо хоног хаалт хийсний улмаас Слатви, Ванутаскан улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөн, өөр хол замаар ачааны машинаар тээвэрлэж байв. 4 сарын 3-ны өдөр цэргийн хүчин бүх эсэргүүцэгчдийг гүүрнээс зайлуулж, зам чөлөөлөх тушаал авчээ. Тулааны дараа нэг цэрэг, дөрвөн эсэргүүцэгч амь үрэгдэж, хүчээр эсэргүүцлийг даран, эсэргүүцэгчдийг баривчилжээ.

Цаашид тулалдахыг хүсээгүй хоёр тосгоны хүмүүс засгийн газрын шаардлагыг хүлээн зөвшөөрч, зүүн хойш нүүхдээ өөрийн эд хогшлыг авч, гэрээ орхин оджээ. Тэд Анук биш хүмүүсийн дэргэд байрлаж, газар нутгийнхаа хязгаарт түр оромж барин суужээ. Шилжин суурьшсан Анук гэр бүлд зургаан сарын цалинтай тэнцэх нөхөн төлбөр өгсөн ч суурьших, шинэ байшин авахад шаардлагатай амласан мөнгөө өгөөгүй байна. Газрын тосны компани Анук хүмүүсийг явснаас хойш хоёр сарын дотор үйл ажиллагаагаа эхэлжээ. Гурван сарын турш ямар нэгэн шүүх хуралгүйгээр хоригдсон эсэргүүцэгчид 10 жил хоригдохоор болжээ.

Нэг жилийн дараа шилжин суурьшсан Анук хүмүүсийн дийлэнх нь түр оромжиндоо амьдарсаар байна. Цахилгаан, цэвэр ус байхгүй бөгөөд дундаа 20 бие засах өрөө хувааж хэрэглэдэг. Хүүхдүүд сургуульд ороогүй байна.

Анук биш хүмүүс дэргэд нь суурьшин, аж төрж байгаа Анук хүмүүсийн талаар маш уурсан ярилцах болсон.

Ихэнх хүмүүс Анукыг “залхуу, хариуцлагагүй” гэж боддог ба гэмт хэрэг үйлдэхээс сийхгүй гэж төсөөлдөг. Мөн тэдний ажлыг булаах учраас Анук хүмүүст ажил өгөх хэрэггүй гэж үздэг. Зарим нэг Анук хүмүүс ажил олсон ч цэвэрлэгчээс хэтрээгүй байна.

Тохиолдол шинжлэх, II хэсэг: Эмэгтэйчүүд, хүүхдийн эрх

Дээрх үйл явдлаас хойш хоёр жил өнгөрчээ. Летишиа бол Слатви дахь Анук нийтлэг нэгдэлд амьдрах 18 настай эмэгтэй. Уг нэгдэл газрын тосны компани шинээр цооног ухаж байгаа газрын зүүн хойд хэсэгт байрладаг. Түүнийг бусад хүмүүсийн хамт засгийн газраас хоёр жилийн өмнө хүчээр нүүлгэсэн билээ. Тухайн үед Летишиа өөрийн нэгдэлд байрлах дунд сургуулийн сурагч байсан. Түүнийг нэгдүгээр ангид байхад нүүлгэн шилжүүлсэн бөгөөд шинэ газар дунд сургууль байгаагүй. Гэр бүлийнхэнтэйгээ шинэ газар амьдрахын тулд бүгдээрээ мөнгө олох шинэ арга замыг хүчээр сонгох болсон. Урьд нь таван үеэрээ эрхэлсэн өөрийн гэсэн аж ахуйтай байжээ.

Нүүлгэн шилжүүлсэн зарим Анук хүмүүсийн гэрт компанийн ажилтнуудыг суулгах хэрэг гарсан. Учир нь компани үйл ажиллагаагаа эхлэхдээ байшин барилгыг цооног барихын тулд нураахаар төлөвлөж байсан ч цооног барих ажилтнуудад байр сууц хэрэг болсон тул шинээр барихгүйгээр хуучин байшинг ашиглахаар шийджээ. Иймээс өндөр цалинтай ажилтнууд сууцандаа гэрийн үйлчлэгч хөлслүүлэн ажиллуулах болсон. Летишиа 17 настайдаа нэгэн ажилтны гэрийг цэвэрлэж эхэлсэн байна.

Түүний ажил өглөө 8 цагаас орой 7 цаг хүртэл үргэлжлэх ба 7 хоногт 5 өдөр ажилладаг. Түүнд жирийн Анук хүний сарын орлогоос их мөнгө өгөх боловч дундаж ажилтны цалингаас доогуур юм. Хоёр дахь 7 хоногийн ням гарагт гэртээ харьж, орлогоо бусадтайгаа хуваалцдаг байна. Харин ажил олгогч түүнийг биеэрээ болон хэлээрээ доромжлох ба гурван сарын дотор охиныг хүчиндэж, жирэмсэн болгожээ.

Жирэмсэн болсон охин, түүний хэвлий дэх хүүхэд нь түүнийг цагдааг баригдах хангалттай шалтаг тул түүнтэй хамт байхыг хүссэнгүй. Ажил олгогч түүнийг халж, охин гэртээ иржээ. Слатви улсын хуульд зааснаар хүүхдийн эцэг тодорхойгүй бол тухайн хүүхдэд Слатви улсын иргэншил олгодоггүй ажээ. Иймээс охиноос төрсөн хүүхдийг төрийн зүгээс иргэнд тооцсонгүй. Летишиа ажилгүй болсон тул хүүхдийнхээ эрүүл мэндийн хэрэгцээг хангах боломжгүй болсон ба түүний гэр бүл түүнийг хүлээж аваагүй байна.

Летишиа зүй бус үйлдлийн золиос болсон олон эмэгтэй амьдардаг нэгэн байшин уруу дүрвэжээ. Энэхүү умгар өрөөтэй жижигхэн байшин ямагт дүүрэн, толгой хоргодох газар л олох боломжтой байхаас гадна олон арван эмэгтэйд өчүүхэн идэх юм олддог байна. Энэ байшинг тухайн орон нутгийн эмэгтэйчүүдийн хандиваар авч явдаг ажээ. Летишиа өвчтэй хүүхдээ эмнэлэгт үзүүлэх хангалттай мөнгө олсны дүнд эмчтэй уулзжээ. Харин эмч шинжилгээгээр түүний хүүхдийг ДОХ-ын вирустэй болохыг мэдэгдсэн байна.

Тохиолдол шинжлэх, I хэсэг: Орон сууцаар хангагдах эрх, нүүлгэн шилжүүлэлт

Дасгал ажил хоёр хэсэгтэй.

- Эхний хэсэгт оролцогчид багуудад хуваагдан, зөвлөмжийн дагуу Тохиолдол шинжлэх нөхцөлийн дагуу задлан шинжилж, өөрсдийн дүгнэлтийг бусаддаа танилцуулна.
- Чиглүүлэгч нь багуудын мэдээллийг сонссоны дараа эрхэд суурилсан хандлагын дагуу чиглүүлж, дүгнэнэ.

60 мин. Эхний хэсэг багаар ажиллах

- Эрхэд суурилсан хандлагыг ашиглан, цаг хугацааны дагуу үйл явдлыг задлан шинжилнэ. Огноо бүр дэх тодорхой эрхийн асуудлыг илэрхийлж, хохирогч болон зөрчигч этгээд, холбогдох олон улсын гэрээнд хамааралтай заалтыг олох, хамаарах төрийн үүргийг сонгож, Хүснэгт 1-т хариултаа бичнэ.

- Хэлэлцүүлгийн үеэр төрийн үүргээр дамжуулан ямар эрхийг хамгаалж, хөхиүлэн дэмжиж, хүндэтгэж, хангаж болох арга замыг анхааран, шууд стратеги хэрэгжүүлэх замаар, эсвэл дэвшилтэт байдлаар биелүүлснээс амжилт олсон эсэхийг нягтална.
- Тухайн зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэхийн тулд юу хийж болох вэ? Хүснэгт 1-ийг ашиглан, задлан шинжилгээгээ бичнэ. Эрхэд суурилсан хандлагыг ашиглан, өөр өөр этгээдээс хэн нь ямар арга хэмжээ авахыг тодорхойлно.
- Өөрийн бэлтгэсэн мэдээлэл болон чиглүүлэгчийн санал бодлыг сонссоны эцэст нэгдсэн байдлаар тайлагнахад бэлтгэнэ.

Чиглүүлэгч дараах асуултыг тавих замаар мэдээллийг нэгтгэнэ.

- Хүчирхийлэл/зөрчил гарахын өмнө ямар шинж тэмдэг гарсан бэ?
- Энэхүү зөрчилдөөн хэн эрх мэдэлтэй байна вэ? Тайлбарлана уу.
- Хэрхэн Анукийн өмнө төрийн зүгээс хүлээсэн үүргийг хариуцлагатай болгох вэ?
- Анукийн эсрэг ялгаварлан гадуурхалтаас хэрхэн урьдчилан сэргийлэхээр юу хийж болох вэ?
- Манай улс дахь нөхцөл байдалтай уг тохиолдол хэрхэн холбогдож байна вэ?


Хүлээж буй үр дүн:

- Аливаа асуудлыг шийдвэрлэхэд хүний эрхэд суурилсан хандлагаар хандах нь чухал

Хүснэгт 1: Төрийн үүргийг задлан шинжлэх нь

Хүний эрхийн тодорхой асуудал	Хохирогч/Зөрчигч	Холбогдох олон улсын гэрээ	Төрийн үүрэг
Жишээ: 1-2 сар: Анук эсэргүүцэгчид нийслэл дэх парламентын барилгын өмнө жагссан.	Жишээ: Анук жагсагчид/Цагдаа	Жишээ: ИБУТЭТОУП	Жишээ: Тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх
Жишээ: 12 сар: Нүүсэн Анук хүмүүс түр оромжиндоо амьдарсаар байна.	Жишээ: Анук нэгдэл/ Засгийн газар	Жишээ: ЭЗНСЭТОУП	Жишээ: Хүчээр нүүлгэхтэй холбоотой нөхөн төлбөр

Шийдвэр гаргах, бодлого боловсруулах, хөгжлийн хөтөлбөрийг төлөвлөх зэрэгт эрх агуулагч болон үүрэг хүлээгч этгээдүүдийн оролцоог тэгш хангах шаардлагатай.



Дасгал 2. Эмэгтэйчүүдийн болон хүүхдийн эрх

Тохиолдол шинжлэх, II хэсэг: Эмэгтэйчүүд, хүүхдийн эрх

Энэ дасгал гурван хэсгээс бүрдэнэ.

1. Эхний хэсэгт та Летишиагийн тохиолдол дээр илтгэл бэлтгэх даалгаврыг багуудад өгнө.
2. Дараах хэсэгт та багуудын бэлтгэсэн илтгэлд нь арга хэмжээ, үр дүнг тодорхойлуулж, бүгдээрээ задлан шинжилгээтэй танилцана.
3. Сүүлийн хэсэгт чиглүүлэгч асуулт тавих замаар нэгтгэн дүгнэнэ.

30 мин Багаар ажиллах

1. Өөрийгөө ТББ, эсвэл хүний эрхийн үндэсний комиссын гишүүн гэж төсөөлөн, Летишиагийн

нөхцөл байдлыг судлан, уг тохиолдлын тухай илтгэл бэлтгэхийг оролцогчдоос хүснэ.

2. Хүснэгт 2-ыг ашиглан өөрийн илтгэлд хамаатай үйл явдлуудыг бичихийг оролцогчдоос хүснэ. Энэхүү хүснэгт нь Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг устгах асуудал эрхэлсэн хороонд гомдол гаргах НҮБ-ын маягтад суурилсан болохыг хожим хэлж болно.

Чиглүүлэгч дараах асуултыг тавих замаар мэдээллийг нэгтгэнэ. Үүнд:

- Та илтгэлээ хэнд илгээх вэ?
- Энэ тохиолдолд ямар эрхүүд зөрчигдсэн бэ?
- Летишиа болон түүний хүүхдийн өмнө төр ямар үүрэг хүлээх вэ?
- Энэ тохиолдолд өөр ямар этгээд оролцсон бэ?
- Летишиагийн эрх нь хүүхэд байхдаа болон насанд хүрсэн үедээ ялгаатай юу?

30 мин Бүлгээр ажиллах

Эхний алхамд ярилцсан хэлэлцүүлэгтээ тулгуурлан, цаашид авах арга хэмжээг санал болгож, эдгээрээс хүлээж буй үр дүнгээ бичихийг оролцогчдоос хүснэ. Хүснэгт 3-т өөрийн хариултыг бичихийг оролцогчдод хэлнэ.

Чиглүүлэгч дараах асуултыг тавих замаар мэдээллийг нэгтгэнэ. Үүнд:

- Тухайн гэрээний заалтын дагуу таны тодорхойлсон ямар зөрчилд анхаарч, арилгахад чиглэсэн ямар төрлийн арга хэмжээ авч болох вэ?
- Эдгээр арга хэмжээнээс ямар үр дүнг (урт болон богино хугацаанд) хүлээж байна вэ?
- Тухайн санал болгосон арга хэмжээг баталгаажуулахад ТББ ямар үүрэгтэй оролцож болох вэ?
- Летишиа бол хүүхэд, эмэгтэй хүн, цөөнхөд хамаарч байгаа хүн, гэрийн үйлчлэгч гэдгээрээ хүний эрхийн зөрчлийн хохирогч. Харилцан адилгүй эрхийн төлөө үний эрхийн хамгаалагч хэрхэн ажиллаж болох вэ? Зарим эрхийг бусдаас нь дээгүүрт үзэх үү? “Бага”, “муухан” ач холбогдолтой эрх байна гэж тодорхойлох уу? Хамгийн үр нөлөөтэй хандлага нь юу байж болох вэ?
- Манай улс дахь нөхцөл байдалтай уг тохиолдол хэрхэн холбогдож байна вэ?

Хүлээж буй үр дүн: Чиглүүлэгч дараах нөхцөлд хүргэхийг чиглүүлнэ.

- Үндэсний болон олон улсын механизмын ашиглах боломжийг мэдэрсэн байна.
- Иргэд хүртэл зөрчилдөөнийг арилгах, бууруулахад хувь нэмэр оруулах боломжтойг онцолно.
- Төрийн зүгээс дур зоргын бус, үүрэг хүлээгчийн хувиар аливаа үйлдэл хийж байгаа эсэхийг хянах боломжийг олж харсан байна.

Хүснэгт 2: Летишиагийн хэргийн талаар илтгэхэд зориулсан мэдээлэл

Таны илтгэлд зориулсан мэдээлэл	
1. Хохирогчийн нэр
2. Хохирогчид хамаарах мэдээлэл	
Нэр
Нас, төрсөн газар
Харьяалал/Иргэншил
Хүйс
Гэрлэсэн байдал /хүүхэдтэй эсэх
Мэргэжил
Үндэс угсаа, шашны итгэл үнэмшил, нийгмийн бүлэг (чухал бол)
Оршин суугаа хаяг
3. Төрийн талаас анхаарах мэдээлэл	
Холбогдох төр (улс)
4. Зөрчлийн мөн чанар	
Өөрийн шаардлагыг илэрхийлэх дэлгэрэнгүй мэдээлэл:	
4.1 Тухайн зөрчлийн тодорхойлолт, зөрчигч этгээд, огноо, газар	
.....	
.....	
4.2 ЭЭЯГБХУТК, эсвэл ХЭТК-ийн заалтаас зөрчсөн эсэх. Олон асуудал байвал тус бүрд нь ялгаж бичих.	
.....	

Хүснэгт 3: Санал болгох үйл ажиллагаа

Санал болгох үйл ажиллагаа	Хүлээж буй үр дүн

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛАН ХӨГЖИХ ХАНДЛАГА

Хүний эрхэд суурилсан хандлага гэж юу вэ?

Сүүлийн жилүүдэд хүний эрхэд суурилан хөгжих хандлага ихээхэн чухлаар тавигдах болсон билээ. Энэ нь ядуурлыг тогтвортойгоор бууруулахад ихээхэн дутагдаж ирсэн хэрэгцээнд-суурилсан буюу үйлчилгээ-хүргэх хандлагууд ихээхэн хүлээн зөвшөөрөгдөж, чухалчлагдах болсны үр дүн юм. Эдгээр хандлагуудын нэгэн хязгаарлагдмал тал бол уг хандлагууд нь олонх тохиолдолд ядуу хүмүүсийн хэрэгцээ, шаардлагыг үл мэдрэх эрх баригчдын зүгээс авч хэрэгжүүлдэг явдал юм. Хүний эрх, хөгжил болон идэвхтэй оролцоо зэргийг хослуулах нь дан ганц хандлагыг баримтлахаас илүү үр дүнтэй болох нь харагдаж байна.

1997 онд танилцуулсан НҮБ-ын Шинэчлэлтийн хөтөлбөрийн хэсэг болгон НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын зүгээс НҮБ-ын тогтолцооны бүхий л байгууллага, салбарууд үйл ажиллагаа, хөтөлбөрүүддээ хүний эрхийн үзэл баримтлалыг үйл хэрэг болгон ажиллахыг уриалсан байна. Энэ нь байгууллага хоорондын хэлэлцүүлэг, хамтын ажиллагааг эхлүүлж, улмаар НҮБ-ын Хөгжлийн бүлгэмээс хүлээн зөвшөөрсөн “НҮБ-ын нийтлэг ойлголцлын мэдэгдэл”-ийг боловсруулсан байна (Хавсралт 1, 113 хуудсыг үзнэ үү). Уг мэдэгдэл нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд үндэслэн хөгжлийн үйл явцыг тодорхойлох, төлөвлөх, боловсруулах, мониторинг хийхэд баримтлах үзэл баримтлалын, дүн шинжилгээний болон арга зүйн хүрээг танилцуулсан болно.

Энгийнээр хэлбэл, олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандарт, зарчмуудыг хөгжлийн бүхий л үйл явц, тухайлбал, хөтөлбөр, стратеги, бодлогод нийцүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, төр, түүний байгууллагуудад хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах, хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүд эрхийнхээ төлөө тэмцэхэд нь дэмжлэг үзүүлэх үүрэг хариуцлагын тухай өргөн цар хүрээтэй ойлголт төлөвшүүлэх явдал юм.

Эрхэд суурилсан хандлагад холбогдох зарчмууд:

- *Түгээмэл, салшгүй байх*- Хүний эрх нь дэлхийн өнцөг булан бүрт амьдарч буй хүн бүрт адил тэгш, салшгүйгээр заяагдсан билээ. Хувь хүн сайн дураараа өөрийн эрхээ эдэлж чадахгүй. Үүний адилаар хэн нэгэн үүнийг бусдаас салгаж болохгүй юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйлд заасанчлан “Бүх хүмүүс нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш, эрх чөлөөтэй төрсөн” билээ.
- *Хуваагдашгүй байх*- Хүний эрх хуваагдашгүй байна. Иргэний, улс төрийн, эдийн засгийн, соёлын эрх зэрэг олон төрлөөс үл хамааран хүн бүрийн эрхэм чанартай салшгүй холбоотой. Иймээс, эдгээр нь эрх болохынхоо хувьд адил тэгш статустай бөгөөд ямар нэгэн байдлаар зэрэглэн үзэж болохгүй юм.
- *Харилцан хамааралтай, уялдаатай байх*- Аливаа нэг эрхийг хангах нь бусад эрхээсээ хэсэгчлэн буюу бүхэлдээ хамаардаг. Тухайлбал, эрүүл байх эрхээ эдлэх нь мэдээлэлтэй байх эрхээс хамаарч болно.
- *Тэгш, үл алагчлах*- Аливаа хүн бүр өөрийн төрөлхөөс заяасан эрхэм чанарын хувьд адил тэгш бөгөөд эрх эрх чөлөө нь ямар нэгэн алагчлалгүйгээр тэдэнд заяасан юм. Эрхэд суурилсан хандлага нь алагчлал болон тэгш бус байдлын асуудалд тусгайлан анхаарал хандуулах шаардлагатай байдаг. Хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдэд нийгмээс тусгаарлагдаж буй бүлгүүдийн сайн сайхан байдал, эрхийг хамгаалах асуудлыг тусгах хэрэгтэй байна. Эмзэг бүлгийнхэнд илүү их бололцоог нээхийн тулд мэдээллийг аль болох олон төрлөөр тухайлбал, хүйс, шашин, үндэс угсаа, хэл болон хөгжлийн бэрхшээлтэй эсэх зэргээр нарийвчлах шаардлагатай байна. Хөгжлийн бодлого, шийдвэр, санаачлагууд нь орон нутгийн оршин суугчдыг гэгээрүүлэх арга замыг хайдаг

бөгөөд хүчний тэнцвэргүй харилцааг хадгалахын эсрэг тэмцэх буюу дахин шинэ бүтцийг бүрдүүлэхэд зохих хувь нэмэр оруулдаг.

- *Оролцоог хангах, тэгш хамруулах*- Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэх замаар иргэний, нийгэм, эдийн засгийн, улс төрийн болон соёлын хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулах, чөлөөтэй, идэвхтэй, утга учиртай оролцох эрхтэй билээ.
- *Гэгээрэл*- Гэгээрэл гэдэг нь хүмүүс өөрсдийнхөө эрхийн төлөө тэмцэх боломжийг бий болгогч үйл явц юм. Хүмүүс өөрт нь чиглэсэн бодлого, хууль шийдвэр болон үйлчилгээг хүлээхээс илүү өөрийн эрхийн төлөө тэмцэх талаар гэгээрүүлэх шаардлагатай. Эдгээр санаачлагууд нь хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүдийн хариуцлагатай үйлдэх чадавхийг бүрдүүлэхэд чиглэн ажиллана. Үүний зорилго нь хүмүүст өөрсдийн амьдралыг өөрчлөх, амьдарч буй нийгмээ шинэчлэх, хувь заяагаа мэдэх боломж, хүч чадлыг өгөхөд оршино.
- *Эрх зүйт ёсыг дээдлэх, хариуцлагатай байх*- Эрхэд суурилан хөгжих хандлага нь “эрх эдлэгч”, “үүрэг хүлээгч” нарыг уялдуулан үзэх замаар хөгжлийн үйл явц дахь хариуцлагын түвшинг нэмэгдүүлж, үүрэг хүлээгчдийн хариуцлагаа биелүүлэх бололцоог дээшлүүлдэг. Үүнд хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх болон хүний эрхийг зөрчихөөс татгалзах зэрэг эерэг, сөрөг бүхий л үүрэг хариуцлагыг багтаан ойлгоно. Засгийн газрын хувьд хувь хүн, орон нутгийн байгууллага, албан тушаалтнууд, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, ивээн тэтгэгчид болон хөгжлийн түншлэгчид, олон улсын байгууллагууд зэрэгтэй харьцуулахад хүний эрхийг хэрэгжүүлэх талаар бусад оролцогчдоос илүү өргөн цар хүрээ бүхий үүрэг хариуцлага хүлээлгэдэг. Харин олон улсын хамтын нийгэмлэгийн хувьд нөөц болон чадавхийн хувьд хязгаарлагдмал хөгжиж буй орнуудтай үр дүнтэй хамтран ажиллах үүрэг ноогддог. Эрхэд суурилан хөгжих хандлага нь хүн бүрийн хувьд зөрчил, үгүйсгэлээс хамгаалагдах, эрхээ бүрэн эдлэхүйц эрх зүй, захиргааны практик, механизм, тогтолцоог хөгжүүлэхийг шаарддаг. Мөн олон улсын нийтлэг хэм хэмжээг орон нутгийн түвшинд нийцүүлэн хариуцлагыг дээшлүүлэх, дэвшлийг хэмжих үлгэр загвар буюу шалгуурыг (бенчмарк) бий болгохыг шаардана.

Хүний хөгжлийн болон хөгжих эрхийн тухай үзэл баримтлалуудыг улам бүр баяжуулан, нэгтгэсний үр дүнд эрхэд суурилан хөгжих хандлага нь дараах зарчмуудыг хүний эрхийн өмнө үзэрэг хүлээгчид болох улс үндэстэн, бизнесийн байгууллагууд, үндэстэн дамнасан корпораци, иргэний нийгмийн байгууллагууд, хувь хүмүүст санал болгож байна. Үүнд:

- Хүмүүс зөвхөн үйлчилгээ хүртэгч, идэвхигүй хүлээн авагч бус харин хөгжлийн гол оролцогч болохыг хүлээн зөвшөөрөх
- Хувь хүн, бүлэг, нийтлэгүүдийг гэгээрүүлэх, мэдээлэл олгох нь хөгжлийн үйл явцад дэмжлэг үзүүлж, тогтвортой байдлыг хангах
- Хөгжлийн үр дүн болон хөгжилд хүрэх үйл явцад нэгэн адил ач холбогдол өгөх, хяналт үнэлгээ хийх
- Хөгжлийн хөтөлбөрүүдийг нийгмээс тусгаарлагдсан, хязгаарлагдсан эмзэг бүлгийнхэнд илүү чиглүүлэх, ялгаатай байдлыг бууруулахад анхаарах
- Хөгжлийн бүх оролцогчдын хариуцлагатай байдлыг дэмжих зэрэг болно.

“Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй бол хэм хэмжээ нь олон улсын хүний эрхийн стандартад суурилж, үйл ажиллагаа нь хүний эрхийг хөхиүлэн дэмжиж, хамгаалахад чиглэдэг хүний хөгжлийн үйл явцын үзэл баримтлалын хүрээ юм” гэж зарим баримт бичигт тодорхойлсон байна.

Хүний эрхэд суурилсан хандлагын шинжүүд:

Хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хүний эрхийг хангахад чиглэсэн байхаар боловсруулдаг;

Олон улсын хүний эрхийн зарчим гэрээ, конвенцийн хэм хэмжээ нь бүх салбарын хөгжлийн хамтын ажиллагаа, хөтөлбөр болон тэдгээрийн бүхий л үе шатад удирдах зарчим нь болдог;

Эрх-эдлэгчид, тэдний эрх, үүрэг-хүлээгчид, тэдний үүрэг хариуцлагыг тодорхойлох бөгөөд эрх эдлэгчдийг эрхээ шаардах, үүрэг хүлээгчдийг үүрэг хариуцлагаа биелүүлэх чадавхийг бэхжүүлэхэд чиглүүлдэг;

Өнөөгийн дэлхийн дэг журмын хувьд хөгжлийн хамгийн гол оролцогч болох Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ) нь дөрвөн үнэт зүйлсийг эрхэмлэдэг. Эдгээр бол аюулгүй байдал, хөгжил, хүний эрх мөн хүрээлэн буй орчин юм. Ялангуяа дэлхийн I, II дайны улмаас тухайн үеийн дэлхий нийтийн хамгийн гол зорилго нь энх тайванч байх, хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх, дайнд сүйрч, доройтсон улс орнуудын сэргээн босгох явдал болсон бөгөөд эдгээр нь НҮБ байгуулагдах гол үндэс болж, улмаар түүний Дүрэмд тусгалаа олсон гэж үздэг. Харин хожим нь хүрээлэн буй орчны доройтол хөгжлийн томоохон саад бэрхшээл болсон тул байгаль орчны асуудлыг онцгойлон анхаарах болжээ.

Хүний эрх нь хүн бүрийг улс төрийн, эдийн засгийн, эрхзүйн болон бусад бүх хэлбэрийн хүчирхийлэл, халдлага түрэмгийлэл, ялаварлан гадуурхалтаас хамгаалахад чиглэсэн олон улсын ёс суртахууны болон эрх зүйн хэм хэмжээнүүдийн нийлбэр цогц юм.

Иймд хүний эрх ба хөгжил хоёрын хоорондын уялдаа холбоог цаашид тодруулан авч үзэхийг оролдоё. Хүний эрхийн болон хөгжлийн асуудлууд нь олон талтай, зорилго чиглэл хийгээд хүлээж буй үр дүн, үзүүлж буй үр нөлөө гээд харгалзан үзэх олон өнцөг байдаг. Тиймээс хүний эрх болон хөгжлийн үйл явц хоёр нь маш олон талт харилцаагаар холбогддог. Нийгэм хэмээх ахуйн олон талт бүтэцлэг шинжээс хамаарч хүний эрх ба хөгжлийн хамаарлыг олон түвшинд авч үзэх тул юуны өмнө хувь хүн ба нийгмийн хөгжил гэсэн ерөнхий байдлаар авч үзье. Энэ нь хүний хөгжил, хөгжих эрх ба эрхэд суурилан хөгжих гэсэн үзэл санаа, хандлагуудыг дэлгэрүүлэн үзэхэд хүргэж байна.

Хүний эрх ба хүний хөгжил:

Хүний эрх ба хөгжлийн хоорондын харилцан хамаарлыг 1970-д оноос анх авч үзэх болжээ. Энэ нь эхэн үедээ улс хоорондын хөгжлийн туслалцааны шалгуур үзүүлэлт, түүнийг үргэлжлүүлэн олгох тухай маргааны асуудлаар зонхилон яригдаж эхэлжээ. Өөрөөр хэлбэл, олонх донор орнуудын зүгээс хөгжиж буй орнуудад үзүүлэх тусламж, дэмжлэгээ үргэлжлүүлэх хийгээд татгалзах гол шалгуур нь хүний эрхийн хувьд гарсан ахиц дэвшил байжээ. Улмаар 1980-д оноос хөгжлийн хамтын ажиллагааны гол зорилго бол хамтарч буй улс орнуудад хүний эрхийг хангах, хамгаалах, ахиц дэвшил гаргах явдал хэмээн тодорхойлох болжээ. 1980-д оны сүүлчээр өрнөсөн ардчиллын давалгааны үеэс эхлэн эрх зүйт төр, эрх тэгш байдал, иргэний оролцоо, олон ургальч үзэл зэрэг ардчилал ба хүний эрхийн үнэт зүйлсийг чухалчлан үзэж, тогтвортой хөгжлийн үндэс хэмээн үзэх болсон. Энэ үеийн нэгэн гол ололт бол хөгжлийн төвд хүнийг тавьж үзэх болсон явдал гэж үздэг.

Хөгжих эрх:

1980-д оноос “Хөгжих эрх” хэмээх ойлголт олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд хэрэглэгдэх болсон бөгөөд өнөөг хүртэл олон тооны маргаан мэтгэлцээн, ялгаатай байр суурийг агуулж байна. Уг ойлголт нь нэр томъёоны хувьд анх 1981 онд “Хүний ба ард түмний эрхийн тухай Африкийн дүрэм”-ийн 22 дугаар зүйлд тусгагдсан гэж үздэг. Гэвч НҮБ-ын дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад олон улсын хүний эрхийн гэрээ конвенциудад хөгжих эрхийн

зарчим, үзэл санаа нь агуулгын хувьд бүрэн туссан гэж судлаачид үздэг байна. Улмаар 1986 онд НҮБ-ын Ерөнхий ассемблейн 41/128 тоот тогтоолоор “Хөгжих эрхийн тухай тунхаг” батлагдан гарсанаар олон улсын хүний эрхийн эрх зүйн тогтолцоонд өргөнөөр хэрэглэгдэх болсон гэж үздэг. Хүний хөгжлийн гол үзэл санаа бол хувь чадвартай, бололцоотой байснаар эрхээ эдэлж, цаашид хөгжинө гэдэгт үндэслэдэг бол хөгжих эрх нь тэрхүү чадвар бололцоо нь зөвхөн хувь хүний биш, харин бүлгийн, нийтийн эрхээ эдлэх үндэс суурь болох ёстой гэсэн байдлаар хандаж тайлбарладаг.

“Хөгжих эрхийн тухай тунхаглал”-д “Хөгжил гэдэг нь нийт иргэд, хувь хүмүүсийн идэвхит, чөлөөт оролцоонд үндэслэн гарч буй үр ашгийг шударгаар хуваарилах, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын цогц үйл явц мөн⁶” хэмээн тодорхойлсон байдаг. Үүний хамт Венийн тунхаглал болон үйл ажиллагааны хөтөлбөр (1993), Хүрээлэн буй орчин, хөгжлийн талаарх Риогийн тунхаглал (1992), Уугуул хүмүүсийн эрхийн тухай тунхаглал (2007) зэрэгт хөгжих эрхийн үзэл санаа нь илүү тодорхой зарчмууд болон тусгагдсан байна⁷. Эдгээр баримт бичгүүдэд хөгжлийн төвд хүнийг тавихын хамт хөгжил нь өөрөө хүн эрх, эрх чөлөөгөө бүрэн дүүрэн эдлэх нөхцөл, үндэс болохыг онцлон тэмдэглэдэг. Ялангуяа хөгжилд хүрээгүйгээс, хөгжих нөхцөл бүрдээгүйгээс болж, хүн эсхүл нийгмийн бүлэг эрхээ эдэлж чадахгүй байгаа нь өнөөгийн хөгжлийн түвшинд зөвтгөх аргагүй зүйл хэмээн үздэг.

Хөгжих эрхийн тухай асуудлыг анх Өмнөдийн улс орнууд ихээхэн дэмжиж байсан. Энэ нь үнэн хэрэгтээ дэлхийн Өмнөд ба Умардын улс орнуудын хоорондын харилцан тэнцвэртэй худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох эрэлд хайгуулын үр дүн гэж тайлбарлах нь бий. Нөгөө талаас хөгжлийн туслалцаа нь хөгжингүй орнуудын үүрэг хариуцлага болон үлдэх бус харин хөгжлийн хувьд тухайн улс орны төр засаг гол үүрэг хариуцлагыг хүлээж, харин бусад орнууд энэхүү хүчин чармайлтад хувь нэмрээ оруулах ёстой гэдэгт “Хөгжих эрхийн тухай тунхаглал” үндэслэдэг.

Тиймээс уг тунхаглалд заасанчлан улс орнууд хөгжилд хүрэхийн тулд, түүний үр шимийг илүү ахиу хүртэхийн тулд, эсхүл хөгжилд тээг болж буй бэрхшээл, саалд тотгор бүхнийг даван туулахын тулд харилцан бие биендээ тусалж, хамтран ажиллах ёстой гэсэн үзэл санааг агуулдаг. Аливаа засаглал цөөн хэсэг хүмүүсийн төлөө бус, нийтийн төлөө, түүний дотор эмзэг, амьдрал дорой бүлгийнхэн, үндэсний цөөнхи зэрэг эрсдэлд учраад буй хүмүүсийн төлөө үйл ажиллагаагаа чиглүүлдэг байх нь энэхүү хандлагын нэгэн үнэт чанар юм. Тиймээс хүний эрхийг хуулиар баталгаажуулж, хүний эрх, эрх чөлөө, нэр төрд халдах аливаа үйлдэл, халдлагаас хамгаалах нь төрийн гол чиг үүрэг болохыг улс орнууд хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ үүргийн биелэлт нь олон улсын харилцааны нэгэн чухал үзүүлэлт болжээ.

Хөгжих эрхийн тухай үзэл санаа нь зөвхөн өнөө үе төдийгүй хойч үеийнхэнд ч эрхээ эдлэх, хөгжих бололцоо байх ёстой гэдэгт үндэслэдэг. Тиймээс ч Хүрээлэн буй орчин, хөгжлийн талаарх Риогийн тунхаглал (1992)-ын гурав дахь зарчим нь “Хөгжих эрх нь өнөөгийн болон хойч үеийнхний хөгжлийн болон байгаль орчны хэрэгцээ нь харилцан тэнцвэртэйгээр хангагдахуйцаар хэрэгжих ёстой” хэмээн заасан байна.

Ерөөс хүний эрх, хөгжил хоёр нь харилцан бие биенээ нөхцөлдүүлж байдаг ажээ. Хүний хөгжлийн илтгэлийг санаачлагч Махбуб ул Хаакийн хэлсэнчлэн “Хөгжил гэдэг хамгийн энгийнээр хэлбэл, сонголт хийх бололцоог нэмэгдүүлэх явдал юм”. Зарчмын хувьд тэдгээр сонголтууд төгс буюу төгс бус, эсхүл бүр цаг хугацааны явцад өөрчлөгдөж ч болно. Харин хувь хүний чадавхийг нэмэгдүүлэх нь сонголт хийх бололцоог нэмэгдүүлэх гэсэн үг бөгөөд энэ нь эрүүл амьдрахаас эхлээд ажил мэргэжил, мэдлэг боловсрол, оролцоо, үзэл бодол зэрэг өргөн хүрээг хамардаг гэж үзжээ. Эдгээр чадваргүйгээр хүн өөрт заяасан боломжуудыг эдлэх боломжгүй болох бөгөөд амьдралын туршид буй болох олон боломжууд тухайн хүнд хаалттай хэвээр үлдэнэ.

⁶ UN Declaration on the Right to Development; www.unhcr.ch/html/menu3/b/74.htm

⁷ Icelandic Human Rights Centre, human Rights and development www.humanrights.is/the-human-rights-project/humanrightscasesandmaterials/ Зочилсон огноо: 2012-06-28

Хөгжлийн бодлого, хөтөлбөр хүний эрхэд суурилсан байх хэрэгцээ

Хүн бол хөгжлийн цөм субъект бөгөөд идэвхтэй оролцогч, эзэн, удирдагч, үр шимийг нь хүртэгч байх ёстой. Үүний тулд хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг хөгжлийн бодлого, хөтөлбөрт суулгаснаар эрх мэдлийн шударга бус хуваарилалтад анхаарал хандуулах, хууль дээдлэх зарчмыг хөгжлийн цөмд авчрах замаар хөгжлийн амжилтыг илүү тогтвортой болгох боломжийг бүрдүүлж болно. Өөрөөр хэлбэл хөгжлийн гол асуудлууд болох тэгш бус байдал, ялгаварлан гадуурхах практик, эрх мэдлийн шударга бус хуваарилалт зэрэгт дүн шинжилгээ хийж, анхаарал хандуулах замаар хөгжлийг илүү сайн, тогтвортой үр дүнд чиглүүлдгээрээ хүний эрхэд суурилсан хандлага давуутай юм. Мөн энэхүү хандлага, арга зүй нь хоёр талт болон олон талт хөгжлийн байгууллагууд, төр, иргэний нийгмийн байгууллага болон ТББ-ыг хөгжлийн үйл явцад оролцож, хувь нэмрээ оруулах боломжийг олгодог. Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүй нь хүнийг эрх-агуулагч болохыг, үүрэг хүлээгчдийн үүрэг хариуцлагыг тогтоох нь зүйтэй болохыг чухалчлан үздэг. Хүний эрхэд дэвшилттэйгээр хүрэхийг зорихын зэрэгцээ аливаа бодлого, хөтөлбөрийн гадна үлдсэн, эрх мэдэл багатай, ялгаварлагдсан бүлгийг онцгойлон анхаардаг бөгөөд хөгжлийн үйл явц, үр дүнд адил ач холбогдол өгдөг онцлогтой юм. Хөгжлөөс үүдэн гарсан шударга бус байдлыг тодорхойлж, ялгаварлан гадуурхсан болон эрх мэдлийн тэнцвэргүй хуваарилалтыг залруулахыг эрмэлздэг.

Хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг хангахаас илүүтэйгээр хүний эрхийг хангахад хүний эрхэд суурилсан хандлага арга зүй чиглэж байна. Хэрэгцээ нь хүнийг сэтгэл дундуур байдалд хүргэхийг хүсдэггүй бол эрх нь хүчирхийллийг хүлээн зөвшөөрдөггүй ба тэрхүү эрхийн зөрчлийг хууль ёсоор сэргээхийг шаарддагаараа онцлогтой. Хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгох нь эрх оршин байдаг гэдгийг зөвшөөрснөөрөө хэрэгцээнд суурилсан хандлагаас ялгардаг. Энэ нь төр болон үүрэг хүлээгчдийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах чадавхийг баталгаажуулдаг байна.

Эрх, хэрэгцээ хоёрын ялгаа

Эрх нь хэрэгцээнээс ялгаатай. Хэрэгцээ бол санаачлага бөгөөд хууль ёсны байж болох ч төрийн үүрэгтэй холбогдох, баталгаажих шаардлагагүй байдаг бол эрх нь төрийн үүрэгтэй холбогдож, баталгааждаг. Эрх нь “орших”, хэрэгцээ нь “байх”-тай холбогддог байна.

Сургагч багшид өгөх зөвлөгөө

Оролцогчдод эрхэд суурилсан хандлагын талаар товч танилцуулж, эрх ба ялгааны талаар ярилцан, хүснэгтэн дээр саналыг нь тэмдэглэнэ.

Эрх	Хэрэгцээ
Эрх нь биелдэг	Хэрэгцээгээ хангадаг
Эрх нь ямагт үүрэг, хариуцлагатай холбоотой	Хэрэгцээ нь үүрэг, хариуцлагад хамаардаггүй
Эрх бол түгээмэл	Хэрэгцээ түгээмэл байх шаардлагагүй
Эрх нь үр дүн, үйл явцад зэрэг анхаарсан цагт биеллээ олдог	Үндсэн хэрэгцээг зорилгоор, эсвэл үр дүнд чиглэсэн стратегиар хангаж болно
Бүх эрх нь нэгэн адил чухал	Хэрэгцээг шатлан захирсан байдлаар ангилж болно
Эрх нь хувь хүмүүс, бүлэг этгээдийг эрх мэдэлжүүлдэг	Хэрэгцээ нь нийгмийн халамжийн хөндлөнгийн оролцооны хувь хүмүүс болон бүлэг этгээдэд хамаарна

Тухайлбал: Эдийн засаг нийгэм соёлын эрх нь хүний сайн сайхан амьдралын зайлшгүй хэрэгцээтэй, төрөөс идэвхтэй хангаж хамгаалах ёстой эрүүл чийрэг байх, чөлөөтэй хөдөлмөрлөж, сурч боловсрох, төрийн халамж хүртэх зэрэг эрхүүдийг багтаахаас гадна түүнийг хэрэгжүүлэхийн төлөө Засгийн газар нь олон улсын өмнө хариуцлага хүлээж хэрэгжүүлдэг билээ.

Жишээ нь: Сурч боловсрох эрх

Боловсрол эзэмших асуудал бол өөрөө хүний эрх бөгөөд бусад хүний эрхийг хангах үндэс болдог.

Хүний эрхийг хүчирхэгжүүлэх явцад боловсрол гэдэг нь эдийн засаг, нийгмийн хувьд орхигдон, гадуурхагдаж байгаа насанд хүрэгчид болон хүүхдүүдийг ядуурлаас өөрсдийгөө татан гаргаж, амьдарч буй орон нутгийнхаа идэвхтэй нэгэн хэсэг болох анхны хэрэгсэл болж өгдөг юм.

Боловсрол нь эмэгтэйчүүдийг чадваржуулах, хүүхдүүдийг аюултай хөдөлмөр, бэлгийн хүчирхийллээс хамгаалах, хүний эрх, ардчиллыг дээшлүүлэх, хүрээлэн буй орчноо хамгаалах хүн амын хэт өсөлтийг хянах асуудлуудад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Иймээс төрийн зүгээс хийж байгаа эдийн засгийн хөрөнгө оруулалтаас хамгийн оновчтой нь боловсрол болох нь тодорхой болсон байна. Ер нь боловсрол гэдэг бол зөвхөн практикийн хувьд ач холбогдолтой төдийгүй сайн боловсрол эзэмшин саруул ухаанаар эрч хүчтэй, өргөн цар хүрээтэй чөлөөтэй сэтгэж чадна гэдэг нь хүн болж төрсний баяр баясал юм.

Сурч боловсрох эрх нь дотроо хэд хэдэн үндсэн шинжийг агуулдаг онцлогтой. Үүнд:

1. **Боломжтой байх**- Төр засгийн зүгээс батлан гаргаж буй хөтөлбөрүүд нь тухайн орны хууль эрх зүйн хүрээнд боловсрол олгогч байгууллагуудаар дамжин иргэдэд хангалттай хэмжээгээр үйл ажиллагаа нь хүрч байх явдал юм.

Жишээ нь. Сурч боловсрох орчныг бүрдүүлсэн байртай, ундны цэвэр устай, эрэгтэй, эмэгтэй ариун цэврийн өрөөтэй, дотооддоо өрсөлдөхүйц хэмжээний цалин бүхий боловсролтой багш нартай, сургалтын бусад шаардлагатай материалуудаар хангагдсан байх шаардлагатай.

2. **Хүртээмжтэй байх**- Боловсрол олгох явдал нь ямар нэгэн ялгаварлан үзэх үзэлгүйгээр тухайн улс орны бүх хүнд хүртээмжтэй байх хэрэгтэй.

Хүртээмжтэй байх гэдэгт 3 үндсэн агуулга багтдаг.

- Ялгаварлан гадуурхах байдал гаргахгүй байх- боловсрол нь хуулийн хүрээнд ч бодит амьдралд ч бүх хүмүүсийн хувьд нээлттэй байх хэрэгтэй,
- Биечлэн хүрч очиж чадахуйц газар байх. Газар байршлын хувьд аливаа нэгэн боловсрол түгээгч байгууллага нь хүмүүс хүрч очиж болохуйц байх, зайны сургалтанд хамрагдах боломжтой байх,
- Эдийн засгийн хувьд боломжтой байх- Боловсрол нь бүх хүмүүс төлж чадахуйц хэмжээний төлбөртэй байна. Бага боловсрол нь бүх хүмүүст үнэ төлбөргүй хүрэх шаардлагатай байдаг бол дунд дээд боловсролыг үнэ төлбөргүй байлгах талаар тодорхой алхамууд хийх ёстой.

3. **Хүлээж авахуйц байх**- Боловсролын бүтэц мөн чанар түүний дотор сургалтын хөтөлбөр, заах арга зэрэг нь чанарын хувьд ч тухайн улс орны ёс заншлын хүрээнд ч гэсэн нэгэн зэрэг оюутан суралцагч тэдний эцэг эхчүүдэд хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд байх

хэрэгтэй. Эдгээр боловсролын хүрээнд тавигдах минимум стандарт нь тухайн орны төр засгийн байгууллагаар батлагдсан байх шаардлагатай.

4. Амьдралд тохирохуйц байх- Боловсрол нь уян хатан байх ёстой. Яагаад гэвэл суралцагчид сурсан мэдсэнээ өөрсдийн амьдарч буй нийгэм орон нутгийг өөрчлөхөд хэрэглэж болохоор мөн нийгэм соёлын хувьд харилцан адилгүй хүрээнээс гаралтай оюутнуудын хэрэгцээг хангаж тэдний амьдралд тохирохуйц байх шаардлагатай.
 - Сурч боловсрох эрх нь төрөөс тодорхой бодлого, хөрөнгө зарцуулж байнга ахиц гаргаж байх ёстой эрхийн сонгодог жишээ юм. Сурч боловсрох эрхийн хүрээнд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дараах асуудлуудыг багтаадаг.
 - Бага боловсролыг хүн бүрт үнэ төлбөргүй, заавал эзэмшүүлэх,
 - Хүн бүрийн хувьд дунд боловсрол хүртээмжтэй, эзэмжих боломжтой байх дунд боловсролыг аажмаар үнэ төлбөргүй болгох эсвэл шаардлагатай тоиолдолд суралцагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх,
 - Хүн бүр өөрийн чадварт тохирсон дээд түвшний боловсрол эзэмших боломжтой байх аажмаар үнэ төлбөргүй болгох асуудал мөн хамаарна,
 - Анхан шатны боловсрол бүрэн эзэмшиж чадаагүй хүмүүст зориулж суурь боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх,
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан боловсролын тусгай хөтөлбөрийг бий болгох,
 - Бичиг үсэггүй, боловсролгүй байдлыг халах,
 - Төрөөс тогтоосон хэм хэмжээнд тохирсон боловсролын хувийн байгууллага, тийм байгууллагад боловсрол эзэмших байгууллагыг сонгох,
 - Эцэг эх нь өөрийн шашин, ёс суртахуун, гүн ухааны үзэл итгэл үнэмшлийн дагуу үр хүүхдийнхээ боловсрол эзэмших байгууллагыг сонгох,
 - Эрдэм шинжилгээний ажил эрхлэх эрх чөлөөг боогдуулахгүй байх,
 - Суралцагчидтай хүнлэг бус, харгис, хэрцгий байдлаар хандахгүй байх, бие махбодын гэсгээл үзүүлэхгүй байх.

Дасгал

Эрхэд суурилсан хандлагын жишээ - ядуурал

20 минут


Багаар ажиллах

1. Ядууралд нөлөөлж буй хүчин зүйлсийг санаагаа уралдуулан гаргаж ирэхийг оролцогчдоос хүснэ. (5 мин)
2. Тухайн асуудлуудаас хүний тоогоор нэг асуудлыг оролцогч бүрт хариуцуулан өгнө.
3. Үүний дараа хүн бүрийг дангаараа дараах асуултад хариулахыг хүснэ. Үүнд:
 - Тухайн хүчин зүйлийг өөрчлөхийн тулд ямар арга хэмжээнд эрхэд суурилсан хандлагыг ашиглаж болох вэ?
 - Эрхэд суурилсан хандлагыг үр ашиг, тулгарах бэрхшээл юу вэ?
 - Эдгээр асуудлыг арилгахад чиглэсэн, үйл ажиллагаагаар нотлогдсон стратеги байна уу?

- Хүний эрхийн үнэт зүйлс, зарчмуудад нийцүүлэн нийгмийн өөрчлөлтийг хүний эрхийн боловсролын үүрэг гэж байх уу? (25 мин)

Эрх эдлэгч ба үүрэг хүлээгч

Хүний эрхэд суурилсан хандлагад эрх эдлэгч, үүрэг хүлээгч гэсэн үндсэн хоёр оролцогч байна. Үүрэг хүлээгч нь өөрийн үүргийг биелүүлэх болон эрх эдлэгч нь өөрийн эрхийг шаардах чадавхийг хөгжүүлэхэд чиглэдэг.




Эрх эдлэгч нь:


- Эрхээ эдэлнэ
- Эрх эдлэгчдийг тэгш оролцуулна
- Эрхээ шаардах чадавхийг нэмэгдүүлэх замаар эрх мэдэлжүүлнэ.

Үүрэг хүлээгч нь:

- Хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүргээ биелүүлнэ
- Үүрэг хүлээгчийн хариуцлагыг шаардана.

Эрх эдлэгч үүрэг хүлээгч хоёулаа бусад хүмүүсийн эрхийг хүндэтгэх үүрэгтэй.





Хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйг бусад дэвшилтэт үзэл санаа, зарчимтай хослуулан хэрэглэж чадваас хөгжлийн гол цөмд хүнийг байлгаж, хөгжлийн жинхэнэ эзэн нь цөөн тооны элит удирдагчид биш ард түмэн байх боломжтой юм.

Хүний эрх ба хөгжил: сорилтууд

Энэ бүгдээс харахад хүний эрх болон хөгжил хоёр нь хоорондоо олон талт харилцан хамааралтай, харилцан бие биенээ нөхцөлдүүлэгч ойлголтууд болох нь тодорхой байна. Гэвч хөгжлийн явцад хүний эрхийн асуудлуудыг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх нь мөн олон тооны эргэлзээ, санал шүүмжлэлийг дагуулж байна.

Юуны өмнө төрийн өнөөгийн улс орнуудын эрх баригч хүчин, дарангуйлагчид хүртэл бүгд өөрсдийгөө хүний эрхийг хүндлэн дээдэлдэг хэмээн зарлаж, тайлан, баримт гаргадаг. Ийм учраас өнөө цагт “Хүний эрх”-ийн үзэл санаа нь ойлголтын хувьд “үнэгүйдэх, ханш буурах” үзэгдэл гарч байна гэсэн шүүмжлэл (Гранстон, 1973), (Оренд 2002), (Веллман, 1999), (Гриффин, 2001) судлаачдын зүгээс өрнөх болжээ.

Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр олон улсын түвшинд эрхэм чухал амлалт бүхий идеал байдал бүрэлдэн тогтож байна. Тэрхүү амлалт, санаачлагуудыг өөрийн эх орны бодит хөрс шороон дээр буулган хэрэгжүүлэх үйл ажиллагааны дутагдал нь олон түмнийг итгэл алдарсан байдалд хүргээд байна. Үүний хамт бүхий л улс төрчид, дипломатчид олон улсын хурал зөвлөлгөөн дээр хүний эрхийн төлөө гэсэн уриа лоозон танилцуулж, хамтран ажиллахаа илэрхийлдэг ч хүний эрхийн үзэл санаа нь бодит байдал дээр бус харин цаасан дээр үлдэж гэсэн шүүмжлэл дагалддаг. Иргэд, хүмүүсийн хувьд төр засаг, улс төрийн нам, улс төрчдөөс амлалт, баталгаа, уран илтгэх чадвар зэргээс илүүтэйгээр идэвхитэй үйл ажиллагаа, тодорхой үр дүн, баримтуудыг шаардаж, хүлээж байгаа нь илэрхий болоод байна.

Хөгжлийн явц дахь хүний эрхийн хамгийн том сорилт бол ядуурал, тэгш бус байдал юм. Даяаршсан хөгжлийн үйл явц нь өөрийн сөрөг үр дагаврыг төрүүлж, баян, ядуугийн ялгаа туйлын их зөрүүтэй болжээ. Үндэстэн дамнасан корпорациуд олшрон хүчирхэгжихийн хамт дэлхий дахинд өлсгөлөн, ядуурал хурдацтай нэмэгдэж байна. Энэ тухай маш олон тооны судалгаа, дүгнэлт тайлан байдаг ч өөрчлөгдөж буй байдал, итгэл найдвар бага хэвээр байгаа билээ. Судлаач Амартаяа Сенийн хэлснээр: “Ядуурал нь ядуу хүмүүсийн амьжиргаа хомсдолтой, аюултай байдалд байх зэрэг нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх чадавхийг доройтуулдаг. Тиймээс ядуурал бол хүний эрхийн зөрчлийн шалтгаан бөгөөд үр дагавар мөн. Хоол хүнсээр хангагдах, эрүүл байх

зэрэг эрх нь шударга зарчим дээр бус харин эдийн засгийн өсөлтийг баримжаалсан хөгжлийн бодлогын улмаас зөрчигдөж байна” хэмээн дүгнэсэн байдаг.

Мөн “хүний суурь хэрэгцээ” үзэл баримтлалын төлөөлөгч болох Петр Увин өөрийн гол үндэслэлээ “Бүх хүн хоол хүнс, хувцас, орон байр зэрэг суурь материаллаг хэрэгцээтэй, тиймээс бүхий л хөгжлийн бодлого, үйл ажиллагаа нь эдгээр суурь хэрэгцээг хангах, дэмжлэг үзүүлэхэд чиглэх хэрэгтэй бөгөөд зөвхөн энэхүү шаардлагын дараа л бусад нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээг хангахад анхаарах ёстой” хэмээн тодорхойлжээ⁸. Үнэхээр хүний эрхийг хангах, хамгаалах нь дан ганц сайхан амлалт, хүсэл зоригоор биелэгддэг зүйл биш билээ. Энэ нь тодорхой хөгжлийн бодлого, хүний ба санхүүгийн нөөц, оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргээс шалтгаална.

Хүний эрх болон хөгжлийн асуудлаар гарж буй дараагийн шүүмжлэл бол хүний эрх ба хөгжлийг хэмжин тодорхойлох оролдлогууд юм. Хөгжлийг ихэвчлэн орлого, бүтээмж, өсөлт зэрэг тоон хэмжигдэхүүнээр хэмжихийг оролддог нь хүний эрх болон бодит үр дүнгийн хамаарлыг гарган тавьж чадахгүй байна гэж шүүмжилдэг. Энэ ч үнэхээр үнэний хувьтай билээ. Олон жилийн турш хүний эрх ба хөгжлийн асуудлыг хоёр тусдаа үзэл баримтлал хэмээн үзэж тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулахад анхаарч байсангүй. Тухайлбал, хөгжил нь эдийн засгийн ойлголт, харин хүний эрх нь эрх зүйн болон ёс зүйн ойлголт хэмээн үзэж байсан билээ. Тиймээс ч хөгжлийн томоохон байгууллагууд болох Дэлхийн банк хөгжлийн асуудлаар дагнаж, НҮБ Хөгжлийн хөтөлбөр хүний эрхийн асуудлыг онцгойлж байв. Харин НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн манлайллын дор боловсруулагдсан “Хүний хөгжил” гэх ойлголт нь хөгжлийг зөвхөн үндэсний нийт бүтээгдэхүүнээр хэмжин тодорхойлж байсан практикийг өөрчилж, хүүхдийн эндэгдэлгүй байх, бичиг үсэгт тайлагдалтын хувь, дундаж наслалт зэрэг үзүүлэлтүүдээр зэрэгцүүлэн гаргах болсноор амьдралын чанарт өөрчлөлт гаргасан юм.

Хөгжлийн байгууллагууд ч хөгжлийн гол сорилт болох ядуурал нь зөвхөн орлого багатай байх явдал бус харин үүний цаана ялгаварлан гадуурхагдалт, эрх мэдэл, боломжийн дутмагшил, эмзэг байдал зэрэг хүний эрхийн зөрчлүүд нөлөөлж байгааг хүлээн зөвшөөржээ.

ДАСГАЛ. НИЙГМИЙГ ӨӨРЧЛӨХДӨӨ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДЛЫГ АНХААРАХ НЬ

Хүний эрхэд суурилсан хандлага дараах үндсэн шинжийг агуулна.

• Хүний эрхийн зарчим, олон улсын гэрээг удирдлага болгох

Аливаа үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхдээ хүний эрхийн зарчим, олон улсын гэрээг удирдлага болгох нь чухал байдаг. Тухайлбал, хүүхдийн эрхийн тухай конвенцийн 7 дугаар зүйлд баталгаажуулсан хүүхдийг төрсний дараа бүртгүүлэх эрх нь хүүхэд бусад эрхээ эдлэхэд чухал болохыг харгалзан зарим бүс нутагт НҮБ-ын хүүхдийн сангийн хөтөлбөр боловсруулахад ач холбогдолтой хэсэг болдог.

• Ялгаварлан гадуурхахгүй байх (хамгийн эмзэг бүлэгт анхаарал хандуулах)

Эрхэд суурилсан хандлага нь нийгэмд өнөөдөр хэн ялгаварлан гадуурхагдаж байна вэ? Хэн анхаарлын гадна орхигдож байна вэ? Гэдэг асуултад хариулахыг шаарддаг. Энэхүү бүлэгт эмэгтэйчүүд, хүүхдүүд, уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс орж болно. Энэ хүрээнд үндэсний хэмжээний бодлогыг хотын хүмүүс л тодорхойлох, ядуурлыг бууруулах хөтөлбөрийг ядуу хүмүүсийн төлөөлөлгүй боловсруулах зэрэг гажуудлыг дурьдаж болно.

• Оролцоог хангах, тэгш хамруулах

Оролцоог бүрэн хангахын тулд НҮБ-ын Хөгжих эрхийн тухай *Тунхаглалд заасан “идэвхтэй,*

⁸ Des Gasper, Human Rights, Human Needs, Human Development, Human Security: Relationships between Four International ‘Human’ Discourses; GARNET Working Paper: No 20/07, p 17.

чөлөөтэй, үр бүтээлч оролцооны” шаардлагад нийцсэн байх ёстой. Тухайлбал, хөдөө орон нутагт амьдарч буй эмэгтэйчүүд бүх түвшний хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй (Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 14-р зүйл), төрийн хэргийг явуулахад оролцох эрх (ИУТЭОУП-ын 25-р зүйл)-ийг баталгаажуулсан байдаг.

• **Хараат байдлаас эрх мэдэлжүүлэх буюу чадавхижуулах**

Эрх эдлэгчийн эрхээ эдлэх боломж, эрхээ шаардах чадавхийг нэмэгдүүлэх, эрхээ хамгаалахад дэмжлэг үзүүлдэг. Мөн халамжийн үйлчилгээ үзүүлэхээс илүүтэйгээр мэдлэг мэдээллээр хангах, боловсролыг бүх нийтэд түгээхэд анхаардаг байна.

• **Хариуцлагатай байх**

Эрх эдлэгчийн эдлэх эрх үүрэг, үүрэг хүлээгчийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгосноор талуудыг хариуцлагатай байхыг шаардана. Өөрөөр хэлбэл үүрэг хүлээгчийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг болон хүний зөрчигдсөн эрхийг сэргээх үүргийг тодорхойлдог байна.

Монгол улс нийгэм, эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн шат эхлэж байгаа өнөө үед бид дээрх хүний эрхийн үндсэн зарчмуудыг аливаа хөгжлийн төсөл хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлж чадсанаар мэдлэгийн менежментэд тулгуурлан хөгжлийн бодлогыг зөв боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

Дасгал (5 багт хуваагдан, баг бүр нэг үндсэн шинжийг сонгон авч тодорхой хугацаанд бэлтгэн бусад байгууддаа тайлбарлах)

Хүний эрхийн олон улсын гэрээ	<ul style="list-style-type: none">• Хүний ямар эрхүүдийг хамруулдаг вэ?• Ямар хүний эрхийн стандарт, механизм, олон улсын гэрээ, конвенц байдаг вэ? (Олон улсын, бүсийн, үндэсний түвшинд)
Оролцоо	<ul style="list-style-type: none">• Хэн оролцож болох вэ, хэрхэн оролцох вэ?• Шийдвэр гаргахад оролцох эсэх?
Хариуцлага	<ul style="list-style-type: none">• Хэн хариуцлага хүлээх вэ, хэний өмнө хариуцлага хүлээх вэ?• Эрх эдлэгч, үүрэг хүлээгч гэж хэн бэ?
Ялгаварлан гадуурхахгүй байх	<ul style="list-style-type: none">• Хэнийг эмзэг бүлэг гэх вэ?, хэнийг ялгаварлан гадуурхах вэ? Үүнд хэн хамаарах вэ?• Тэд хэрхэн, яаж хамрагдах вэ?
Эрх мэдэлжүүлэх	<ul style="list-style-type: none">• Хэн эрх мэдэлжсэн байх вэ?• Хэрхэн эрх мэдэлжүүлэх вэ?

СЭДЭВ 9.

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛАН ХӨГЖИХ ХАНДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

НҮБ-ын Нийтлэг ойлголцлын Мэдэгдэл нь эрхэд суурилан хамтран хөгжих болон хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах зорилготой баримт бичиг хэмээн ойлгогддог. Энэ нь хөгжлийн хамтын ажиллагаа, бодлого, техникийн туслалцаа зэргийг хүний эрхийг хангахад чиглүүлэх бөгөөд хүний эрхийн зарчим, стандартууд нь хөтөлбөрийн үйл явцын бүх үе шатанд чиглүүлэгч болдог. Дараах зүйлүүд нь хүний эрхэд суурилсан хандлагын зайлшгүй, үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд бөгөөд боловсролын салбар дахь бодлого, хөтөлбөрийн төлөвлөлтөнд хэрэглэгддэг.

- Үнэлгээ, шинжилгээ – Боловсрол дахь хүний эрхийн асуудлыг тодорхойлж, тэдгээр эрхийг хангаагүйгээс болж үүсэх үр дагаврыг тооцон, төрийн хүлээх үүргийг нарийвчлан гаргана.
- Хөтөлбөрүүд хүмүүс эрхээ эдэлж байгаа болон төр үүргээ хэрхэн биелүүлж буй чадавхийг үнэлдэг. Мөн тэдгээр талуудын чадавхийг бэхжүүлэх стратегиудыг боловсруулдаг.
- Хөтөлбөрүүд нь хүний эрхийн зарчим, стандартаар баримжаалсан үйл ажиллагаа, түүний үр дүнг үнэлдэг.
- Хөтөлбөр боловсруулах нь олон улсын хүний эрхийн тогтолцоо, байгууллагаас гаргасан зөвлөмжүүд дээр суурилдаг. Нэмж хэлэхэд, сайн хэмээн үнэлэгдсэн хөтөлбөрийн олонх бүрэлдэхүүн хэсгүүд нь эрхэд суурилах хандлагын хүрээнд боловсруулагдсан байдаг. Үүний тулд доорх алхмуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:
- Нөхцөл байдлын шинжилгээ хийх
- Хэрэгжүүлэх чадавхийг үнэлэх
- Хөтөлбөрийн төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжүүлэлт
- Хяналт ба үнэлгээ

Хүний эрхэд суурилсан хандлагаар сайн хөтөлбөрийг хэрхэн чанаржуулах вэ?

- “Сайн хөтөлбөр” гэдэг нь хөтөлбөрөө бусад хүмүүсээр биш харин өөрсдөө боловсруулах ёстой юм. Хүүхэд, өсвөр үеийнхэн болон ядуусыг оролцуулан бүх суралцагчид нь эд бараа хүлээн авагч, үйлчилгээний үр шимийг хүртэгчид бус харин өөрсдийн боловсрол, хөгжлийн үйл ажиллагааны гол оролцогчид хэмээн үзэх нь чухал.

Боловсрол дахь эрхэд суурилсан хандлагын хувьд хүүхэд хийгээд ядуусыг оролцуулан бүх суралцагчид нь сурч боловсрох эрхийг эдлэгч, нөгөө талаас үүрэг хүлээгч гэсэн үйлийн субъект байна. Эрхэд суурилсан боловсрол нь хүүхэд, өсвөр үеийнхэн, тэдний эцэг эх болон бусад суралцагчдын эрхээ эдлэх чадавхийг дээшлүүлэхэд анхаардаг. Хүний эрхийн боловсрол гэдэг нь хүмүүс эрхээ ойлгох, эдлэх, хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэрэгсэл юм.

- Сайн хөтөлбөрийн хувьд оролцоо нь үр дүн болон утга агуулгын хувьд хамгийн чухал зүйл юм. Оролцоо гэдэг нь “тэд” “өөрсдийнхөө” боловсролын хөтөлбөрт хамрагдах төдий биш харин суралцахуйн хэрэгцээгээ тодорхойлохоос эхлэн бүх үйл ажиллагаанд оролцоно гэсэн үг.

Олон тооны гэрээ конвенциудад эмэгтэйчүүд, хүүхдийн оролцоог хангах нь хүний эрх хэмээн заасан байдаг. Боловсрол дахь эрхэд суурилсан хандлагын хувьд оролцоо нь зайлшгүй үйл явц ба үр дүн байна.

- Сайн хөтөлбөрт гэгээрэл нэн чухал бөгөөд энэ нь зөвхөн стратеги биш юм. Гэгээрэл нь магадгүй нөлөөлөх, чадавхийг бэхжүүлэх болон үйлчилгээ хүргэх зэрэг стратегийн үзэл баримтлал байж болно.

Эрхэд суурилсан боловсрол нь гэгээрлийг үйл ажиллагааны зайлшгүй стратеги,

мөн зорилго хэмээн үзнэ. Ач холбогдол өгөх гэдэг нь албан ба албан бус зүй ёсны тогтолцоогоор аливаа гомдол саналыг шийдвэрлэх, бололцоог нэмэгдүүлэх гарцыг олох явдал юм.

- Сайн хөтөлбөрт үйл явц болон үр дүнд хяналт тавих, боловсролын бүх шатанд шийдвэр гаргахдаа уг мэдээллийг ашиглах нь нэн чухал юм. Эрхэд суурилсан хандлага нь сурч боловсрох эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүргээ илүү хариуцлагатай биелүүлэхийг шаарддаг.
- Сайн хөтөлбөрт оролцогчдын дүн шинжилгээ нь тухайн хамт олон, нийгэм дэх хариуцлагыг илүү тодорхой болгох тул боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулах болон үнэлгээ хийхэд ихээхэн чухал юм.

Боловсрол дахь олонх оролцогчид нь үүрэг хүлээгчид байдаг. Эрхэд суурилсан хандлагын хувьд эрх эдлэгч ба үүрэг хүлээгчдийн хоорондын харилцааг тодорхойлох нь хамгийн чухал алхам байдаг. Оролцогчийн дүн шинжилгээг илүү нарийн хийх шаардлагатай байдаг. Эрх ба үүргийн харилцаа нь хүний эрхийн гэрээ, баримт бичгүүдээр хүлээсэн үүрэг хариуцлагыг илүү тодорхой, өөрөөр хэлбэл, зөвхөн амлалт бус харин сайн сайхан үйлс болгоно. Хөгжлийн туслалцааны үйл ажиллагаа нь ч мөн олон улсын үүрэг хариуцлагын үр дүн байх ёстой.

- Сайн хөтөлбөрийн хувьд, ялангуяа боловсролын хөтөлбөрүүд нь хүүхэд болон эмзэг бүлгийн бусад хүмүүсийн суурь хэрэгцээг хангахад чиглэх ёстой. Тухайн оролцогчдын өөрсдийн идэвхи чармайлт болон гаднаас өгөх хөгжлийн дэмжлэг нь одоогийн байгаа чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэх ёстой. Ядуурлыг арилгах, ялгаатай байдлыг бууруулах нь бүх боловсролын хөгжлийн удаан хугацааны зорилтууд байх ёстой.

Боловсролын хөтөлбөрүүд нь хэрэгцээг хангахын хамт хүүхэд, өсвөр үе болон бусад суралцагчдын эрхийг хангах талаар үүрэг хүлээнэ. Боловсролын харилцаанд оролцогчид нь боловсролын хөтөлбөрүүдийг бидэнд буй хувилбарууд хэмээн үзэхээс илүү “эрх” хэмээн үзэх шаардлагатай. Сурч боловсрох эрх гэдэг нь ялгаатай байдал болон ядуурлыг бууруулах гэсэн үг. Иймд боловсролын хөтөлбөрүүд нь төлөвлөж буй үйл ажиллагааг ялгаатай байдал, ядуурал, зүй бус үзэгдлүүдийг арилгахад уялдуулан холбож өгөх хэрэгтэй юм. Энэ нь бүтцийн болон хууль эрх зүйн шинэчлэлтийг агуулж болно. Хүний эрхийн хэм хэмжээ нь өөрчлөлтөд хүргэх нөлөөлөл болон арга хэрэгслээр хангадаг.

- Сайн хөтөлбөрийн хувьд, боловсролын хөтөлбөрүүд нь нэн тэргүүний асуудлууд, тэдгээрийн зэрэгцүүлэн болон хэсэгчлэн хийх, хойшлуулшгүй байх үндсэн шалтгаануудыг тодорхойлсон нөхцөл байдлын шинжилгээний үндсэн дээр боловсруулагдах ёстой.

Боловсрол дахь эрхэд суурилсан хандлага нь ядуурал болон тэгш бус байдлыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийг даван туулахад чиглэнэ. Хүний эрх хуваагдашгүй байх зарчмын дагуу дээрх шалтгаануудад бүх түвшинд нэгэн зэрэг анхаарах шаардлагатай байдаг.

- Сайн хөтөлбөрийн хувьд, зорилтуудыг тодорхойлох нь нэн чухал бөгөөд ялангуяа төлөвлөлтийн үе шатанд тэдгээрийг чухалчлагдах шинжээр нь ангилах нь зүйтэй. Эдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хичээл зүтгэл нь эерэг өөрчлөлтүүдийг бий болгох, улмаар тогтвортой хадгалахад эрмэлзэх ёстой. Үүнд мөн байгаль орчны тогтвортой байдлыг хамруулан ойлгоно.

Эрхэд суурилсан боловсрол олгох нь эерэг үр дүнд хүргэх болон хүний эрхийн үнэт зүйлс бүхий үйл явцаар дамжуулан хэрэгжүүлэхийг шаарддаг. Өөрөөр хэлбэл, боловсрол дахь эрхэд суурилсан хандлага нь үйл явц ба үр дүнд нэгэн зэрэг анхаарал тавьдаг. Өөр нэгэн зарчмын ялгаа бол үйлчилгээ хүргэхээс илүү чадавхийг бэхжүүлэх, нөлөөлөл хийхэд эрмэлзэх явдал юм.

Эх сурвалж: Жонсон, Урбан, Хөгжлийн хөтөлбөр дэх хүний эрхийн хандлага НҮБ, Хүүхдийн сан, Нью-Йорк, 2003, х 39-41

Нөхцөл байдлын үнэлгээ ба анализ

Нөхцөл байдлын анализ дахь хөгжлийн хандлага нь үндсэн шалтгаан, эрсдэл, эрх мэдэл, оролцогчид болон жендерийн асуудалд анхаардаг бол хөтөлбөр төлөвлөлтийн эрхэд суурилах хандлага нь боловсролын салбарт холбогдох бүхий л хүний эрхийн баримт бичгүүд, гэрээний байгууллагуудын Ерөнхий зөвлөмжүүд, тэдгээрийн дүгнэлтүүдэд үндэслэгддэг. Үүнд доорх бүрэлдэхүүн хэсгүүд хамаарна.⁹

- *Бодлого, эрхзүй, практикийн орчны шинжилгээ:*

Эрх зүйн зохицуулалт байх нь хангалттай нөхцөл биш. Олонх тохиолдолд хэдийгээр эрх зүйн зохицуулалт байдаг боловч хэрэгждэггүй. Бодлогыг хэрэгжүүлэх чадавхи сул, нөөц хангалттай бус, олон нийтийн шаардлага, мэдээлэл, гэгээрэл сургалтын ажил бага бол үр дүнгүй байдаг бөгөөд ийм тохиолдолд хүний эрхийг хүндэтгэх орчин бүрдэхгүй.

- *Төрийн хүлээх үүрэг хариуцлагыг чухалчлах:*

Боловсролын хувьд төр нь сургуулиудыг байгуулах, багш нарыг бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулах, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, алагчлалыг арилгах, бүх хүнд боловсрол хүртээмжтэй байх бололцоог хангах зэрэг гол үүргийг хүлээдэг. Мөн орон нутгийн удирдлага, сургууль, эцэг эх, нийгмийн гишүүд зэрэг бусад оролцогчид ч үүрэг хүлээдэг. Гэхдээ зарим тохиолдолд тэд үүргээ биелүүлэх чадавхи нь төрөөс дээр дурдсан үндсэн үүргээ хэрхэн биелүүлснээс хамаардаг.

- *Хүүхдийн эрхийн тухай конвенцийн дөрвөн үндсэн зарчимд нийцүүлэх:*

Хүүхэд амьдрах, хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, алагчлалаас ангид байх, хөгжих эрх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх зэрэг нь уг дүн шинжилгээний явцад анхаарах ёстой асуудал байна.

- *Хүний эрхийн зөрчилд хийх шинжилгээ:*

Дүн шинжилгээний хүрээнд хүний эрхийн зөрчлийн гол болон нийтлэг хүчин зүйлс, шалтгаан нөхцлийг шинжлэн үзэж, улмаар боловсрол хүртээмжтэй байх, боловсролын чанар, боловсролын харилцаанд хүүхдийн эрхийг хүндэтгэх байдалд чиглүүлнэ.

- *Ядуу болон эмзэг бүлгийнхнийг чухалчлан үзэх:*

Эдгээр бүлгийнхний хувьд олонх тохиолдолд сурч боловсроогүй байх бөгөөд эрх нь зөрчигдөх, хөндөгдөх ихээхэн эрсдэлд байдаг.

- *Оролцооны хандлага:*

Эцэг эх, багш нар, шашны тэргүүнүүд, нийгмийн гишүүд, хүүхдүүдийг уг дүн шинжилгээнд оролцуулах нь тэдгээрт уг асуудлыг дахин анхаарах бололцоог олгодог. Хүүхдүүдийн үзэл бодол, байр суурь ч нэн чухал байдаг. Янз бүрийн насны, сургуульд суралцдаг хийгээд сурдаггүй, хөгжлийн бэрхшээлтэй, газарзүйн янз бүрийн бүлэг, орон нутаг, угсаатны бүлгийн гишүүн ч бай бүх охид, хөвгүүдийн дуу хоолойг нэгэн адил авч үзэх ёстой.

- *Нарийвчилсан мэдээлэл*

Бүх бүлгийн хүүхдүүд боловсролд хамрагдах, оролцох, дүүргэх, амжилттай төгсөх бололцоог бүрдүүлэхийн тулд холбогдох мэдээллийн санг хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс, угсаатны ба нийгмийн гарал байдал, эдийн засгийн байр суурь, шашин, хэл, газарзүйн байрлал болон бусад статусаар ялган харуулах нь чухал байдаг.

Хэрэгжүүлэх чадавхийг үнэлэх нь

Боловсролын бодлого, хөтөлбөр дэх эрхэд суурилсан хандлага нь эрх эдлэгчид өөрийн эрхийн төлөө ажиллах болон төр, төрийн албан хаагчийн зүгээс хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхийг үнэлэхэд анхаардаг. Уг үйл явц нь боловсролын эрхэм зорилгыг дэмжихүйц чадавх

⁹ Save the Children, Child Rights Programming: How to apply rights-based approaches to programming, 2nd ed., Save the Children Sweden, Stockholm, 2005, p. 41.

бүрдүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө, үйл ажиллагааг агуулах нь зүйтэй.

Эрх эдлэгчдийн эрхээ шаардах чадвар

Эрхээ эдлэхийн тулд хүний эрх гэж юу болох, хэрвээ хүний эрх хөндөгдсөн тохиолдолд хаана, хэнд, хэрхэн хандах, ямар шийдвэр гаргах талаар хүмүүс мэддэг байх нь чухал юм. Хэрвээ багш хичээлдээ ирэхгүй байх буюу хичээлээ заахгүй бол эцэг эхчүүдийн хувьд хүүхдийнхээ сурч боловсрох эрхийг шаардаж, уг асуудлыг шийдвэрлэхийн тулд хамтран ажиллана. Үүний тулд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд болон шийдвэр гаргагчидтай холбогдох шаардлагатай. Мөн тэдний эрх хэрхэн хангагдахгүйд хүрсэн, ямар арга замаар уг байдлыг өөрчилж болох талаар дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Хүүхдүүд өөрийн эрхийн төлөө тэмцэх чадвар дадал бий болгоход анхаарч тодорхой хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Хүүхдүүд үр дүнтэй нөлөөлөл хийх чадвар эзэмших, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бодлого боловсруулагчид, улс төрчидтэй холбогдох боломжийг нэмэгдүүлэх зорилготой зарим стратеги, арга хэрэгслүүд байдаг (Ном зүйг үзнэ үү, 102 хуудас). Эрх эдлэгчид өөрсдийн эрхээ эдлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилго бүхий мэдээлэл, нөлөөлөл, чадавхийг бэхжүүлэх, эцэг эхийн сүлжээ байгуулах, үе тэнгийнхний дэмжлэг болон туслалцааг авах зэрэг олон тооны стратегийн талаар чадваржуулах шаардлагатай.

Төр, төрийн албан хаагч үүрэг хариуцлагаа биелүүлэх чадвар

Төр, төрийн албан хаагчид сурч боловсрох эрхийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх чадавхийг үнэлэх нь нэн чухал. Үүрэг хариуцлагаа биелүүлэх нь дараах хүчин зүйлээс шалтгаалж болно. Үүнд:

- Нөөцийн хомс байдал – санхүүгийн (татварын болон төсвийн тэргүүлэх чиглэл) буюу хүний (чадвар болон байгууллагын чадавхи) нөөц
- Эрх мэдлийн хомсдол – эрхзүй, ёс суртахуун, оюун санааны болон соёлын
- Хариуцлагын хомсдол – үүргээ биелүүлэхээс татгалзах болон улс төрийн хүсэл зориггүй байх
- Салбар, түвшин хоорондын зохицуулалтын хомсдол
- Ойлголтын хомсдол – жишээ нь, бичиг үсэгт тайлагдаагүй эцэг эх хүүхдээ сургуульд суралцуулах үүргийнхээ талаар мэдэхгүй байж болно.

Уг дүн шинжилгээ нь өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд шаардлагатай стратегиудыг боловсруулж өгнө. Жишээ нь, хүүхдээ сургуульд суралцуулах үүргээ биелүүлэх эцэг эхийн чадавхийг нэмэгдүүлэхийн тулд төрөөс сургуультай холбогдон гарах бодит зардлыг тооцоолж үзэх хэрэгтэй. Бүх нийтэд боловсрол олгох зорилго бүхий бодлого боловсруулахын тулд уг дүн шинжилгээ нь сургалтын төлбөр, дүрэмт хувцас, хичээлийн хэрэгслүүд, тээврийн зардал, эцэг эхийн эдийн засгийн бололцоо, хүүхдийн өөрийнх нь олох мөнгө зэргийг агуулсан байвал зохино. Хямрал, мөргөлдөөний үед дээрх хүчин зүйлсүүд бүр хүчтэй тусаж болно. Гэвч дайны байдалд байсан ч боловсролын хүртээмжийг хадгалах болон сурч боловсрол эрхийг сэргээн эдлүүлэх, чадавхиа дээшлүүлэх боломжтой юм.

Хөтөлбөр төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх нь

Хүний эрхэд суурилсан хандлага нь хөгжлийн үйл явц нь үр дүнгийн адил нэн чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл, хөгжлийн үйл явц нь түүнээс гарах үр дүнд ихээхэн нөлөөлдөг. Эрхэд суурилсан хандлагын дээр дурдсан зарчмуудыг (10 дугаар хуудас) хөтөлбөр төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх үе шатанд авч үзэх нь зүйтэй. Хэдийгээр оролцоо, хариуцлагатай байх зэрэг нь хөгжлийн хувьд цоо шинэ зүйл биш хэдий ч ёс суртахууны болон улс төрийн дэмжлэг

нь эрхэд суурилсан хандлагын нэмж буй шинжүүд юм¹⁰. Эдгээр зарчмуудыг хэрэгжүүлснээр ядуу болон нийгмээс тусгаарлагдсан хүмүүст тодорхой үр дүн гарч байвал нэн чухал юм.

Хүний эрх ба хөгжил: сорилтууд

Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр олон улсын түвшинд эрхэм чухал амлалт бүхий идеал байдал бүрэлдэн тогтож байна. Тэрхүү амлалт, санаачлагуудыг өөрийн эх орны бодит хөрс шороон дээр буулган хэрэгжүүлэх үйл ажиллагааны дутагдал нь олон түмнийг итгэл алдарсан байдалд хүргээд байна. Үүний хамт бүхий л улс төрчид, дипломатчид олон улсын хурал зөвлөлгөөн дээр хүний эрхийн төлөө гэсэн уриа лоозон танилцуулж, хамтран ажиллахаа илэрхийлдэг ч хүний эрхийн үзэл санаа нь бодит байдал дээр бус харин цаасан дээр үлдэж гэсэн шүүмжлэл дагалддаг. Иргэд, хүмүүсийн хувьд төр засаг, улс төрийн нам, улс төрчдөөс амлалт, баталгаа, уран илтгэх чадвар зэргээс илүүтэйгээр идэвхтэй үйл ажиллагаа, тодорхой үр дүн, баримтуудыг шаардаж, хүлээж байгаа нь илэрхий болоод байна.

Хөгжлийн явц дахь хүний эрхийн хамгийн том сорилт бол ядуурал, тэгш бус байдал юм. Даяаршсан хөгжлийн үйл явц нь өөрийн сөрөг үр дагаврыг төрүүлж, баян, ядуугийн ялгаа туйлын их зөрүүтэй болжээ. Үндэстэн дамнасан корпорациуд олшрон хүчирхэгжихийн хамт дэлхий дахинд өлсгөлөн, ядуурал хурдацтай нэмэгдэж байна. Энэ тухай маш олон тооны судалгаа, дүгнэлт тайлан байдаг ч өөрчлөгдөж буй байдал, итгэл найдвар бага хэвээр байгаа билээ. Судлаач Амартаяа Сенейн хэлснээр: “Ядуурал нь ядуу хүмүүсийн амьжиргаа хомсдолтой, аюултай байдалд байх зэрэг нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэх чадавхийг доройтуулдаг. Тиймээс ядуурал бол хүний эрхийн зөрчлийн шалтгаан бөгөөд үр дагавар мөн. Хоол хүнсээр хангагдах, эрүүл байх зэрэг эрх нь шударга зарчим дээр бус харин эдийн засгийн өсөлтийг баримжаалсан хөгжлийн бодлогын улмаас зөрчигдөж байна” хэмээн дүгнэсэн байдаг.

Мөн “хүний суурь хэрэгцээ” үзэл баримтлалын төлөөлөгч болох Петр Увин өөрийн гол үндэслэлээ “Бүх хүн хоол хүнс, хувцас, орон байр зэрэг суурь материаллаг хэрэгцээтэй, тиймээс бүхий л хөгжлийн бодлого, үйл ажиллагаа нь эдгээр суурь хэрэгцээг хангах, дэмжлэг үзүүлэхэд чиглэх хэрэгтэй бөгөөд зөвхөн энэхүү шаардлагын дараа л бусад нийгэм-сэтгэл зүйн хэрэгцээг хангахад анхаарах ёстой” хэмээн тодорхойлжээ¹¹. Үнэхээр хүний эрхийг хангах, хамгаалах нь дан ганц сайхан амлалт, хүсэл зоригоор биелэгддэг зүйл биш билээ. Энэ нь тодорхой хөгжлийн бодлого, хүний ба санхүүгийн нөөц, оролцогч талуудын хамтын ажиллагаа зэргээс шалтгаална.

Хүний эрх болон хөгжлийн асуудлаар гарж буй дараагийн шүүмжлэл бол хүний эрх ба хөгжлийг хэмжин тодорхойлох оролдлогууд юм. Хөгжлийг ихэвчлэн орлого, бүтээмж, өсөлт зэрэг тоон хэмжигдэхүүнээр хэмжихийг оролддог нь хүний эрх болон бодит үр дүнгийн хамаарлыг гарган тавьж чадахгүй байна гэж шүүмжилдэг. Энэ ч үнэхээр үнэний хувьтай билээ. Олон жилийн турш хүний эрх ба хөгжлийн асуудлыг хоёр тусдаа үзэл баримтлал хэмээн үзэж тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулахад анхаарч байсангүй. Тухайлбал, хөгжил нь эдийн засгийн ойлголт, харин хүний эрх нь эрх зүйн болон ёс зүйн ойлголт хэмээн үзэж байсан билээ. Тиймээс ч хөгжлийн томоохон байгууллагууд болох Дэлхийн банк хөгжлийн асуудлаар дагнаж, НҮБ Хөгжлийн хөтөлбөр хүний эрхийн асуудлыг онцгойлж байв. Харин НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн манлайллын дор боловсруулагдсан “Хүний хөгжил” гэх ойлголт нь хөгжлийг зөвхөн үндэсний нийт бүтээгдэхүүнээр хэмжин тодорхойлж байсан практикийг өөрчилж, хүүхдийн эндэгдэлгүй байх, бичиг үсэгт тайлагдалтын хувь, дундаж наслалт зэрэг үзүүлэлтүүдээр зэрэгцүүлэн гаргах болсноор амьдралын чанарт өөрчлөлт гаргасан юм.

¹⁰ Frankovits, Andriy, The Human Rights-based Approach and the United Nations System, United Nations Educational, Scientific and Cultural Organization, Paris, 2006, p. 20.

¹¹ Des Gasper, Human Rights, Human Needs, Human Development, Human Security: Relationships between Four International 'Human' Discourses; GARNET Working Paper: No 20/07, p 17.

Хөгжлийн байгууллагууд ч хөгжлийн гол сорилт болох ядуурал нь зөвхөн орлого багатай байх явдал бус харин үүний цаана ялгаварлан гадуурхагдалт, эрх мэдэл, боломжийн дутмагшил, эмзэг байдал зэрэг хүний эрхийн зөрчлүүд нөлөөлж байгааг хүлээн зөвшөөржээ.

Дасгал

“Нэгэн хотын түүх” (40 минут)

1. Түүхийг уншаад хувийн дүгнэлтээ хийнэ.
2. Багаараа ажиллаад, багийн нэгдсэн дүгнэлтэд хүрнэ.
3. Бусад багуудын байр суурийг няцаана.
4. Эцэст нь ангийн хэлэлцүүлэг хийгдэнэ.

Тохиолдол судлал – Нэгэн хотын түүх

Нэгэн хотын удирдах зөвлөл Ерөнхий архитекторын газартай зөвлөлдсөний эцэст 1960-аад оны хуучны байшингуудад ойрхон газарт дэлгүүр, бизнес төв, соёлын болон спорт танхим бүхий олон төрлийн үйлчилгээ үзүүлэх цогцолбор барихаар шийджээ. Гадаадын барилгын компани Удирдах зөвлөлийн зохион байгуулсан тендерт ялсан.

Нөхцөл байдлыг зураг төлөвлөгөөг холбогдож лавлах боломжтой хүний харилцах утасны хамт Удирдах зөвлөлийн байранд иргэдийн санал авах зорилгоор зарлалын самбарт сар гаран хугацаанд байрлуулсан. Хотын удирдах зөвлөл, барилгын компани цогцолбор барих гэрээнд гарын үсэг зурж, компани ажлаа заасан талбайд хийж эхэлсэн.

Оршин суугчид цэцэрлэгт хүрээлэнг тойруулан төмөр хашаа босгон, бульдозер модыг газартай тэгшилж эхэлмэгц юу болж байгааг ойлгосон. Ялангуяа өндөр настай оршин суугчид “Амьдрах нөхцөл байдлыг дордууллаа” гэж ихэд уурлан, дуу чимээ, тоос шороо, барилгын талбай дээр ажиллаж буй үл таних гадаад хүмүүсийн эсрэг жагсаал хийжээ. Зарим идэвхтэй оршин суугчид цогцолбор болон гадаадын компани үүнийг барьж байгааг хурцаар шүүмжилж, аян өрнүүлсэн байна. Тэд “Гадаадын компани хотын захирагч, удирдах зөвлөлийн гишүүдийг хахуульдсан” гэсэн цуу тарааж эхэлсэн ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл тэр даруй хов живийг өлгөн авч, нийтэд түгээжээ.

Багаар ажиллах

Оролцогчид доорх багуудад хуваагдаж, дээрх тохиолдлын хүрээнд өөрийн байр суурийг хамгаалж, бусад багуудын эсрэг хэрхэн няцаалт өгөхөө эцэслэн ярилцана:

- Хотын захирагч, хотын удирдах зөвлөлийн гишүүд
- Өндөр настай оршин суугчид
- Тэмцлийн хэлбэрийг сонгосон оршин суугчид
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
- Гадаадын барилгын компанийн төлөөлөл

Багуудын байр суурь

Дээр харуулсан дарааллаар баг бүр өөрийн нэг гишүүнээр байр сууриа дамжуулан илэрхийлнэ. Үүний дараа нэг багаас нэг л асуултыг нэг багт тавина. Асуултын зорилго нь тухайн хариулагч багийн байр суурийг няцаах зорилгыг агуулах бөгөөд өөр нэмж асуулт, тодруулга хийхгүй. Мөн баг асуулт тавьж, хариулж байхад дэргэдээс бусад баг оролцож болохгүй.

Хэлэлцүүлэг

Багш дараах асуултуудыг асууж оролцогчид хариулна.

- Хэн ямар алдаа гаргасан бэ?
- Хүмүүс хэрэгцээндээ анхаарч байр сууриа илэрхийлсэн үү? Эрхээ эдлэхээр зорьж байсан уу?
- Хүний эрхийн зарчмыг удирдлага болгож чадсан уу?
- Эцэст нь хэн хожсон бэ?

Багш дараах дүгнэлтэнд хүрэхэд нь чиглүүлнэ:

- Иргэдийн оролцооноос мэдлэг, чадвар, хандлага хүний амьдралд нөлөөлөх боломжтойг онцолно.
- Эрх агуулагч, үүрэг хүлээгчийг тодорхойлсноор хариуцлага тооцох, шаардлага тавихад хялбар болно.
- Учир дутагдалтай үйлдлийг эрхэд суурилсан хандлагаар засах боломжтой. Ангийн хэлэлцүүлгийн дараа тохиолдлын хариуг хэлнэ.

Олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн дарамтын улмаас Удирдах зөвлөлийн гишүүд нь ялигүй олонхийн саналын дагуу цогцолборын барилгын ажлыг зогсоох шийдвэр гаргасан. Хот энэ асуудлыг олон сарын турш шийдэж чадахгүй байсан тул тухайн компани нь гэрээг цуцалж, хууль ёсны дагуу Удирдах зөвлөлөөс нөхөн төлбөр шаарджээ. Энэ явдлын эцэст уурлаж бухимдсан оршин суугчид, Удирдах зөвлөлийн гишүүд, сүйтгэсэн цэцэрлэгт хүрээлэн, гадаадын компанид их хэмжээний нөхөн төлбөртэй үлджээ. Боломжит хөрөнгө оруулагчдын дунд хотын нэр хүнд олон жилийн турш унасан. Оршин суугчид ялсан боловч бодит амьдрал дээр өөрсдийн орчин тойрныг тохижуулах, хөгжүүлэх нөхцөлийг хаажээ.

Хүний эрхэд суурилсан бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх

• *Эрх хамгаалах хэм хэмжээ болон хөгжих зорилт бүхий хөтөлбөр боловсруулах үйл явцын хооронд ямар холбоо байдаг вэ?*

Олон улсын гэрээгээр баталгаажсан хүний эрхийн хүрээн дэх стандарт, мөн өргөн оролцоо, ялгаварлан гадуурхахгүй байх, тайлагнах зэрэг зарчмуудыг хөтөлбөр боловсруулах бүх шатанд чиглүүлэгчийн үүрэг гүйцэтгэх ёстой. Гэрээний эрх хамгаалах стандарт нь тухайн улс заавал соёрхон баталсан байх шинжийг агуулах бөгөөд хөгжлийн эрэлт дэх хөтөлбөрийн зорилгыг тодорхойлоход тусалдаг. Жишээлбэл, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт болон Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасан хангалттай хоол хүнсээр хангагдах эрхийг хэрэгжүүлэх асуудалд хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хөтөлбөрийн зорилгыг чиглүүлж болно. Хүний эрхийн хүрээн дэх стандартыг удирдлага болгосноор засгийн газрын хөтөлбөр нь хүний эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрх, мөн Иргэний болон улс төрийн

эрхийн тухай олон улсын пактад заасан улс төрийн амьдралд оролцох, шүүн таслах ажиллагааг явуулахтай холбоотой хүний эрхийг хэрэгжүүлэхэд илүү тодорхой дэмжлэг үзүүлдэг. Төрсний дараа бүртгүүлэх эрх (Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 7 дугаар зүйл) нь дурын бусад эрхийг эдлэхэд чухал эрх болохыг харгалзан зарим бүс нутагт ЮНИСЕФ-ийн хөтөлбөр боловсруулахад чухал хэсэг болдог. Хувийн амьдрал халдашгүй дархан байх эрх (Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйл) нь ялгаварлан гадуурхах болон ХДХВ/ДОХ-ын улмаас гадуурхагдах явдлын эсрэг тэмцэхэд хэрэгтэй. Мөн хүний эрхийн гэрээний байгууллагын ерөнхий зөвлөмж, тодорхой улсад өгсөн дүгнэлт зөвлөмж нь хөтөлбөр боловсруулах шат бүрт тодорхой чиглэмж болох боломжтой.

• *Хөтөлбөр боловсруулахад баримтлах тэгш эрх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим гэж юу вэ?*

Бүх хүмүүс хүн төрөлхтний нэг болохын хувьд, төрөхөөс эрхэм зэрэг, нэр төртэй байдгийн хувьд эрх тэгш байна. Бүх хүмүүс арьс, үндэс, хүйс, угсаа гарал, нас, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл, үндэсний болон нийгмийн гарал, хөгжлийн бэрхшээлтэй байдал, хөрөнгө чинээ, төрсөн өдөр, бусад байдлаар ялгаварлагдалгүйгээр өөрийн эрхээ эдэлнэ. Хөгжих зорилт бүхий хөтөлбөр нь нэгэн зэрэг бүх хүмүүсийг хамарч чадахгүй болохоор гадуурхагдсан бүлгийг чухалчлан үздэг.

Хөгжлийн үйл явц нь үндэсний болон орон нутгийн элит буюу шилдэг хэсгийн ашиг сонирхолд захирагдсан шинжтэй бөгөөд хөгжлийн үр шимийг хүртэгч нь нийгмийн цөөн тооны элит бүлэг байх нь түгээмэл. Энэ хүрээнд үндэсний хэмжээний бодлогыг хотын хүмүүс л тодорхойлох, ядуурлыг бууруулах хөтөлбөрийг ядуу хүмүүсийн оролцоогүй боловсруулах зэрэг гажуудлыг дурьдаж болно. Энэ нь нийгэм дэх тэнцвэргүй байдлыг улам гааруулдаг. Мөн санамсаргүй буюу мэдлэггүйгээс үүдэлтэй шууд бус ялгаварлан гадуурхалтаас зайлсхийх ёстой. Тухайлбал, хүмүүсийг алслагдсан нутагт амьдардаг гэсэн шалтгаанаар хүн амын тодорхой бүлгийг хөтөлбөр боловсруулах үйл явцад оролцохоос хасах зэргээр илэрнэ. Хөтөлбөрийг боловсруулах ажиллагаа нь ялгаварлан гадуурхалтын үндсэн болон тогтолцооны гажуудлыг арилгах, бодит тэгш эрхийг хангахад тус болох ёстой. Хөтөлбөрийг боловсруулахад дараах дэлгэрэнгүй төлөвлөгөөг зайлшгүй дагана. Үүнд:

1. Тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ялгаварлан гадуурхалтад өртөж болзошгүй этгээд, нэн ялангуяа ядуу, алслагдсан, хөдөө орон нутагт амьдардаг, үндэстэн, угсаатны цөөнх зэрэг хүмүүст онцгой анхаарал хандуулах,
2. Мэдээлэл цуглуулах, задлан шинжлэх бололцоог нэмэгдүүлэх. Олон талаас задлан шинжилгээ хийж болохуйц мэдээллийг цуглуулахад анхаарах,
3. Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангасан хурал, хэлэлцүүлэг явуулах зэрэг ажлыг төлөвлөх, тогтолцооны шинжтэй ялгаварлан гадуурхалтыг устгах түр зуурын, тусгай арга хэрэгслийг санал болгох,
4. Зохистой хэлбэр, цөөнхийн хэлээр төслийн тухай мэдээллийг түгээх,
5. Мэдээлэл, сурталчилгааны кампанит ажил явуулах, хууль тогтоомжийн шинэчлэлийг хэрэгжүүлэх, ялгаварлан гадуурхалтад өртсөн иргэдийн гомдол гаргаж шийдвэрлүүлэх тогтолцоог (хүний эрхийн үндэсний байгууллага байгуулах зэрэг) бэхжүүлэх, энэ чиглэлээр хүн амыг гэгээрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

• *Хөтөлбөр боловсруулахад баримтлах оролцооны зарчим гэж юу вэ?*

Оролцооны зарчим гэдэг нь холбогдох бүхий л талуудыг хөгжлийн үйл явцад бодитойгоор оролцож, үнэлгээ, задлан шинжилгээ, төлөвлөгөө, хэрэгжүүлэлт, хяналт шалгалт, дүн гаргах

зэрэг хөтөлбөр боловсруулах бүх үе шатанд хяналт тавьж болохыг хэлнэ. Оролцоог бүрэн хангахын тулд НҮБ-ын Хөгжих эрхийн тухай *Тунхаглалд заасан “идэвхтэй, чөлөөтэй, үр бүтээлч оролцооны”* шаардлагад нийцсэн байх ёстой. Тухайлбал, хөдөө орон нутагт амьдарч буй эмэгтэйчүүд бүх түвшний хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох эрхтэй (Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн 14-р зүйл), мөн хүүхдийн санаа бодолд (Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 12-р зүйл) анхаарал хандуулах шаардлагатай. Үүнээс гадна төрийн хэргийг явуулахад оролцох эрх (ИУТЭОУП-ын 25-р зүйл)-ийг баталгаажуулсан байдаг. Идэвхтэй, агуулга бүхий оролцоо бол зөвхөн зорилт төдий бус, мөн хөгжлийн хэрэгсэл болох ёстой. Хөгжлийн бодлогыг боловсруулах явцад гадуурхагдсан бүлгийн иргэдэд өөрийн хүсэл бодлыг илэрхийлэх боломжийг олгох ёстой. Оролцоог нэмэгдүүлэх хүрээнд:

1. Иргэний нийгмийн байгууллагыг санхүүжүүлэх, хөгжих зорилт бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодит оролцоог улам нэмэгдүүлэх,
2. Ил тод байдлыг хүчтэй болгох, зохистой хэлбэрээр, шаардлагатай бол цөөнхийн хэлээр хөтөлбөрийн баримт бичиг, төслийн тухай мэдээллийг түгээх,
3. Маш ядуу, тусгаарлагдсан бүлгийн нийгэм болон соёлын нөхцлийг сайтар харгалзан, оролцоог хангахаар тусгай сувгийг бий болгох. Энэ механизм нь хөтөлбөр боловсруулах бүх үйл явцад бүрэлдэхүүн хэсэг болно,
4. Иргэнийг гэгээрүүлэх, хөгжих зорилт бүхий хөтөлбөрийн нэмэлт хэсэг бус, тулгуур хэсэг болох хүний эрхийн тухай мэдлэгийг дээшлүүлэх,
5. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн кампанит ажлыг явуулах,
6. Орон нутгийн нийгмийн ажилтан – идэвхтэний сүлжээ бий болох бололцоог нэмэгдүүлэх,
7. Адил ашиг сонирхол бүхий иргэний нийгмийн байгууллага, бүлгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, мөн төр, бусад үүрэг хүлээгчийн харилцаанд өөрийн хүслийг илэрхийлэх сувгийг бэхжүүлэх.

• *Нөхцөл байдлын задлан шинжилгээ хийхэд хүний эрх хэрхэн дэмжлэг болдог вэ?*

Хүний эрхийн өнцгөөс харж хийсэн задлан шинжилгээ нь хүчний тэнцвэргүй харьцааг олж харах боломжийг олгоно. Эрх нь зөрчигдсөн бүлэг, эрхийг зөрчигч бүлгийг тодруулснаар ядуурал, эмзэг байдлын үндсэн шалтгааныг мэдэж авах боломжтой. Энэ үүднээс авч үзвэл эрхэд суурилсан хандлага нь институтын ажиллагаанаас гадна эд хөрөнгөгүй, туйлын эмзэг давхаргын учир шалтгаанд нөлөөлдөг улс төр, нийгмийн үйл явцыг судлах хэрэгсэл болдог. Хүний эрхийн хэм хэмжээ дараах гурван түвшинд нөхцөл байдлын задлан шинжилгээг гүнзгий хийхэд тусалдаг. Үүнд:


1. Шалтгаант холбооны задлан шинжилгээ: Хөгжлийн өмнө тулгарч байгаа асуудлын үндсэн шалтгаан, ялгаварлан гадуурхалтад анхаарал хандуулна.
2. Учир холбогдол/үүргийн задлан шинжилгээ: Тодорхой харилцаанд оролцогчдын хүлээх үүргийг тодорхойлоход тусална.
3. Эрх эдлэгчийн бололцоог нэмэгдүүлэх, үүрэг хүлээгчийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад шаардлагатай үйлдлийн шинжийг тодорхойлох

Дасгал.

Тогтолцоог нэгтгэн тайлбарлах

Чиглэл: Тайлбараа хийсний дараа оролцогчдыг багт хуваан “buzz” буюу маш хурдан хугацаанд хүснэгтэд орсон мэдээллийг сануулах зорилгоор баг бүрээс нэг гишүүнээр урьж яриулна.

ТОГТОЛЦООГ НЭГТГЭХ НЬ АРГАЧЛАЛ



Хүний эрхийн соёлыг бий болгох нь аливаа хүний эрхийн үйл хэргийн зорилго билээ. Өөрийн хүний эрхийн үйл хэрэг, ялангуяа хүний эрхийн боловсролын хичээл зүтгэлийн тогтолцооны хандлагаар дамжуулан шалгаснаар өөрийн үйл хэргийн чанар, үр нөлөөт байдал болон нөөц баялгийн бүтээмжит хэрэглээг мэдэгдэхүйц байдлаар нэмэгдүүлэхэд ашиглаж болно. Мөн тулгарах бэрхшээлийг нарийн тодорхой болгох, хүний эрхийн үнэт зүйлстэйгээ зэрэгцүүлэн нийгмийн өөрчлөлтөд оруулах хувь нэмрээ үнэлэх боломжтой.

Хүний эрхийн боловсрол бол хүсч байгаа нийгмийн-улс төрийн өөрчлөлтөд хүргэх тухай улс эсвэл нутаг дахь одоогийн хүний эрхийн нөхцөл байдалд чиглэх боломжит арга хэмжээний нэг юм.

ХАВСРАЛТУУД

ХӨГЖЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА НҮБ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН НИЙТЛЭГ ОЙЛГОЛЦОЛ РУУ¹²

Удиртгал

Нэгдсэн үндэстний байгууллага нь хүний эрх, эрх чөлөө, энх тайван, шударга ёсны зарчмууд дээр үндэслэн байгуулагдсан билээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүний эрх бол эрх чөлөө, шударга ёс, энх тайвны үндэс суурь хэмээн тунхагласан байдаг. Венийн тунхаглал болон үйл ажиллагааны хөтөлбөрт ардчилал, хөгжил, хүний эрх болон эрх чөлөө нь харилцан хамааралтай бөгөөд харилцан бие биенийгээ нөхцөлдүүлдэг тухай авч үзсэн байдаг.

Нэгдсэн үндэстний байгууллага 1997 онд Шинэчлэлийн хөтөлбөр хэрэгжүүлж, НҮБ-ын тогтолцооны бүх байгууллагууд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, үйл ажиллагаандаа хүний эрхийн хэм хэмжээг тусган нийцүүлэхийг Ерөнхий нарийн бичгийн дарга уриалсан юм. Түүнээс үндэслэн олон тооны НҮБ-ын байгууллагууд хөгжлийн хамтын ажиллагаандаа хүний эрхэд суурилсан хандлагыг боловсруулан хэрэглэж, улмаар тогтолцооны нэгэн бүрэлдэхүүн хэсэг болгох талаар ихээхэн туршлага хуримтлуулсан байна. Гэхдээ байгууллага бүр уг хандлагыг, мөн үйл ажиллагаандаа хэрхэн нэвтрүүлэх талаар өөрөөр тайлбарладаг. Тиймээс НҮБ-ын байгууллага хоорондын хамтын ажиллагаа нь дэлхийн болон бүс нутгийн түвшинд, мөн улс үндэстний түвшинд Улс орны нийтлэг үнэлгээ (ССА), НҮБ-ын Хөгжлийн тусламжийн цар хүрээ (UNDAF)-г боловсруулан, хөгжлийн бодлого хөтөлбөрт тусгах талаар нийтлэг ойлголт бий болгосон юм.

2005 оны 5 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд НҮБ-ын Шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд Хүний эрхэд суурилсан хандлага сэдвээр байгууллага хоорондын семинар зохион байгуулж, хүний эрхэд суурилсан хандлагын талаар НҮБ-ын байгууллагуудын бодлого болон практикт нийтлэг ойлголт бий болгохыг оролдсон байна. Энэхүү Нийтлэг ойлголцлын мэдэгдэл нь НҮБ-ын байгууллагуудын хөгжлийн хөтөлбөр болон хөгжлийн хамтын ажиллагаан дахь хүний эрхэд суурилсан хандлагын талаар тусгасан болно.

Нийтлэг ойлголцол

1. Хөгжлийн хамтын ажиллагааны бүхий л бодлого, хөтөлбөр, техникийн туслалцаа нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хүний эрхийн олон улсын бусад баримт бичгүүдэд заасан хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэгдэх ёстой.
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хүний эрхийн олон улсын бусад баримт бичгүүдэд заасан хүний эрхийн хэм хэмжээ, зарчмууд нь бүх салбар дахь хөгжлийн хамтын ажиллагаа, хөтөлбөр төлөвлөлтийн үйл явцын гол чиглүүлэгч хандлага байна.
3. Хөгжлийн хамтын ажиллагаа нь эрх эдлэгч өөрсдийн эрх, эрх чөлөөгөө эдлэх болон үүрэг хүлээгчид түүнд холбогдох үүрэг хариуцлагаа биелүүлэх чадавхийг бүрдүүлэхэд чиглэнэ.

1. **Хөгжлийн хамтын ажиллагааны бүхий л бодлого, хөтөлбөр, техникийн туслалцаа нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хүний эрхийн олон улсын бусад баримт бичгүүдэд заасан хүний эрхийг хангах, хамгаалахад чиглэгдэх ёстой.**

Хөтөлбөр төлөвлөлтийн үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хангахад хувь нэмрээ оруулах тул аливаа хөтөлбөрүүдэд хүний эрхэд суурилсан хандлагыг нэгтгэж өгөх шаардлагатай. Хөгжлийн хамтын ажиллагаа болон хөтөлбөр дэх хүний эрхэд суурилсан хандлага, түүнтэй

¹² Attachment 1, Report by 'The Second Interagency Workshop on Implementing a Human Rights-based Approach in the Context of UN Reform', Stamford, USA, 5–7 May 2003.

холбогдох бүх үйл ажиллагааны зорилго нь нэг буюу хэд хэдэн хүний эрхийг хэрэгжүүлэхэд шууд хувь нэмрээ оруулах ёстой.

2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон хүний эрхийн олон улсын бусад баримт бичгүүдэд заасан хүний эрхийн хэм хэмжээ, зарчмууд нь бүх салбар дахь хөгжлийн хамтын ажиллагаа, хөтөлбөр төлөвлөлтийн үйл явцын чиглүүлэгч хандлага байна.

Эрүүл мэнд, боловсрол, засаглал, хүнс тэжээл, ус болон эрүүл ахуй, ДОХ\ХДХВ, ажил эрхлэлт болон хөдөлмөрийн зохицуулалт, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдал зэрэг бүх салбарын хөтөлбөр төлөвлөлтийг хүний эрхийн зарчмуудад нийцүүлнэ. Бүхий л хөгжлийн хамтын ажиллагаа нь Мянганы тунхаглал болон Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Мөн Улс орны нийтлэг үнэлгээ (ССА), НҮБ-ын Хөгжлийн тусламжийн цар хүрээ (UNDAF)-г боловсруулахад дээр дурдсан хүний эрхийн зарчмуудыг удирдлага болгон баримтална.

Хүний эрхийн зарчмуудыг хөтөлбөр төлөвлөлтийн бүх үе шатанд тухайлбал хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах (зорилго, зорилтууд, стратегийг тодорхойлох), хэрэгжүүлэх, хяналт тавих болон үнэлгээ хийх зэрэгт баримтална.

Хүний эрхийн суурь зарчмууд нь түгээмэл, салшгүй байх, хуваагдашгүй байх, харилцан хамааралтай байх, ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх, оролцоог хангах, тэгш хамруулах, хуулийг дээдлэх, хариуцлагатай байх зарчим зэрэг болно. Эдгээр зарчмуудыг тус бүрд нь авч үзвэл:

- Түгээмэл, салшгүй байх зарчим

Хүний эрх нь түгээмэл бөгөөд салшгүй байна. Дэлхийн аль ч улс орон, бүс нутагт амьдарч байгаа хүн бүрт хүний эрх заяасан юм. Тиймээс хүний эрхийг тухайн хүнд сайн дураар өгөх болон түүнээс салгаж болохгүй юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэгдүгээр зүйлд “Хүн бүр төрж мэндлэхдээ эрх чөлөөтэй, адилхан нэр төртэй, ижил эрхтэй” хэмээн тунхагласан байдаг.

- Хуваагдашгүй байх зарчим

Хүний бүхий л эрхүүд хуваагдашгүй байна. Өөрөөр хэлбэл иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг, соёлын эрхүүд нь хүн бүрийн эрхэм зэргээс салшгүй, нэгдмэл байна. Үүний хамт тэдгээр нь хүний эрх болохынхоо хувьд адил тэгш статустай бөгөөд ач холбогдлын хувьд зэрэг дэв тогтоох, нэгийг нөгөөгөөс нь чухалчлах шаардлагагүй юм.

- Харилцан хамааралтай байх зарчим

Хүний аль нэг эрхийг хэрэгжүүлэх нь бусад эрхийг хэрхэн хангаж байгаагаас бүхэлдээ буюу хэсэгчлэн шалтгаалдаг. Тухайлбал хүний эрүүл байх эрхийг хангах нь тухайн хүний сурч боловсрох, мэдээлэлтэй байх зэрэг эрхийг хангах үндсэн нөхцөл болж өгнө.

- Ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх зарчим

Хүн бүр өөрийн эрхэм зэрэг, мөн чанарынхаа хувьд адил тэгш заяасан тул арьс үндэс, нас, хүйс, хэл соёл, итгэл үнэмшил, улс төрийн болон бусад үзэл бодол, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, өмч хөрөнгө, төрсний болон бусад статус, эсвэл нийгмийн анги давхраа зэрэг ямар нэгэн байдлаар алагчлан үзэх, ялгаварлан гадуурхахгүй байх эрхтэй. Тиймээс олон улсын хүний эрхийн гэрээнд заасанчлан ямар нэгэн ялгаа бүхий байдлаас үл хамааран хүн бүрт хүндэтгэлтэй хандах ёстой.

- Оролцоог хангах, тэгш хамруулах зарчим

Хүн бүр хүний эрх, эрх чөлөө нь хангагдаж буй иргэний, улс төрийн, нийгэм, эдийн засаг,

соёлын бүх орчинд адил тэгш, зорилго чиглэлтэй, идэвхитэй оролцох, хувь нэмрээ оруулах, түүний үр шимийг хүртэх боломжтой байна.

- *Хуулийг дээдлэх, хариуцлагатай байх зарчим*

Хүний эрхийг хангах, хамгаалах талаар төр болон бусад үүрэг хүлээгчид олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээдэг. Үүрэг хүлээгчдийн хувьд хүний эрхийн зарчим, үзэл санаанд тухайн орны хууль эрх зүйн хэм хэмжээ, стандартыг нийцүүлэх шаардлагатай. Хэрвээ энэхүү үүргийг биелүүлээгүй бол эрх эдлэгчдийн зүгээс эрхээ эдлэх нөхцөл бололцоогоор хангуулахын тулд хуулиар оногдсон дүрэм журам, зааврын дагуу зохих шүүхэд хандан эрхээ сэргээн эдлэх эрхтэй байна.

3. Хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүд нь эрх эдлэгч өөрсдийн эрх, эрх чөлөөгөө эдлэх болон үүрэг хүлээгчид өөрийн холбогдох үүрэг хариуцлагаа биелүүлэх чадавхийг бүрдүүлэх, түүнд хувь нэмэр оруулахад чиглэнэ.

Хүний эрхэд суурилсан хөгжих хандлагад хүний эрх нь эрх эдлэгч буюу хувь хүмүүс болон бүлгүүд, нөгөө талаас үүрэг хүлээгчид буюу төр болон төрийн бус оролцогчдын хоорондын харилцааг онцлон авч үздэг. Эрх эдлэгчдийн хувьд өөрсдийн эрхээ эдлэх, түүнийг шаардах, харин үүрэг хүлээгчдийн зүгээс өөрт ногдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхэд шаардлагатай чадавхийг бэхжүүлэх, бололцоог өргөтгөхөд чиглэнэ.

НҮБ-ЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮДЭД ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ХАНДЛАГА ТУСГАГДСАН БАЙДАЛ

Хүний эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэхэд үр дүнтэй, сайн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх практикийг хэрэглэх шаардлагатай болохыг туршлага харуулдаг. Үр дүнтэй, сайн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх нь дан ганц хүний эрхэд суурилсан хандлагыг баримтлах бус нэмэлт бүрэлдэхүүн хэсгүүдтэй байдаг. Хүний эрхэд суурилсан хандлагыг нэвтрүүлэхэд шаардлагатай тэдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь:

- a) Эрх эдлэгчид эрхээ эдлэх, үүрэг хүлээгчид өөрт ногдсон үүрэг хариуцлагаа биелүүлэх чадавхид дүн шинжилгээ, үнэлгээ хийж, хүний эрх хэрэгжихгүй байгаа үндсэн шалтгааныг тодорхойлно.
- b) Эрх эдлэгчид эрхээ эдлэх, үүрэг хүлээгчид өөрт ногдсон үүрэг хариуцлагаа биелүүлэхэд тухайн хөтөлбөрийн зохицол, хүртээмж зохистой байх шаардлагатай бөгөөд тэрхүү чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн стратеги боловсруулна.
- c) Хөтөлбөрүүдийн зүгээс хүний эрхийн зарчим, стандартуудад үндэслэн хэрэгжиж байгаа үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүнд хяналт тавих, үнэлгээ хийнэ.
- d) Хөтөлбөрүүд нь олон улсын хүний эрхийн гэрээний байгууллагууд, тогтолцооноос зөвлөмж авч, тусган хэрэгжүүлнэ.

Хүний эрхэд суурилсан хандлага бүхий үр дүнтэй, сайн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд мөн дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Хүмүүс нь хөгжлийн үйлчилгээг хүртэгч, идэвхигүй хүлээн авагч бус харин хөгжлийнхөө хувьд гол оролцогч хэмээн хандах
2. Оролцоо нь зорилго болон арга хэрэгсэл болох

3. Гэгээрүүлэх, мэдээлэл олгоход чиглэсэн стратегиудыг баримтлах
4. Үр дүн болон үйл явцад хоёуланд нь хяналт тавих, үнэлгээ хийх
5. Бүр оролцогчдод дүн шинжилгээ хийх
6. Хөтөлбөрүүд нь нийгмээс тусгаарлагдсан, хязгаарлагдсан эмзэг бүлгийнхэнд илүү чиглэх
7. Хөгжлийн үйл явцад орон нутгийнхныг түлхүү оролцуулах
8. Хөтөлбөрүүд нь ялгавартай байдлыг бууруулахад чиглэх
9. Дээрээс доош болон доороос дээш хандлагуудыг нэгэн зэрэг хэрэглэх
10. Хөгжилд саад болж буй үндсэн шалтгаануудыг тодорхойлох нөхцөл байдлын шинжилгээ хийх
11. Хөтөлбөр боловсруулахад хэмжигдэхүйц зорилго, тодорхой зорилтот бүлэгт чиглэх
12. Стратегийн түншлэлийг бий болгох, тогтворжуулах
13. Хөтөлбөрүүд нь бүх оролцогчдын хариуцлагатай байдлыг дэмжих

**Монгол Улсын
Хүний эрхийн Үндэсний Комисс**

Тусгаар тогтнолын талбай,
Засгийн газрын XI байр, Ү давхар

Утас: 262786, 262902,
Факс: 976-51-262786
Хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 70000222

Цахим хаяг: www.mn-nhrc.org,
Цахим шуудан: info@mn-nhrc.org
www.facebook.com/nhrcom

Тогтвортой бичил уурхай төсөл

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Олимпийн гудамж 12 “Скай Плаза”
бизнес центр 2-р давхар
ш/х 58, Улаанбаатар 210648
Зип код 14210 Монгол Улс

Утас: +976 11 328848
Факс: +976 11 322415

Цахим хаяг: www.sam.mn
www.swiss-cooperation.admin.ch/mongolia/

